

ISSN 2521-1501

МӨНГӨ · САНХҮҮ · БАЯЛАГ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

MONEY, FINANCE, WEALTH

2018 №09

Иргэн баян бол улс баян

МӨНГӨ · САНХҮҮ · БАЯЛАГ

Сэтгүүлийн зөвлөлийн дарга

Н.Баяртсайхан (Ph.D.)

Сэтгүүлийн эрхлэгч

Б.Болдбаатар (D.Sc.)

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд

Б.Баярдаваа

Ж.Ганбаатар (Ph.D.)

А.Ганбат (Ph.D.), *Сэтгүүлийн зөвлөлийн
нарийн бичгийн дарга*

Д.Ган-Очир (Ph.D.)

Л.Даваажаргал (Ph.D.)

Т.Мөнгөнсүвд

Н.Ургамалсүвд

Энэхүү сэтгүүлд дурдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд сэтгүүлийн зөвлөлийн байр суурийг илэрхийлэхгүй. Сэтгүүлд хэвлэгдсэн холбогдох байгууллагын шийдвэр, зөвлөмж, дүгнэлт болон эрдэмтэн, судлаачийн бүтээл нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн оюуны өмчийн эрхийн тухай хууль тогтоомжоор хамгаалагдсан болно.

“Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл

Монголбанк Д байр,

Бага тойруу-3, Улаанбаатар-46

Монгол Улс, 15160

Утас: 976-11-451565

Факс: 976-11-311471

Цахим шуудан: money.finance.wealth@gmail.com

journal@mongolbank.mn

*Улс баян бол иргэн баян,
Иргэн баян бол улс баян*

МӨНГӨ . САНХҮҮ . БАЯЛАГ

Дугаар №09

Агуулга

“Их өр”-ийн асуудлыг шийдвэрлэсэн нь

Н.Баяртсайхан • 4

**Особенности развития экономики Монголии в XX в.
и погашение большого долга**

Ч.Улаан • 18

**Улстөрийн эдийн засгийн ухаан: орчин үеийн
мөнгө, санхүүгийн диалектик**

Самаруха В.И., Б.Даш-Ёндон, Самаруха И.В. • 35

**Актуальные вопросы Монголо-Российских торговых
отношений на современном этапе**

Д.Моломжамц • 48

Монгол Улс, ОХУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдал

Н.Отгонсайхан • 58

**Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын Оросын
Холбооны Улс дахь хэрэглээний асуудалд**

Сорокина Е.М., А.Өнөржаргал • 71

Хүрээлэн буй орчны эдийн засгийн бүртгэлийн асуудалд

Р.Бадамханд • 77

Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын гэрээний асуудалд

Э.Бямбажав • 84

**Монгол Улсын худалдааны салбарын түүхэн хөгжлийн товч тойм,
тулгамдаж буй асуудлууд**

Л.Дамбадорж • 96

Монгол Улсыг инновацийн чиг хандлагаар хөгжүүлэх асуудалд

Л.Оюунцэцэг • 102

**Монгол Улсын Төвийн бүсийн нэгдсэн системийн
үр ашгийг нэмэгдүүлэх боломж**

Б.Батзаяа • 116

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

“ИХ ӨР”-ИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

Н.Баяртсайхан¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
E58, F02, F34, F35, H63	Энэхүү илтгэлд БНМАУ, ЗСБНХУ болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын зээл, техникийн туслалцаа, төлбөрийн асуудлыг судалж, “Их өр”, үүссэн түүх, бүтээн байгуулалт, их өрийг шийдвэрлэсэн тухай авч үзээд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 оны Улаанбаатарт хийсэн дээд хэмжээний айлчлалын үеэр тохиролцсон өр зохицуулах зарчмууд нь “Их өр”-ийг тэглэх үндэс суурь болж, Монгол Улс, ОХУ-ын Ерөнхий сайд нарын Москвад 2003 онд хийсэн уулзалтын үр дүнд “Их өр”-ийг 96-аас доошгүй хувиар чөлөөлж буюу үлдсэн хэсгийг 300 сая ам.доллараар төлөх түүхэн тохиролцоонд хүрсэн байна гэдгийг онцлон тэмдэглэжээ.
<i>Түлхүүр үг:</i>	
Их өр, БНМАУ, ЗХУ, Монгол Улс, ОХУ, өр, зээл, техникийн туслалцаа, буцалтгүй тусламж, төлбөр	Олон улсын банк, санхүүгийн байгууллагад хэрэглэдэг аргачлал, шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан өрийн тооцоо, судалгааг гаргаж, өрийг худалдах, худалдан авах зарчмаар ОХУ, Монгол Улсын Сангийн сайд нар эцэслэн “Их өр”-ийг 250 сая ам.доллараар тэглэсэн нь Монгол Улс, Оросын Холбооны Улсын онцгой харилцааг бэхжүүлэх чухал алхам болжээ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

1. Удиртгал

Монгол-Оросын 1912 оны арваннэгдүгээр сарын 3-ны өдрийн гэрээ бичиг; Орос, Монголын хооронд найрамдал байгуулах тухай Зөвлөлийн Засагт Орос Улсын Засгийн газраас Монгол Ардын Засгийн газар лугаа хэлэлцэн тогтсон 1921 оны арваннэгдүгээр сарын 5-ны өдрийн гэрээ бичиг, Хаант засгийн концесс болон эдийн засгийн давуу нөхцлөөс ЗСБНХОУ-ын Засгийн газар татгалзсан тухай нэмэлт протокол; БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зүйлүүдийг батлан тогтоосон 1929 оны зургаадугаар сарын 28-ны өдрийн гэрээ бичиг; Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны нэгдүгээр сарын 20-ны өдрийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд БНМАУ, ЗСБНХУ болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын зээл, техникийн туслалцаа, төлбөрийн асуудлыг судлахыг зорилоо.

Их өрийн талаар судалгааны өргөн материал байгаа ч зах зээлийн харилцаанд шилжсэн шилжилтийн үе (1991-2018 он)-ийн өр, зээл, төлбөрийн байдалтай харьцуулан нарийвчлан судлах шаардлага тулгарч байна.

Төсөв болон төсөвтэй адилтгах хэт тэлсэн зарцуулалтын хэрэгцээг хангахын тулд улсын байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаас татсан санхүүжилт, гадаад өрийн нийт хэмжээ 2011-2016 онд ДНБ-ий 30 хувиас 67 хувь хүртэл огцом тэлж, өрийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангахуйц

¹ Эдийн засгийн ухааны доктор, профессор, Монголбанкны ерөнхийлөгч.
Цахим шуудан: telmen@mongolbank.mn

зохистой түвшнээс давсан төдийгүй үүнийг дагаад зээлийн үйлчилгээний хүүний төлбөрийн дарамт өсч, төсвийн тэнцвэргүй байдлыг үүсгэж, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгосон байна.

Засгийн газрын гадаад өр 2017 оны байдлаар ДНБ-ий 65.7 хувиар хэмжигдэж байгаа ч Хөгжлийн банк, Төв банкны өр, төлбөрийг хамруулан улсын нийт гадаад өрийг тооцвол ДНБ-ий 90.6 хувьтай тэнцэж байна.²

Засгийн газрын гадаад өрийн богино хугацаанд хүлээгдэж байсан эргэн төлөлтийн хугацааг сунган шийдвэрлэсэн ч дунд хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангахуйц хэмжээнээс хэтэрсэн хэвээр хадгалагдахаар хүлээгдэж байна.³ Мөн Засгийн газрын өрийн бүтцэд гадаад өрийн эзлэх жин сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн төдийгүй үүнийг дагаад зээлийн үйлчилгээний төлбөр⁴ төсвийн зардалд томоохон хувийг эзэлж байна.

Манай орны нийт гадаад өрийн хэмжээ 2017 оны эцсийн байдлаар 27.4 тэрбум ам.доллар байгаа нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн албан ханшаар 66,5 их наяд орчим төгрөг байна. Энэ нь манай орны 2017 оны ДНБ-ээс 2,45 дахин их өр байна гэсэн үг юм. Нийт өр 2010 оноос хойш 3,85 дахин өссөн бөгөөд 9.3 тэрбум ам.доллар нь Засгийн газар, Төв банкны өр байгаа ажээ [18].

Засгийн газрын нийт өр, түүний дотор гадаад өрийн хэмжээ жил тутам нэмэгдсээр 7.4 тэрбум ам.долларт хүрсэн боловч Засгийн газрын гадаад өрийн 2017 оны өсөлт нь “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд донороос авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилтээр бий болж байгааг зарим судлаачид онцлон тэмдэглэдэг [19].

Иймд “Их өр”-ийн үүссэн түүх, бүтээн байгуулалт, шийдвэрлэсэн байдлыг харьцуулан үзвэл нэлээд сонирхолтой баримт гарч ирэх учиртай юм.

Хаант Орос улс, автономит Монгол Улсын зээлийн асуудал

1911 онд Монгол Улсад үндэсний хувьсгал гарч, тусгаар тогтнолоо сэргээн зарлаж, Монгол Улсын шашин, төрийг хослон баригч хаанаар VIII Богд Жавзандамба хутагтыг 1911 оны арванхоёрдугаар сарын 29-ий өдөр ёслол төгөлдөр өргөмжилсөн билээ.

Төрөө төвхнүүлэхийн тулд юуны түрүүнд Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхэд олон улсын түвшинд ажиллах, үүнтэй холбогдуулан хаант Оросын Засгийн газарт хандаж, цэрэг, эдийн засгийн тусламж хүсэх улс төрийн ажлаа эхэлсэн байдаг.

1913 оны улсын төсвийг үзвэл, орлого 757418 рубль болж, түүний 60 гаруй хувь нь татвар хураамж, 15 хувь нь түрээсийн төлбөр, 5 орчим хувь нь алтны уурхайн орлогоос бүрдэж байжээ. Засгийн газрын төсөв нь алдагдалтай

² Төсвийн тогтвортой байдлыг хангахуйц Улсын өрийн хэмжээг хөгжингүй орны хувьд ДНБ-ий 60 хувь, хөгжиж буй орнуудын хувьд ДНБ-ий 40 хувьтай тэнцэнэ гэж үздэг [19].

³ Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр 2018-2022 онд төлөгдөх өр, төлбөрийг хугацаанд нь бүтнээр эргүүлэн төлнө гэж авч үзэхэд улсын нийт гадаад өр 2019 онд ДНБ-ий 94 хувь хүртэл өссөний дараа алгуур буурч 2022 онд ДНБ-ий 70 хувьтай тэнцэхээр хүлээгдэж байна [19].

⁴ 2017 онд тэнцвэржүүлсэн орлогын 16 хувьтай тэнцэж байсан [19].

байсан бөгөөд түүнийг гадаадын зээл, гол төлөв хаант Оросын Засгийн газраас авсан зээлээр нөхөж байжээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Намнансүрэн хаант Орос улсад 1913 онд хийсэн албан ёсны айлчлалын үеэр хийгдсэн хэлэлцээрт хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал онцгой байр суурь эзэлж байсан ажээ. Манай Засгийн газрын хүсэлтийн дагуу хаант Оросын Засгийн газраас 3 сая рублийн зээл олгохоор шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 2 сая рублийг 1913 оны нэгдүгээр сард хүлээн авчээ [17].

Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд 1923 оны 6 дугаар сард байгуулагдсан Худалдааны анхны Хэлэлцээрийн үндсэн дээр Зөвлөлт Орос улсаас машин, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний болон хүнсний бараа худалдан авч, манай орны малын мах, арьс шир, ангийн үс, бусад түүхий эд, материалыг нийлүүлж байжээ.

Мөн ЗХУ-аас манай орны эдийн засгийг хөгжүүлэхэд зориулж зээл, тусламжийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгож эхэлсэн нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр болж байжээ.

1924 онд Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулсан нь үндэсний санхүү, мөнгөний тогтолцоог үүсгэн бүрдүүлэх, гадаадын капиталын үйл ажиллагааг хязгаарлах, ялангуяа хөдөө аж ахуй, улс ардын аж ахуйн бусад салбарыг хөгжүүлэхэд үлэмж ач холбогдолтой болжээ.

БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд 4 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгох тухай Хэлэлцээрийг 1932 онд байгуулжээ.

2. Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн хамтын ажиллагааны өрнөлт, бүтээн байгуулалт (1960-1990 он)

Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах тухай, зээл, тусламжийн талаар манай хоёр орны Засгийн газар хоорондын 1960-1990 онд байгуулсан 8 удаагийн үндсэн Хэлэлцээр, 4 удаагийн Протоколын дагуу нийт 6775 сая шилжих рублийн удаан хугацааны хөнгөлөлттэй зээлийг авч, XX зууны бүтээн байгуулалтын их ажлыг өрнүүлсэн байна.

1960-1990 онд 879 объектыг барихад зориулж, 6702,7 сая шилжих рубль, 72,4 сая ам.долларын зээл авсан байдаг [10].

Л.И.Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид Монгол Улсад айлчлах үеэр БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан зөвлөлтийн ард түмний бэлэг болгож, хэд хэдэн барилга, байгууламж байгуулах Хэлэлцээрт 1974 оны 11 дүгээр сарын 27-нд гарын үсэг зуржээ.

Улаанбаатар хотод 140 мянган м² талбай бүхий угсармал орон сууц үйлдвэрлэх Байшин үйлдвэрлэх комбинат, Гэрлэх ёслолын ордон, Дорнод, Хөвсгөл аймгийн төвд 50 ортой иж бүрэн эмнэлэг, Архангай, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай аймгийн төвд тус бүр 964 хүүхдийн сургууль, багш нарын орон сууц, Дархан хотод 70 мянган м² талбай бүхий угсармал орон

сууц үйлдвэрлэх Байшин үйлдвэрлэх комбинат, Цэрэг, батлан хамгаалахын төв сургууль, Гэмтлийн эмнэлэг зэрэг олон тооны барилга байгууламжийг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Зөвлөлтийн барилгын байгууллагын хүчээр барьж өгсөн билээ.

2.1. Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр

Монголын Улсын эдийн засагт сүүлийн 40 жилд гол түшиг болж байгаа Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийг байгуулах, ашиглахтай холбогдсон асуудлыг боловсруулах, шийдвэрлэх асуудал нь БНМАУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн 1970 оны аравдугаар сард ЗХУ-д албан ёсны айлчлалын үеэр яриа хэлэлцээрийн нэг гол сэдэв байсан бөгөөд хэлэлцээрийн явцад Эрдэнэтийн зэс, молибдены ордыг хамтран ашиглах талаар урьдчилсан тохиролцоонд хүрч чадсан байна.

Түүх сөхвөл, Эрдэнэт үйлдвэр, хотын барилга, байгууламжийг барихад 1974 оны гадаад худалдааны үнээр 595 сая рубль, үүний дотор Эрдэнэт үйлдвэрийг барихад 408 сая рубль (*1,72 орчим тэрбум төгрөг*), үйлдвэрлэлийн бааз барихад 92 сая рубль, иргэний орон сууц, иргэний барилгад 95 сая рубль зарцуулахаар төлөвлөж байсан бол нийт 589 сая рубль зарцуулж, дээрх объектуудыг барьж байгуулжээ. Түүнээс гадна энэ хөрөнгөөр Галуут нуурын цахилгаан станцаас Монголын хил-Дархан-Эрдэнэтэд орж ирэх 220 кВт-ийн 407 км дамжуулах шугам, Дархан-Эрдэнэтийн автомашины 180 км зам, Салхит-Эрдэнэтийн 167,5 км төмөр зам болон олон барилга, байгууламжийг “Эрдэнэт үйлдвэр”-ийн цогцолборын хүрээнд барьж ашиглалтанд өгч байжээ [15].

Монгол-Зөвлөлтийн 1976 оны тавдугаар сарын 27-ны өдрийн хэлэлцээрийн дагуу 230 сая рублийг Монголын хувь хөрөнгөнд, үүний дотроос 210 сая рублийг Монгол-Зөвлөлтийн уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн Монголын хувь хөрөнгөд зориулан жилийн хоёр хувийн хүүтэйгээр олгож байсныг архивын материалаас харж болно.

1978 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Ю.Цэдэнбал оролцсон эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Зөвлөлтийн Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаар жилд 4 сая тонн хүдэр олборлож, боловсруулах хүчин чадал бүхий Эрдэнэт үйлдвэрийн эхний ээлжийг ашиглалтанд хүлээн авах тухай баримт бичгүүдэд гарын үсэг зурж, Монгол Улсад өнгөт төмөрлөгийн үйлдвэрийн анхдагч болох уул уурхайн баяжуулах том цогцолбор ашиглалтанд орсон юм. Үйлдвэр байгуулагдаж, бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн эхний 8 жилд экспортын жилийн дундаж орлого 117 сая рубль, ашиг 60 сая рубль болж, үйлдвэрийн зориулалт бүхий анхны хөрөнгө оруулалтаа бүрэн нөхсөн байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 оны 11 дүгээр сард Монгол Улсад хийсэн айлчлал болон 2002 оны гуравдугаар сард Засгийн газрын тэргүүнүүдийн түвшинд хийсэн хэлэлцээний үеэр тохиролцсон ерөнхий зарчмыг удирдлага болгон манай орны Санхүү, эдийн засгийн яам, Үйлдвэр, худалдааны яам Эрдэнэтийн хэлэлцээрийн асуудлаар эдийн засгийн суурь тоо, аргачлалыг

тохиролцохын тулд олон хувилбараар судалгаа, тооцоо хийж, Монголын талын байр суурийг илэрхийлж, батлах зэргээр өргөн хүрээтэй хэлэлцээг өрнүүлсэн байна.

ОХУ-ын Засгийн газрын даргын М.М.Касьяновын урилгаар Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, ОХУ-ын Үйлдвэр, шинжлэх ухаан, технологийн яамны сайд С.Р.Митин нар Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2003 оны 7 дугаар сарын 1-нд Москва хотноо гарын үсэг зурсан билээ.

Эрдэнэт үйлдвэр өнгөрсөн 40 жилийн хугацаанд нийт 17,2 сая тонн зэсийн баяжмал, 4,7 сая тонн зэсийн баяжмал дахь цэвэр зэс үйлдвэрлэн, 13.8 тэрбум ам.долларын орлого олж, улсын болон орон нутгийн төсөвт нийт 4,6 тэрбум ам. доллар төвлөрүүлж, 2,2 тэрбум ам. долларын цэвэр ашигтай ажилласан байна.

3. “Их өр”-ийн асуудлыг хэлэлцэж эхэлсэн нь

Монгол Улсын ЗХУ-аас авч ашигласан зээлийн өр төлбөрийн асуудлаар Зөвлөлтийн талтай албан ёсоор хэлэлцээ хийх Засгийн газрын төлөөлөгчдийг томилж, Монгол Улсын сайд, Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны тэргүүн дэд дарга Т.Намжим ахалж, 1988-1989 он, 1990 оны 2 дугаар сар хүртэлх хугацаанд албан ёсны түвшинд хэд хэдэн удаа уулзалт хэлэлцээр хийж байсан боловч 1990 оны гуравдугаар сард төр, засаг солигдсоноор эхний шатны уулзалт хэлэлцээ тодорхой үр дүнд хүрээгүй ажээ.

Гэхдээ Монгол Улсын хуучин ЗХУ-аас авсан нийт зээлийн хэмжээг үндсэн зээл, бодогдсон хүүний хамт хоёр улсын хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 1991 оны нэгдүгээр сарын 1-ний байдлаар бараг 10,5 тэрбум шилжих рубль⁵ гэж талуудын холбогдох байгууллагын хооронд тооцоо нийлсэн байжээ. Түүний дотор 1961 оноос өмнө авсан зээл 226 сая рубль байснаас хоёр улсын хувь нийлүүлсэн төмөр замыг барихад болон 1950-иад оны сүүлээр татан буугдсан “Совмонголметалл” нийгэмлэгийн анх байгуулахад авсан зээлийн үлдэгдэл 144 сая рубль байжээ [14].

Зээлийн нийт дүнд 1975 оноос хойш авч ашигласан зээл 81 хувийг эзэлж, зээлийг бүтцээр нь үзэхэд хөрөнгө оруулалтын зориулалттай зээл 66,3 хувь, гадаад худалдааны тэнцлийг хангахад авсан зээл 33,6 хувийг тус тус эзэлж байжээ.

Хөрөнгө оруулалтын зориулалттай зээлийн бүтцийг салбараар үзэхэд:

- | | |
|--|------------|
| • хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарт | 18,4 хувь; |
| • түлш, эрчим хүчний салбарт | 20,5 хувь; |
| • тээвэр, холбоо, барилга, материал-хангамжийн салбарт | 18,0 хувь; |

⁵ Харин ОХУ-ын “Известия” сонины 1990 оны гуравдугаар сарын 2-ны өдрийн № 61 [22964] дугаарт хэвлэгдсэн ЗСБНХУ-ын Сангийн орлогч сайд В.Г.Пансковын албан ёсны мэдээнд 1989 оны нэгдүгээр сарын 1-ний байдлаар Монгол Улсын нийт өр 9542,7, үүнээс үндсэн өр 8981,3 рубль хэмээн дурджээ.

- орон сууц, нийтийн аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт 22,0 хувь;
- хөнгөн аж үйлдвэр, хамтарсан үйлдвэрт 8,0 хувь;
- геологи хайгуул, зураг төслийн ажилд 5,0 хувь.

Гадаад худалдааны тэнцлийг хангахад зориулж авсан зээл нь хоёр янзын учир шалтгаантай байжээ. *Нэгд*, манай экспортын барааны нийт хэмжээ үнийн дүнгээр импортын барааны дүнд хүрдэггүй байсан. Жишээлбэл, манай орны экспортын бүтээгдэхүүний нийт хэмжээ 1980-аад оны эцэст 730 орчим сая ам.доллар болдог байсан бол импортын хэмжээ 1010 сая ам.доллар, зөрүү нь 300 орчим сая ам.доллар байсан бөгөөд тэр үед шилжих рублиэр тооцож, уг зөрүүд ЗХУ-аас барааны зээл авдаг байжээ. *Хоёрт*, манай орны экспорт, импортын барааны үнийн өсөлтийн зөрүүд авсан зээл байсан бөгөөд гадаад худалдааны зээлийн 52 хувийг эзэлж байсан байна.

Дэлхий дахины 1973-1974 оны эрчим хүчний томоохон хямралаас үүдэн нефть бүтээгдэхүүний үнэ, түүнийг дагаж машин техник, бараа материалын үнэ ихээхэн нэмэгдсэн нь манай орны гадаад худалдааны тэнцэлд ноцтой сөрөг нөлөө үзүүлжээ. Тухайлбал, импортоор авч байсан машин техник, материал, түүхий эдийн үнэ 1975-1980-аад оны сүүлч гэхэд 1,8 дахин нэмэгдсэн байхад Монголын экспортын барааны үнэ энэ арваад жилд ердөө л 36 хувиар өссөн ажээ.

Манай Засгийн газрын төлөөлөгчид Монгол, Зөвлөлтийн гадаад худалдааны импорт, экспортын үнийн өсөлтийн дээрх асар их зөрүүг гарган тавьж, ЗХУ-ын Төлөвлөгөөний хороо, Сангийн яамны удирдах албан тушаалтнуудаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Ер нь энэхүү “үнийн зөрүү” (*оросоор* “ножницы цен”) нь “Их өр”-ийн асуудлыг амжилттай шийдвэрлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж тухайн үеийн удирдах албан тушаалтнууд хүлээн зөвшөөрдөг билээ.

3.1. Зээлийн өрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон нь

Манай Засгийн газрын төлөөлөгчид 1988-1990 онд Зөвлөлтийн талтай уулзалт хэлэлцээ хийхдээ зээлийн төлбөрийн зонхилох хэсгийг төлбөрөөс чөлөөлүүлэх, хүчингүй болгох, багаахан хэсгийн төлбөрийг хийх, гэхдээ түүний хугацааг улс орныхоо эдийн засаг, гадаад худалдааны тэнцлийг хангах, төлбөрийн чадварыг бүрэлдүүлэх боломжтой уялдуулан бодитойгоор авч үзэх нь зүйтэй гэсэн тооцоо, үндэслэлийг боловсруулж, дараах саналыг тавьж байжээ [14]. Тухайлбал:

1. Буурай хөгжилтэй орны хүн ам, нийгмийн үйлчилгээний хүрээний болон дэд бүтцийн салбарт зээл биш, буцалтгүй тусламж олгодог олон улсын практикт байдаг зарчмыг харгалзан орон сууц, нийтийн аж ахуйн барилга, байгууламж, эмнэлэг, сургууль барих, мөн тээвэр, холбоо, худалдаа, хангамж, түлш, эрчим хүч, барилга зэрэг дэд бүтцийн салбарт авсан 4 тэрбум орчим рублийн зээлийг төлбөрөөс чөлөөлүүлэх санал тавьсан ажээ.

2. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарт авсан 1,2 тэрбум рублийн зээл байсан боловч эдгээр салбараас олон арван жилийн турш ЗХУ-д мал, мах, ноос, ноолуур, арьс шир, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн нийлүүлж байсан юм. Тус салбарт зээл ахиухан авч эхэлсэн 1965 оноос хойш манайхаас ЗХУ-д 3 сая тонн амьдын жинтэй тэнцэх мал, мах, 270 мянган тонн төрөл бүрийн ноос, ноолуур, 15 сая ширхэг арьс шир, бэлэн бүтээгдэхүүнийг экспортоор гаргасан байдаг ажээ.

Зөвхөн 1975-1990 оны арван таван жилийн хугацаанд ЗХУ-д гаргасан хөдөө аж ахуй, түүний гаралтай бүтээгдэхүүний хэмжээ тухайн үеийн гадаад худалдааны үнээр 1,9 тэрбум рубль болсон байжээ. Гэтэл уг бүтээгдэхүүнийг ЗХУ-д тухайн үед мөрдөж байсан дотоодын бөөний болон бэлтгэлийн үнээр үнэлэхэд 6,9 тэрбум рубль болж, түүний зөрүү 5 тэрбум рубль нь Зөвлөлт улсын төсөвт цэвэр ашиг болж орсон нь тодорхой болсон байна.

Монголын талаас гаргасан энэхүү тооцоо нотолгоо нь зээлийн өрийг чөлөөлүүлэхэд хамгийн чухал үндэслэл, өөрөөр хэлбэл “хэзрийн тамга” болж байжээ. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарт авсан 1,2 тэрбум рублийн зээл, 5 тэрбум рублийн ашгийн ердөө л 20 орчим хувьтай тэнцэж байгаа тул энэхүү зээлийг чөлөөлүүлэх, түүгээр ч барахгүй манай нийгмийн үйлчилгээний болон дэд бүтцийн салбарт авсан 4 тэрбум рублийн зээлийн өрийг ч уг ашгийн дүнтэй дүйцүүлэн тооцож хаахад төвөгтэй биш гэсэн үндэслэлийг гаргаж байжээ.

3. Хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэг болон Улаанбаатар төмөр замд манай талын хувь хөрөнгөд 1961 оноос өмнө авсан зээлээс төлөгдөөгүй үлдсэн 140-өөд сая рублийн өрийг хүчингүй болгох санал тавихдаа “Совмонголметалл” үйлдвэр 1950-иад оны сүүлээр татан буугдсан, Улаанбаатар төмөр замыг анх барихад авсан зээл нь тээврийн үйлчилгээг өргөтгөх зориулалттай байсныг иш үндэслэл болгосон байна.

4. Хамтарсан үйлдвэрийг барьж байгуулахад Монголын талын авсан нийт зээлийн хэмжээ 420 орчим сая рубль, түүний дотор “Монголсовцветмет” (одоогийн “Монголросцветмет”) нэгдлийн жоншны уурхай, Бор-Өндөрийн баяжуулах үйлдвэрийн зээл 123 сая рубль байжээ. Тус нэгдлийн уурхай, үйлдвэрийг барихад авсан зээлийг төлөх боломж бүрэлдэхгүй, үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа хангалтгүй байгаа талаар Зөвлөлтийн талд дараахь үндэслэлээр хандаж байжээ:

- “Монголросцветмет” нэгдэл байгуулагдсанаас хойш жоншны хүдэр, баяжмалыг бүхэлд нь ЗХУ-д экспортлож байсан, улмаар Зөвлөлтийн тал төмөрлөг, химийн үйлдвэрлэлд түүхий эд болгон ашиглаж, өндөр ашиг орлоготой эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан нь ойлгомжтой;
- Гэтэл Монгол дахь жоншны уурхай, баяжуулах үйлдвэрийн алдагдлыг нөхөхийн тулд манай улсын төсвөөс 250 сая орчим төгрөгийн татаас олгосон байжээ. Түүнчлэн хамтарсан үйлдвэрт нийлүүлсэн машин

механизм, тоног төхөөрөмжийн гадаад худалдааны үнэ 1976 оноос хойш таван жил тутамд 46-54 хувиар өссөн зэргийг харгалзан уг зээлийг төлөхгүйгээр тохиролцох санал дэвшүүлжээ.

5. Геологи хайгуул, зураг төслийн ажлыг санхүүжүүлэхэд авсан 340 сая рублийн зээлийг гол төлөв хамтарсан үйлдвэрийн түүхий эдийн баазыг бүрдүүлэх, үйлчилгээний хүрээний болон үйлдвэрлэлийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулах ажилд зориулж байсан тул Монголын тал энэ зээлийг төлбөрөөс чөлөөлөх үндэслэлтэй гэж үзэж байжээ.

6. Гадаад худалдааны тэнцлийг хангахад авсан зээлийн хувьд гэвэл, Зөвлөлтөөс нийлүүлж байсан импортын барааны үнэ 1975-1990 онд асар ихээр өссөн, харин ЗХУ-д гаргаж байсан манай экспортын барааны үнэ багахан өсөлттэй байсан зөрүүг нөхөхөд зориулагдсан 1,7 тэрбум рублийг шууд чөлөөлүүлэх үндэслэлтэй гэж үзэж байсан байна.

7. Харин үлдэх 1,6 тэрбум рублийн зээлийг ЗХУ-аас жинхэнэ биет бараа авахад зориулжээ. Гэхдээ Монголын экспортын нөөц хомс, экспортод гаргаж байсан бүтээгдэхүүний үндсэн үнэ харьцангуй доогуур байсан зэргээс шалтгаалж импортын барааг хэрэгцээний дагуу нийлүүлэхэд зээл авах зайлшгүй шаардлага гарч байсан хэрэг ажээ.

Нөгөө талаар манай орны экспортын эх үүсвэр нь гол төлөв мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, эрдсийн түүхий эд байсан нь гадаад худалдааны төлбөрийн чадварыг нэмэгдүүлэхэд олигтой нөлөө үзүүлж чадахгүй байсныг манай тал онцолж байжээ.

8. Манай орны экспортын чухал эх үүсвэр болж байдаг эрдсийн түүхий эд олборлох, баяжуулах уул уурхайн үйлдвэр, ихэнхдээ ЗХУ-ын зээлийн хөрөнгөөр, хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр баригдсан гэдэг нь ойлгомжтой хэрэг юм. Гэхдээ тийм үйлдвэрлэлийн анхны хөрөнгө оруулалт болон ашиглалтын зардал ихтэй бөгөөд бүтээгдэхүүний үнэ хямд, үр ашиг багатай дамжлага хэсэг (*уурхай, баяжуулах үйлдвэр*) нь Монгол Улсад, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ахиу ашигтай хэсэг нь Зөвлөлтийнх байсныг бодолцож асуудал болгон тавьж байсан ажээ.

Тухайлбал, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 1979-1989 онд ЗХУ-д нийлүүлсэн зэсийн баяжмалд агуулагдсан 1 сая тн зэсийг тус улсад нэг тн-ийг нь 1200 орчим рублиэр худалдсан байлаа. Тийм хэмжээний зэсээр сайн чанарын бэлэн бүтээгдэхүүн хийвэл дэлхийн зах зээлийн дундаж үнээр тооцоход 6-8 тэрбум рубль болох тооцоо гаргаж, энэ тухай Зөвлөлтийн талд танилцуулсаар байсан ажээ.

Хэрэв Эрдэнэтийн зэс, молибдений орд газрыг анхнаас нь л өндөр үр ашигтай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэмжээнд бүрэн цогцолбороор байгуулж эзэмшсэн бол гадаад худалдаанд зээл авах шаардлагагүй, улмаар хөрөнгө оруулалтын зээлийн хэмжээг ч үлэмж багасгах боломж байсан гэдэг дүгнэлтэд хүрч болох талтай байлаа [14].

9. Дээр дурдсан бүхий л байдлыг үндэслэн гадаад худалдаагаар бараа авахад зориулж ЗХУ-аас олгосон зээлийг чөлөөлүүлэх саналыг манай тал тавьж, бүхэлд нь авч үзэхэд нийтдээ 10 орчим тэрбум рублийн зээлийн өрийг чөлөөлүүлэх юм уу, хүчингүй болгуулах үндэслэлийг гаргасан байжээ.

4. “Их өр”-ийг шийдвэрлэсэн нь

ЗХУ болон бусад социалист орнуудтай манай орны эдийн засгийн харилцаа өргөжиж, тэдгээр орноос манайд үзүүлэх тусламж, хөнгөлөлттэй нөхцлөөр өгөх зээл эрс нэмэгдсэн байна. Тухайлбал, зөвхөн ЗХУ-аас Монголын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд 1971-1975 онд 450 сая орчим рублийн зээл, тусламж өгч байсан бол үндэслэл тооцоо сайжирсны ачаар 1976-1980 онд 1,4 тэрбум, 1981-1985 онд 3,2 тэрбум, 1986-1990 онд 3,5 тэрбум шилжих рублийн зээл, тусламж авч ашигласан байна [8].

Ийнхүү 1976 оноос хойш 14 жилийн хугацаанд жилийн хоёр хувийн хүүтэй, төлж эхлэх хугацаанд тухайн таван жилд тохиосон нөхцөлд урьдах зээлийн төлбөрийг шинэ хугацааг 40 хүртэл жилээр сунган тогтоож, хүү ногдуулахыг зогсоодог зэрэг ихээхэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай оронд барьж байгуулсан дэд бүтэц, үйлдвэрлэл, нийгмийн зориулалттай олон зуун чухал объект орчин үед эдийн засаг, нийгмийн амьдралын чухал үндэс суурь болж ашиглагдсаар байна.

Аж үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 1970-1990 онд 7,2-8,7 хувь байжээ.

ЗХУ-аас Монголд 1976 оноос 1990 оныг хүртэл хугацаанд арав шахам тэрбум шилжих рублийн зээл, тусламж авч, дэд бүтэц болон үйлдвэрийн олон чухал объект барьж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал нөхцөл бүрдүүлж байсныг зөвхөн төлөвлөгөө, төсөл боловсруулалт сайжирснаар тайлбарлаж болохгүй билээ. Үүнд улс төрийн бодлогын нөхцөл, шалтгаан нөлөөлсөн нь тодорхой юм.

Өр үүссэн үеийн хоёр орны харилцаанд эдийн засгийн харилцааны асуудлыг шийдэхэд улс төрийн бодлогоор хандах явдал давамгайлж байсан, гадаад худалдаагаар харилцан нийлүүлж байсан бараа, үйлчилгээний үнэ тариф нь дэлхийн зах зээлийн үнэ тарифаас ялгаатайгаар тогтоогдон олон жил өөрчлөгдөхгүй, хатуу мөрдөгддөг нь хэвшил болсон байсан, бараа, үйлчилгээний болон зээл, тусламжаар барих объектын үнийг ихэнх тохиолдолд нэг тал, тухайлбал Зөвлөлтийн талын аж ахуйн нэгжүүдийн санал болгосноор тогтоодог практик байсан, мөн тэр үеийн тооцоонд хэрэглэж байсан шилжих рублийн чөлөөт валюттай харьцуулсан ханш нь жинхэнэ худалдан авах чадварт үндэслэсэн бодит ханш байгаагүй зэргээс тооцоолж зээлийн хүүг шинэчилж тодорхойлох, түүнчлэн нийгмийн салбарт зориулагдсан зээлийг хөнгөлүүлэх талаар Монголын талаас удаа дараа гаргаж байдаг саналыг анхаарах учиртай.

ОХУ-ын Засгийн газрын дарга С.Степашин 1999 оны зургаадугаар сард Монгол Улсын шилжих рублийн нийт өрийн 70 хувийг хөнгөлж, үлдэх 30 хувийг 33 жилийн хугацаанд хөнгөлөлттэй хүүтэйгээр төлөхийг шаардаж, Засгийн

газрын тэргүүн Ж.Наранцацралтад албан тоот ирүүлж байсан нь Парисын клубын зарчимд үндэслэсэн, нөгөө талаар хоёр улсын харилцааны түвшинг илтгэсэн явдал байлаа [9].

1993 онд Ерөнхийлөгч асан П.Очирбат, Б.Н.Ельцин нар *“Монголын олон иргэн ЗСБНХУ-д хэлмэгдэн, цаазлагдсаны хариуцлага өнөөгийн ОХУ-д холбогдолгүй”* гэсэн албан ёсны хамтарсан мэдэгдэл гаргасан бөгөөд өр зохицуулах талаар ямар ч албан ёсны тохиролцоо байгаагүй байна.

ОХУ-д төлөх өрийн асуудлыг зохицуулан шийдвэрлэсэн өнөөгийн тохиролцоо нь Ерөнхийлөгч асан Б.Очирбат, Б.Н.Ельцин нарын 1995 онд санал солилцож байсан ерөнхий хандлагад огт харшлаагүй бөгөөд харин ч тэр үед П.Очирбатын баримталж байсан байр сууриас ихээхэн сайжирсан байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат: *“1990-ээд оны дундуур Оросын талаас санал болгосон “Их өр”-ийн 85 хувийг хүчингүй болгоод үлдсэн 15 хувийг нь жилийн хоёр хувийн хүүтэйгээр 30 жилийн хугацаанд төлөх саналыг хүлээн авах ёстой, үүнийг МАХН тухайн үед хүлээн зөвшөөрч шийдвэрлээгүй нь өр, зээлийн мухардалд оруулсан”* гэж үзэж байсан ажээ. Хэрвээ тэр үед П.Очирбатын санал болгосны дагуу дээрх хувилбарыг хүлээн авсан бол Монгол Улс 30 жилийн хугацаанд нийт 2,1 тэрбум гаруй ам.доллар төлөх байсныг дээрх шийдвэртэй харьцуулбал тэнгэр, газар шиг зөрүүтэй байгаа бөгөөд энэ нь эдийн засагт жинхэнэ хүндрэл бий болгох байсан билээ.

Харин ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди нарын 2000 оны арваннэгдүгээр сард тохиролцсон зарчмыг, тухайлбал:

- өр үүссэн түүхэн нөхцөл байдлыг харгалзан үзэх;
- Монгол Улсын эдийн засагт дарамт үзүүлэхгүй байх;
- олон улсын тавцанд өрийг шийдвэрлэж байгаа дэвшилтэт арга, механизмыг хэрэглэх;
- цаашдын хамтын ажиллагааны ирээдүйг харгалзах зэрэг зарчмыг удирдлага болгон ажилласан ажээ.

ЗСБНХУ-аас БНМАУ-д олгосон урт хугацааны зээлийн өрийн асуудлыг зохицуулах талаар санал боловсруулах хоёр тал (монгол-орос)-ын ажлын хэсгүүд байгуулагдан 20 гаруй удаа яриа хэлэлцээ хийж байсан. Дээрх хэлэлцээрийн үеэр Монголын тал тооцоо, судалгаа сайтай, зарчмын асуудалд анхаарал хандуулан ярилцаж байсан нь эцсийн шийдэлд хүрэх боломжийг алхам алхмаар ойртуулсан байна [11].

1. Өр үүсч бий болсон түүхэн нөхцөл, манай улсын төлбөрийн чадвар, төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлыг харгалзан, үнийн өсөлт, төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөх болон нийгэм, соёл, эрүүлийг хамгаалах, хөдөө аж ахуй, геологи хайгуул, зураг төслийн ажлыг санхүүжүүлэхэд олгосон зээлийг төлбөрөөс бүрмөсөн чөлөөлөх;

2. Өмнө ашигласан зээлд 1991 оноос эхлэн хүү тооцохгүй байх;

3. Хамтын үйлдвэрүүдийн Монголын талын хувь хөрөнгийг бүрдүүлэхэд авсан зээлийг тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнгээр төлж барагдуулах;

4. Үндсэн өрийг чөлөөт валютад хөрвүүлэн өр шийдвэрлэж байгаа олон улсын арга туршлага, оновчтой механизмыг хэрэглэх зэрэгт чиглэж байлаа.

Харин Оросын тал өрийн хэмжээг эцэслэн тохиролцох, зээлийн бүх хэлэлцээрийг нэгтгэх, шилжих рублийг чөлөөт валютад хөрвүүлэх итгэлцүүрийг тохиролцох, өр, төлбөр барагдуулах хугацааг хойшлуулах, зээлийн өрийн зарим хэсгийг хөнгөлөх, өрийн зарим хэсгийг буюу бүхэлд нь гурав дахь этгээдэд худалдах гэх мэт асуудлыг хүлээн зөвшөөрч ажиллах талаар байр сууриа илэрхийлж байсан. Зээлийн өрийг зохицуулах асуудлаарх яриа хэлэлцээ 1990 оноос өмнө нэлээд эрчимтэй хийж байгаад 1990-1993 онд үндсэндээ зогсонги байдалд оржээ. Харин 1993-1994 оны үед дахин сэргэж, манай тал идэвх гарган хөөцөлдсөнөөр нэгдсэн ойлголт, байр сууринд хүрэхэд нэлээд дөхөж ирсэн болно.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын 2003 оны зургаадугаар сарын 26-наас долдугаар сарын 2-ны өдрүүдэд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны хооронд үүссэн шилжих рублийн өрийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх арга механизмыг тохирсон нь түүхэн чухал ач холбогдолтой шийдвэр болсон юм. Манай хоёр улсын Ерөнхий сайд нар Монгол Улсаас ОХУ-д төлөх “Их өр”-ийн 95-аас доошгүй хувийг хөнгөлөх, гэхдээ мэргэжлийн яамд тооцоогоо нарийвчлах, хөнгөлөлтийн түвшинг тодорхойлох, өр барагдуулах арга, механизмыг олон улсын жишигт нийцүүлэн тохиролцох үүргийг өгснөөр олон жил яригдсан “Их өр”-ийн асуудал шийдвэрлэгдэх эцсийн шатандаа орсон билээ.

Ерөнхий сайдын айлчлалын дараа Санхүү, эдийн засгийн сайдын ахалсан *“Их өр”-ийн асуудлыг зохицуулан шийдвэрлэх комисс*” ОХУ-ын холбогдох байгууллагатай үргэлжлүүлэн ажиллаж, өрөөс чөлөөлөх хэмжээг тохиролцсон юм. Ингэхдээ дээд түвшинд тохиролцсон зарчмууд, тухайлбал, Монгол Улсын эдийн засгийн бодит боломжийг харгалзан үзэх, манай орны эдийн засгийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаанд дарамт үзүүлэхгүй байх нөхцлөөр тооцоог тус тусдаа хийж, үр дүнгээ тулгасан юм. Ингэхэд Монгол Улсын өр төлөх боломж, манай талын тооцоогоор 300 сая ам.доллар, Оросын талын тооцоогоор 330 сая ам.доллараар тодорхойлогдож, тооцоо ойролцоо гарч байсан нь тухайн үедээ “Их өр”-ийг шийдвэрлэхд чухал ач холбогдолтой болсон билээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын 2003 оны долдугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр дээр дурдсан үндсэн зарчмуудын хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллагад хэрэглэдэг аргачлал, шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан өрийн тооцоо, судалгааг гаргаж, “Их өр”-ийн асуудлыг зохицуулан шийдвэрлэх арга хэлбэр, механизмыг тохиролцож, өрийн 95-аас доошгүй хувийг хөнгөлж болох тухай ойлголцолд хүрсэн. Түүнчлэн эцсийн тооцоо нийлэх, хөнгөлөлтийн түвшинг тодорхойлох, төлбөр барагдуулах

үүргийг хоёр улсын санхүү, эдийн засгийн төв байгууллагуудад даалгаснаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-аас тодорхой шийдвэр, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлснээр манай орны нийт өрийн 98 хувийг төлбөрөөс чөлөөлүүлж, үлдсэн төлбөрийг богино хугацаанд барагдуулснаар энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэж, 2003 онд багтаж өрийн данс тэглэгдсэн юм.

ОХУ-ын Сангийн сайд А.Кудринээс Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярт 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн 20.01.01/1229 тоот, ОХУ-ын Засгийн газрын тэргүүн М.Касьяновоос 2004 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярт ирүүлсэн 75п-П2 тоот, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинээс Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид ирүүлсэн Пр/271 тоот албан бичгийг тус тус хүлээн авснаар “Их өр” гэж нэрлэгддэг шилжих рублиэр илэрхийлэгдсэн зээлийн асуудал бүрэн шийдэгдэж, өрийн данс хаагдсаныг баталгаажуулсан юм.

Ийнхүү 2004 онд Монгол Улсын хувьд аль нэг улстай хугацаа хэтэрсэн өрийн асуудал байхгүй, гадаад эдийн засгийн харилцааны хувьд бусад оронтой эрх тэгш харилцахад маш тааламжтай, макро эдийн засгийн тогтвортой нөхцөл бүрдсэн билээ [12].

5. Дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 оны Улаанбаатарт хийсэн дээд хэмжээний айлчлалын үеэр тохиролцсон өр зохицуулах зарчмууд нь “Их өр”-ийг тэглэх үндэс суурь болж өгчээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр, ОХУ-ын Ерөнхий сайд М.М.Касьянов нарын 2003 онд Москвад хийсэн уулзалтын үр дүнд “Их өр”-ийг 96-аас доошгүй хувиар чөлөөлж, үлдсэн хэсгийг 300 сая ам.доллараар төлөх түүхэн тохиролцоонд хүрсэн байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагад хэрэглэдэг аргачлал, шалгуур үзүүлэлтэд тулгуурлан өрийн тооцоо, судалгааг гаргаж, өрийг худалдах, худалдан авах зарчмаар ОХУ-ын Сангийн сайд А.Кудрин, Монгол Улсын Сангийн сайд Ч.Улаан нар эцэслэн “Их өр”-ийг 250 сая ам.доллараар 2003 оны эцсээр цайруулсан нь Монгол Улс, Оросын Холбооны Улсын онцгой харилцааг бэхжүүлэх чухал алхам болжээ.

“Их өр”-ийн үлэмж хэсгийг хүчингүй болгосон тухай ОХУ-ын Ерөнхий сайд, Сангийн сайдын албан бичигт дурдагдсан “Монголросцветмет”-тэй холбоотой 162 сая ам.долларын өр, клирингийн өр болох 10 сая ам.доллар, нийт 174,2 сая ам.долларын өрийг “Их өр”-ийн зарчмаар буюу 97,8 хувийг хүчингүй болгуулж, үлдсэн 3,8 сая ам.долларын өрийг нэг удаагийн мөнгөн төлбөрөөр төлөхөөр болж, хоёр орны Сангийн сайд нар ОХУ-ын Москва хотноо 2010 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурснаар “Их өр”-ийг эцэслэн тэглэжээ.

ЗХУ-аас авсан 11,4 тэрбум шилжих рублийн зээлийн зөвхөн 5,2 хувийг Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт хотыг байгуулсан хөрөнгө оруулалт эзэлж байна.

“Их өр”-ийг зохицуулан 98 орчим хувийг нь чөлөөлүүлж, үлдсэн хэсгийг нь өөрийн эх үүсвэрээр шийдвэрлэсэн нь Монгол Улс эдийн засгийн бие даасан байдлаа бэхжүүлэх чиглэлд хийсэн томоохон алхам болжээ.

“Их өр”-ийн 98 хувийг чөлөөлүүлж, 2 хувийг төлсөн нь тоон утгаар бол Монгол Улс ХХ зуунд ЗХУ, ОХУ-аас авсан зээлээ бүрэн чөлөөлүүлж, манай орны тухайн үеийн Засгийн газрын бодлогын алдаанаас улбаатай нэмж бодогдсон хүүний 82 хувийг чөлөөлүүлж, 18 хувийг нь төлснөөр “Их өр”-ийг тэглэсэн байна.

Алив том гүрэнтэй харилцахад жижиг улсын ашиг сонирхлыг хамгаалахад хэцүү байдаг. Ийм учраас жижиг буюу буурай хөгжилтэй орны төр, засгийн эрх баригчид үндэсний ашиг сонирхлын зарчмын асуудлаар нэг санаагаар, эв зүйг олж ажиллаж чаддаг байх нь маш чухал гэдгийг “Их өр”-ийг шийдвэрлэсэн үйл явц харуулж байна.

Ном зүй:

- [1] “Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”, 1993 оны 1 дүгээр сарын 20.
- [2] “Улаанбаатарын тунхаглал”, 2000 оны 11 дүгээр сарын 14.
- [3] “Москвагийн тунхаглал”, 2006 оны 12 дугаар сарын 8.
- [4] “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”, 2009 оны 8 дугаар сарын 25.
- [5] ҮСХ. (1990-2017) Монгол Улсын Статистикийн эмхтгэл. – Улаанбаатар.
- [6] “Известия” сонины 1990.03.02-ны № 61 [22964] дугаар.
- [7] Лигдэн, Б. (1996) Эрдэнэт уул уурхайн баяжуулах үйлдвэр. – Улаанбаатар,
- [8] Содном, Д. (2003). Амьдрал, бодол. – Улаанбаатар.
- [9] Бат, Ц. (2005). “Их өр”-ийг шийдсэн байдалд эргэлзэх хэрэггүй. “Ардын эрх”, № 89.
- [10] Жамбалдорж, Д., Ганзориг, Р. (2007) Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны он жилүүд, хэтийн төлөв. – Улаанбаатар.
- [11] Пүрэвсүрэн, Б. (2008) Их өр үүссэн, дууссан түүх. – Улаанбаатар.
- [12] Сангийн яам. (2012) Ойллого түүх 1911.12.29-2011.12.29. – Улаанбаатар.
- [13] Мэндсайхан, Л. (2013) Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн түүхэнд холбогдох архивын баримт, эх сурвалж. – Улаанбаатар, 35 х.х.
- [14] Намжим, Т. (2014) Замнал, бүтээл, цэгнэл. “Адмон” хэвлэлийн газар, – Улаанбаатар.
- [15] Галбаатар, Д. (2016) Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг байгуулахад Ю.Цэдэнбалын гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол. Эрдэм шинжилгээний эмхтгэл, – ЭР., 42-49 дэх тал.
- [16] Галбаатар, Д. (2016) Эрдэнэт үйлдвэрийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр. Mongolian Economy, № 08, – Улаанбаатар, 20-21 дэх тал
- [17] Моломжамц, Д. (2017) Монгол Улсын банкны салбарын хөгжлийн түүхэн эхлэлийг тодорхойлох асуудалд. Мөнгө, санхүү, баялаг. № 03, – Улаанбаатар, 41-46 дахь тал.
- [18] Осоргарав, Б., Хашчулуун, Ч. нар. (2018). Монгол Улсын өр. – Улаанбаатар.
- [19] Баярдаваа, Б. Дулмаа, Э. (2018) Макро эдийн засаг, банк, санхүүгийн салбарын хүндрэлийг даван туулсан бодлогын сонголт, хүрсэн үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ. Мөнгө, санхүү, баялаг. № 6, – Улаанбаатар, 92-114 дэх тал.

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

ОСОБЕННОСТИ РАЗВИТИЯ ЭКОНОМИКИ МОНГОЛИИ В XX в. И ПОГАШЕНИЕ БОЛЬШОГО ДОЛГА

Чултэм Улаан¹

<i>Классификация JEL:</i>	<i>Аннотация:</i>
D00, G00, L11, N15, H63	Рассмотрены вопросы становления экономики Монголии в XX в., обусловленные ее историческим прошлым и спецификой современного этапа развития. Сделан анализ достигнутого уровня развития страны при сравнении с уровнем развития бывших социалистических стран-членов Совета экономической взаимопомощи (СЭВ), когда-то составлявших единую систему хозяйствования. В конце сделан вывод о том, обеспечение всестороннего решения проблемы внешних долгов страны путем принятия необходимых мер на национальном и международном уровне для устойчивого снижения уровня задолженности в долгосрочном плане является насущным вызовом современности.
<i>Ключевые слова:</i>	
экономика Монголии, долг,	

1. Введение

Развитие экономики Монголии имеет свои особенности, обусловленные ее историческим прошлым и спецификой современного этапа развития. Именно поэтому изучение проблем развития нашей страны в XX в. и реальная их оценка приобретают особую актуальность.

Как известно, экономика феодальной Монголии состояла из однотипных экстенсивных кочевых животноводческих хозяйств, где еще не выкристаллизовалось общественное разделение труда. Скотоводство было практически единственным занятием ее населения, разнообразия деятельности не существовало. Самой характерной особенностью существовавшей в то время системы хозяйствования было минимальное вмешательство человека в совершающиеся естественно-исторические процессы. Это было идеальное воплощение знаменитой формулы “*Laissezfaire, laissezpasser*”, что означало: “Пусть все идет, как будет угодно случаю”.

Что собой представляло хозяйство дореволюционной Монголии? На этот вопрос ясно и бесспорно могли бы ответить только статистические данные, но их почти не было. Однако в 1918 г. правительством VII Богдо Жавзандамба хутахта была произведена перепись населения страны и поголовья скота. Сопоставляя данные различных источников, в том числе данные переписи населения 1918 г., можно получить самую общую картину о численности населения и количестве скота, а следовательно и об экономике страны [1, 35]. Правда, данные переписи страдали рядом существенных недостатков, поэтому, по некоторым источникам,

¹ доктор экономических наук (Ph.D.), профессор, член Великого Государственного Хурала Монголии, Заслуженный экономист Монголии

они охватывали лишь около 70 процентов территории и поголовья скота. Остальная часть страны оставалась неохваченной переписью.

Так, численность населения Монголии по данным переписи населения 1918 г. составляла 374 тыс. человек. Интересные расчеты провел руководитель специальной экспедиции Иркутской конторы Центросоюза России, экономист, впоследствии известный ученый, академик И. Майский. По ним, на территории Монголии в тот момент проживали 648,1 тыс. человек, из них 105 тыс. иностранцев (*100 тыс. китайцев и 5 тыс. русских, табл. 1*).

Таблица 1

Численность населения Монголии и среднегодовой темп прироста населения в 1918-1940 гг., %

Годы	Численность населения, тыс. человек	Среднегодовой темп прироста населения
1918	648,1	—
1925	684,0	0,8
1940	743,8	2,3

Источник: Namjim T. Past and Present of Mongolia. Ulaanbaatar, 1996. P. 37.

По данным переписи, в 1918 г. в нашей стране было всего лишь 5,2 млн голов скота. На наш взгляд, количество скота явно занижено, что было связано с тем, что перепись давала данные лишь по четырем аймакам и духовному ведомству.

Таблица 2

Поголовье скота Монголии в 1924-1925 гг., тыс. голов

Вид скота	1924	1925	Прирост, %
Верблюды	272,0	367,0	34,9
Лошади	1340,0	1457,0	8,7
Крупный рогатый скот	1512,0	1437,0	-5,0
Мелкий рогатый скот	10640,0	12904,0	21,3
Всего	13764,0	16165,0	17,4

Источник: Namjim T. Past and Present of Mongolia. Ulaanbaatar, 1996. P. 281.

Распространив данные переписи на всю территорию страны, академик И. Майский пришел к выводу, что в 1918 г. в Монголии имелось всего 9,6 млн голов скота. При этом он полагал, что и эти цифры переписи скота ниже действительных приблизительно на 30 процентов, исходя из чего он сделал вывод о том, что в то время поголовье скота составляло примерно 12,7 млн голов, что примерно соотносится с последующими данными 1924-1925 гг. (табл. 2).

Скотоводство, определявшее весь облик и быт народа тогдашней Монголии, и было основой ее экономики. Огромное количество скота сосредоточивалось в руках феодалов и монастырских хозяйств. Так, светским и духовным феодалам, составляющим всего лишь 7,8 процентов населения, принадлежало 49,5 процентов скота, или почти половина всего его поголовья,

остальная же часть приходилась на долю аратов-скотоводов, т.е. подавляющего большинства населения страны.

Таблица 3

Приблизительный объем производства продукции
животноводства в Монголии (1918 г.)

Показатели	Всего	Из них:	
		Для внутреннего потребления	Для экспорта
Количество заготовленного скота, тыс.	2270,0	1298,0	972,0
в том числе:	Верблюды	12,0	3,0
	Лошади	156,0	70,0
	Крупный рогатый скот	218,0	100,0
	Овцы	1572,0	667,0
	Козы	312,0	132,0
Молоко, млн л	330,0	330,0	—
Сливочное масло, тыс. т	8,0	7,2	0,8
Овечья шерсть, тыс. т	10,0	4,4	5,6
Верблюжья шерсть, т	800,0	80,0	720,0
Грива, т	800,0	110,0	690,0
Волосы яка, т	800,0	800,0	—
Конина, тыс. шт.	95,0	40,0	55,0
Яловка, тыс. шт.	130,0	55,0	75,0
Овечья кожа и козляная, тыс. шт.	1400,0	900,0	500,0
Кожа ягнят и козлят, тыс. шт.	1200,0	700,0	500,0

Источник: Namjim T.Past and Present of Mongolia. Ulaanbaatar, 1996. P. 281.

Кроме того, экономика Монголии полностью зависела от иностранного торгово-ростовщического капитала, который занимал господствующее положение на монгольском рынке и держал весь внешнеторговый оборот страны в своих руках.

Экономическая отсталость Монголии объяснялась еще и тем, что почти половина ее мужского населения представляло собой духовное сословие и фактически не участвовала в материальном производстве. Араты-скотоводы, за исключением лишь отдельных лиц, были поголовно неграмотными.

Таблица 4

Количество иностранных компаний,
работавших в Монголии (1922-1924 гг.)

Количество компаний	1922	1923	1924
Китайские	863	1553	1443
Российские	29	57	166
Американские, английские, немецкие	5	26	62
Тибетские	—	18	19
Частные предприниматели	234	296	2325

Источник: Namjim T.Past and Present of Mongolia. Ulaanbaatar, 1996. P. 323.

В этих условиях свершилась народная революция 1921 г., которая была продолжением национально-освободительной революции 1911 года, результатом длительной освободительной борьбы монгольского народа за выживание. В истории древнейшего народа была перевернута исключительно важная страница: старая, феодально-теократическая Монголия ушла в историю и возникла новая, народно-революционная Монголия, которая пройдя через ряд этапов и переходных периодов в своем развитии, ныне опять находится в переходном состоянии.

Таблица 5

Объем производства некоторых видов промышленной продукции
на душу населения в 1940-1990 гг.

Вид продукции	1940	1960	1970	1980	1990	Прирост, %
Электричество, кВт. ч	15,5	111,7	439,3	973,2	1613,1	104 раза
Уголь, кг	234,9	649,7	1602,0	2719,0	3443,7	14,7 раз
Медный концентрат, кг	—	—	—	—	170,0	...
Плавиковый шпат и его концентрат, кг	—	42,3	61,8	375,0	355,0	62 раза
Цемент, кг	—	—	77,1	110,5	212,4	2,8 раз
Сапоги, пар	0,2	0,9	1,3	1,3	2,3	11,5 раз
Кожаное пальто, шт.	—	1,0	3,0	3,0	2,0	2 раза
Дублёнки, шт.	—	3,0	3,0	5,0	7,0	2,3 раза
Мясо и мясные продукты, кг	6,5	13,4	28,0	35,3	28,4	4,4 раза
Молоко и молочные продукты, л	—	1,1	9,0	15,5	28,4	26 раз
Хлебокондитерские изделия, кг	4,4	14,6	29,8	43,5	50,5	11,5 раза
Мыло, шт.	—	2,0	3,0	30,0	5,0	2,5 раза

Источник: Namjim T. Past and Present of Mongolia. Ulaanbaatar, 1996. P.305.

Приступая к строительству нового общества, Монголия не имела ни техники, ни людей, обладающих навыками ее использования. На наш взгляд, с учетом ранее существующей базы достигнутый в 1990-е гг. уровень развития Монголии является результатом огромных усилий и напряжений нашего народа.

За годы прошлого века в нашей стране было создано крупное промышленное производство с различными отраслями. В Монголии в 1972 г. выработка электроэнергии на душу населения была в 623 раза больше, чем в Бирме, в 6 раз больше, чем в Шри-Ланке, в 4 раза больше, чем в Пакистане и Индии, и в 1,5 раза больше, чем в Турции.

Наряду с коренными изменениями в экономике были осуществлены поистине гигантские преобразования в области образования и культуры. В условиях глубокой религиозности и почти поголовной неграмотности населения создание сфер образования, здравоохранения и культуры являлось решающим фактором дальнейшего развития страны.

На наш взгляд, прежде чем достичь нынешнего уровня развития, Монголия прошла несколько этапов в своем развитии, а именно:

1. 1924-1940 гг. – период завоевания экономической самостоятельности;
2. 1940-1960 гг. – этап становления новой экономики;
3. 1960-1990 гг. – этап индустриализации страны.

По нашему мнению, на каждом этапе развития страны решались конкретные задачи, которые ниже рассмотрим более детально.

2. Период завоевания экономической самостоятельности

С развитием государственного сектора экономики страны произошли кардинальные изменения в структуре государственного бюджета. Государственные и кооперативные организации начали давать основную часть дохода госбюджета уже к 1940 г., о том свидетельствуют данные табл. 6.

Таблица 6

Динамика структуры доходов государственного бюджета
(1924-1940 гг., %)

Показатели	1924	1932	1940	Прирост, %
Доходы от государственных и кооперативных организаций	8,6	22,6	62,1	7,2 раз
Торговые и производственные налоги	2,2	20,5	11,2	5,1 раз
Доходы от прибыли государственных компаний	–	2,5	7,1	2,8 раза
Бюджетная добавка	–	–	24,5	–
Таможенные налоги	6,4	0,6	19,3	3 раза
Налоги от населения	70,1	39,2	17,5	–4 раза
Налог от скотоводства	10,5	7,1	12,4	1,1 раз
Подходный налог служащих	–	0,7	2,4	3,4 раза
Подходный налог от иностранных торговцев	11,2	1,0	1,6	–7 раз
Торгово-промышленный налог	4,1	0,7	1,0	–4,1 раза
Таможенный сбор	44,3	20,0	–	–
Налог на имущество монастырей	–	6,7	–	–
Налог на лам	–	3,0	0,1	–30 раз
Другие	21,3	38,2	20,4	–4,2
Местные налоги	4,8	8,6	1,1	4,4 раза
Другие доходы	16,5	14,6	9,2	–44,2
Кредит	–	15,0	10,1	–32,7
Всего	100,0	100,0	100,0	-

Источник: по данным Министерства финансов Монголии

В структуре дохода госбюджета непрерывно росла доля дохода вновь созданных предприятий с одновременным уменьшением доли налогов, взимаемых у населения. Так, например, доля доходов от государственных и кооперативных организаций за 1924-1940 гг. выросли в 7,2 раза, а доля налогов от населения снизилась за это же время в 4 раза.

К концу данного этапа, завершившегося к 1940 г., промышленность стала самостоятельной отраслью экономики. Ее доля в совокупной продукции промышленности и сельского хозяйства составляла 17 процентов.

За эти годы в структуре народного хозяйства страны произошли коренные изменения. Доля сельского хозяйства в производстве общественного продукта за 1921-1940 гг. снизилась с 98 до 64 процентов, а доля промышленности в эти же годы увеличилась с 1,0 до 12,7 процентов, что в то время являлось немалым достижением. Из табл. 7 видно, что в структуре общественного продукта и национального дохода прочное место начали занимать новые отрасли, такие как промышленность и строительство, однако сельское хозяйство, а особенно животноводство, по-прежнему оставалось ведущим сектором экономики.

Таблица 7

Динамика структурных изменений в экономике
(1921-1940 гг., %*)

Показатель	1921	1924	1940
Общественный продукт	100,0	100,0	100,0
Сельское хозяйство	98,0	96,5	64,0
Промышленность	1,0	1,5	12,7
Строительство	–	–	1,3
Транспорт и связь	–	–	1,0
Торговля и снабжение	–	2,0	6,8
Другие	1,0	–	14,2
Национальный доход	100,0	100,0	100,0
Сельское хозяйство	99,2	93,9	61,0
Промышленность	0,8	1,1	8,5
Строительство	–	–	0,8
Транспорт и связь	–	–	0,8
Торговля и снабжение	–	5,0	9,1
Другие	–	–	19,8

Примечание: * по данным Нацкомстата Монголии

3. Этап становления новой экономики (1940-1960 гг.)

В результате событий, происшедших после победы революции 1921 г., Монголия безвозвратно вступила в эпоху коренной социально-экономической перестройки, суть которой сводится к замене феодально-крепостнического хозяйства социалистическим. В этот период были, конечно, серьезные перегибы и ошибки.

Төсөвжүүлэлтийг боловсруулснаар үйлдвэрлэлийг өргөтгөх, сайжруулах, техникийн шинэчлэл хийхэд чиглэгдсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх сурвалжийг төлөвлөх бололцоо өргөсдөг. Төсөвжүүлэх процессийг ашгийн байгууллагын санхүүгийн төлөвлөлтийн стратегийн хэв маягт хамааруулж болно. Төсөвжүүлэлтийг хэрэглэх нь байгууллагадаа хөрөнгө оруулалт татах чадварыг дээшлүүлдэг, юу гэвэл, төсөвжүүлэлт нь гаднын (гадаад) ашиглагчид буюу хөрөнгө оруулагчид, банкуудад санхүүгийн ил тод байдлыг харуулж өгдөг, ингэснээр, ийм компанид гаднаас хөрөнгө оруулах, удаан хугацааны зээл олгоход гарч болох эрсдэл буурах нөхцөл бүрддэг байна.

Ашигийн бус байгууллагуудын (*төсөвт газрууд, өөр бусад ашигийн бус байгууллагууд*) санхүүгийн төлөвлөгөөг эдгээр байгууллагын дүрмийн үйл ажиллагааны хүрээнд ашгийн бус үндсэн дээр нийгэм-соёл, шинжлэх ухаан, боловсролын болон бусад үйлчилгээний санхүүгийн нөөцийн хэмжээ, түүнийг ашиглах чиглэлийг тодорхойлох зорилготойгоор боловсруулдаг.

Санхүүгийн **төсөөллийн** үндсэн гол онцлог нь дунд агаад удаан хугацааны төлөвийг баримжаалдаг, таамаглаж буй санхүүгийн хэмжээсийг үнэлэх, зөвлөх шинжтэй байдагт оршино. Санхүүгийн төсөөлөл бол санхүүгийн өсөлт, санхүүгийн хэмжээ, бүрэлдэл бүтэц, тэдгээрийг ашиглах чиглэлийн хэтийн төлөвийг урьдчилан харж, стратегийн үнэлгээ өгөх үйл ажиллагаа юм. Санхүүгийн төсөөллийн үзүүлэлтүүд нь санхүүгийн хэтийн төлөв байдал, санхүүгийн нөөцийн хэрэгцээ зэргийг тодорхойлж байдаг юм. Санхүүгийн прогнозчлолын үр дүнг санхүүгийн төлөвлөгөө боловсруулахад ашигладаг,

гэхдээ санхүүгийн төсөөлөл нь санхүүгийн бодлогын үзэл баримтлал, стратегийг боловсруулан хэрэгжүүлэхэд бие даасан үүрэг ч гүйцэтгэж болно.

Санхүүгийн төсөөллийн зорилго нь санхүүг бэхжүүлэх, улс орны болон түүний нутаг дэвсгэрийн, аж ахуй эрхэлдэг субъектүүдийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн дунд болон удаан хугацааны төлөвийн төсөөллийг санхүүгийн нөөцөөр хангах, санхүүжүүлэх үнэлгээний гол шинжийг заадаг хэмжээг эдийн засгийн хувьд боловсруулах, улмаар санхүүгийн төлөвлөгөөний үзүүлэлтийг үндэслэх явдал юм. Санхүүгийн төсөөллийн үндсэн зорилт нь: мөнгөн өртгийн агаад эд материалын хэм зохицлын хэтийн уялдааг хангах; захиргааны байгууллагууд агаад аж ахуйн субьектийн мэдэлд олгож болох санхүүгийн нөөцийн эх сурвалж, хэмжээ, бүтцийг төсөөлөх; байгууллагуудын менежмент агаад захиргааны байгууллагуудын нөөцийг ашиглах арга зам, чиглэл, гол баримжааг үндэслэх; санхүүгийн төсөөллийн гол шинжийн хүрээнд гаргах шийдвэрийн үр дүнг тодорхойлж, санхүүгийн үүднээс гарах үр дагаврыг үнэлж үзэх зэрэгт оршино.

Санхүүгийн төсөөллийн явцад санхүүгийн хэтийн төлөвлөгөө хэмээн нэрлэж болох төсөөлөл зохиогддог. Энэ төсөөлөл нь 3-5 жилийг тооцоолсон дунд хугацааны, бас арай илүү урт хугацааны хэмээн байж болно.

* * *

Дэлхийн хөгжингүй орнуудын төрийн үйл ажиллагааг шинжилж үзвэл, нийгмийн амьдралын аль ч хүрээнд төрөөс оролцох дэс шат тухайн салбарын тогтвортой байдлын түвшинтэй шууд пропорциональ холбоотой ажээ гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Хэрэв социаль хүрээний тогтвортой байдал хангалтгүй байвал нийгмийн социаль амьдралд төр оролцоно, хэрэв эдийн засгийн тогтолцооны зохих гол шинж доогуур байвал төр тухайн салбарын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөгөө нэмэгдүүлдэг. Энэ нь эдийн засгийн хямралын үед бүүр ч тодорхой илэрдэг амой.

Эдийн засагт төрөөс оролцох *чиглэл*, *дэс шатыг* тодорхойлох арга улс бүхэнд өөр өөр байна. Бүс нутгийн, нийгмийн амьдралын эдийн засгийн тогтвортой байдал зэргийг нарийн хянаж шинжилж үзэх нь бүсүүдийн нийгэм, эдийн засгийн дэд системд төр оролцох чиглэл, дэс шатыг тодорхойлох боломж олгодог.

Төр нь нийгмийн эдийн засгийн амьдралд ямар нэгэн хэмжээгээр оролцдоггүй улс орон өнөөгийн ертөнцөд чухамдаа байхгүй. Төрийн оролцооны хэмжээ, далайц, арга хэрэгсэл нь л янз бүр байна. Эдийн засагт төр нөлөөлөх хэмжээ зөөлөн аядуу байвал ийм байдлыг эдийн засгийн *дирижизм* хэмээн нэрлэж заншжээ, хэрэв нөлөөлөл нь байнга агаад хүчтэй байвал *төрийн зохицуулалт* хэмээн нэрлэгддэг. Эдийн засгийн дирижизм ардчилсан, өндөр хөгжилтэй, харьцангуй жижгэвтэр улсууд (*Бельги, Швейцарь, Нидерланд, Сингапур, Мальт, Сант-Марико, Кипр*)-д тогтжээ.

Хөгжингүй томоохон улс орнууд холбооны нэгж, аж ахуй эрхэлдэг субьект олонтой, нутаг дэвсгэр уудам, хүн ам ихтэй хийгээд том гүрний өөр бусад ялгагдах онцлогтой байдаг болохоор энэ бүхэн нь төрийн нухацтай оролцоо, бүс

нутгийн дээд зэргийн менежмент шаарддаг, иймд энд эдийн засгийн дирижизм тохирохгүй.

Улс орны том жижгийн хэмжээ, эдийн засагт төрөөс оролцох дэс шат агаад эдийн засгийн идэвхтэй өрнөлтийн дараахь уналтын үе дэх инфляцийн түвшин зэргийн хоорондын хамаарлыг В.Леонтов бүр 1973 онд олж тогтоосон байна. Улс орон хичнээн том байх тусам, улсын үйлдвэрийн газрын хэмжээ 50 хувьд хичнээн ойр байх тусам хямралын үеийн инфляцийн түвшин төчнөөн доогуур байдаг ажээ. Эдийн засагт нь улсын салбар 30-50 хувийг эзэлдэг, эдийн засгийн асар их чадавхтай АНУ, Энэтхэг, Хятад, Япон, Герман, Орос зэрэг хөгжиж байгаа хийгээд хөгжингүй улс орнуудад инфляцийн түвшин жилд гол төлөв хоёр оронтой тооноос давдаггүй гэдгийг В.Леонтьев олж тогтоожээ. Эдийн засагт нь улсын салбар 20-иос бага хувь эзэлдэг Исланд, Эквадор, Гана, Уругвай, Сьерра-Леоне зэрэг улс орнуудад хямралын үед инфляци эрс нэмэгдэж, жилд хэдэн зуу, заримдаа хэдэн мянган хувьд хүрдэг байна.

“Эдийн засгийн нэн чухал социаль хүрээнүүдэд хувийн хэвшил зонхилж байгаа бол хямрал гүнзгийрэх үед энэ нь үйл явцын тогтворгүйжилтийг хурдасгадаг” гэсэн дүгнэлтэд Дж.Ю.Стиглиц, Э.Уорнер, У.Нордхауз, Дж.Тобин, Д.Тэслер болон бусад хэд хэдэн эрдэмтэн бие биеэс хамааралгүйгээр тус тусын судалгаагаар хүрсэн байна. *“Хувийн өмчийн хөгжингүй институци бий болгох, өөрөөр хэлбэл, хувийн өмчийг голлон шүтэх нь тогтворгүйжилтээс хамгаалах баталгаа болж чадахгүй”* гэдгийг дэлхий дахины туршлага харуулж байна.

Эдүгээгийн байдлаар эдийн засгийн үйл явцад төрийн оролцоо хөгжингүй олон оронд Орос, Монголынхоос дээгүүр байна. Жишээлбэл, эдийн засагт төрөөс оролцох хувь хэмжээ АНУ-д сүүлийн 30 жилд эрс өсчээ:

- тус орны бүх гол авто зам, төмөр замын шугам улсын мэдэлд байна;
- шинжлэх ухаан-техникийн ололтыг ашиглах эрсдэлтэй бизнесийг хөгжүүлэх асуудлыг төр мэдэлдээ бүрэн авчээ;
- 1960-аад оны үед “ядууралтай тэмцэх дайн” зарлаж, “Орон сууц”, “Эрүүл мэндийн үйлчилгээ”, “Амьжиргааны баталгаат доод хэмжээ” зэрэг социаль хөтөлбөрийг төр ивээлдээ авчээ.

Их Британид ган, нүүрсний үйлдвэрлэлийг төр хариуцдаг, Японд олон улсын борлуулалтын зах зээлийг эзэмших хүнсний амин чухал бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэгчдийг эрж хайх ажлыг төр эрхэлдэг байна.

АНУ, Япон, Канад, ХБНГУ, Их Британи зэрэг томоохон улс орнуудад төрийн зохицуулах үйл ажиллагаа нь холбооны, бүсийн, орон нутгийн гэсэн гурван түвшинд хэрэгждэг ажээ.

Хөгжилтэй бүх орнуудад холбооны Засгийн газар нь дараах асуудлыг хариуцдаг: хөгжлийн стратегийг тодорхойлох, үндэсний батлан хамгаалах, хууль тогтоомж, мөнгө үйлдвэрлэх, шуудан холбоо, тээврийн гол их зам, нөөц сан бий болгох, бүс хоорондын харилцааг зохицуулах, олон улсын худалдаа, засгийн газрын нийгмийн хөтөлбөр боловсруулах, байгаль орчны асуудал гэх мэт.

Бүсийн агаад орон нутгийн удирдлагын мэдэлд дараах асуудал багтдаг: хүн амын ахуй амьдрал, боловсрол, дэг журам, гал түймрийн алба, цэвэрлэх байгууламж (*муу усыг татаж цэвэрлэх суваг, хоолой, ариутгах газар*), хог хаягдал боловсруулах, ариун цэвэр-эмчилгээний үйлчилгээ болон орон нутгийн бусад үйлчилгээ.

Дээрх зорилтыг шийдвэрлэхэд татварын аргаар дайчлан хуримтлуулсан нөөц төрд хүрэлцэхгүй. Төрийн үйл ажилагааг хэрэгжүүлэхэд нэн хэрэгтэй эдийн засгийн өөр нэг чухал бүтэц нь төрийн өмчийн зарчмаар байгуулагдсан **улсын салбар** юм. Яагаад гэвэл, эдийн засгийн хувийн хэвшил нь, гол төлөв, ашгийг дээд зэрэгт хүргэх гэсэн зорилгод чиглэгдсэн байдаг, түүний сонирхол нийгмийн социаль асуудлыг шийдэхэд хамаардаггүй. Ядуу амьдралтай хүмүүст санаа тавьсан нэг удаагийн ивээх тэтгэлэг улс орны социаль-эдийн засгийн нөхцөл байдлыг тогтворжуулах системтэй, үр бүтээлтэй үйл ажиллагааг орлож чаддаггүй.

Хөгжингүй олон улс оронд төр засаг нь нийгмийн “*үр ашиг-шударга ёс*” гэсэн үндсэн хоёр гол баримжааны хоорондын харьцааг тэнцвэржүүлэх арга хэмжээг байнга авч байдаг. Нийгмийн эдийн засагт төрийн гүйцэтгэх үүрэг хангалтгүй байгаа тэр газар тухайн тэнцвэржүүлэлтийн хэм зохицол эвдэрч орчин үеийн аж ахуй эрхлэлтийн нөхцөлд илүү дасан зохицсон (*санаа сэтгэл, эд материал, бие бялдар зэргийн хувьд*) цөөнхийн төлөөх үр ашгийг хангах тал руу хэлбийдэг.

Хөгжингүй хэд хэдэн орон (*АНУ, Их Британи, Япон, БНСУ, Израйль зэрэг*)-д шинжлэх ухаан, хөрөнгө мөнгө, хүч хөдөлмөр ихээхэн шингээсэн бүтээгдэхүүнийг гадагш гаргаж, түүхий эдээр солиход чиглэгдсэн төрийн зохицуулалтын монетар үзэл баримтлалыг хэрэгжүүлж байна. Орчин үеийн монетаризмын⁵ үндэстэн (*улс орон*) дамнасан бодлого нь бага хөгжилтэй улс орнуудын (*харамсалтай нь энд Орос, Монгол хамаарч байна*) эдийн засгийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлэх замаар хөгжилтэй орнуудын эдийн засгийн уналтыг зөөллөх арга болдог байна, дэлхийн санхүүгийн орчин үеийн хямралын үед энэ нь тодорхой илэрсэн билээ.

Үндэсний үйлдвэрлэлээ сэргээх гол чиг баримжаатай холбоотойгоор ОХУ-ын өмнө: хөрөнгө оруулалтын эрэлтийг Оросын бүтээгдэхүүн рүү шилжүүлэх, зүглүүлэх талаар гаалиар ивээн тэтгэх, эх орны эдийн засгийг гаднын өрсөлдөгчөөс хамгаалах, хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээний санхүүжилтийг сайжруулж, зах зээлийн үйлчилгээний хөгжлийг дэмжих зэрэг асуудал тулгарч байна, энэ бүхнийг хэрэгжүүлэх нь эдийн засаг өсөх, дундаж анги төлөвших, улс орны бүх хүн амын амьдралын түвшин дээшлэх гол нөхцөл болох юм.

Эдгээр асуудлууд Монголын нөхцөлд ч гэсэн тулгарч буй. Монголын улстөр-эдийн засгийн амьдралын өнөөгийн байдал нь түүнийг бүх талаас

⁵ монетаризм – гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ бол эдийн засгийн хөгжлийн тодорхойлогч хүчин зүйл юм гэж үздэг макро эдийн засгийн онол.

нь шинжлэн судлахыг шаардаж байна. Энэ шаардлагыг хангах нь Монголд шинжлэх ухаанч улстөрийн эдийн засгийн ухааныг сэргээж, улмаар үндэсний улстөрийн эдийн засгийн ухааныг боловсруулахад хүргэх болно.

Ном зүй:

- [1] Политическая экономия (1989). Учебник для вузов. Медведев В.А., Абалкин Л.И., Ожерельев О.И. и др. – М., Политиздат, 735 хуудас
- [2] Даш-Ёндон Б. (2018). Улстөрийн эдийн засгийн ухааны философийн асуудалд. Цуврал: «Философи, эрх зүйн судалгаа». Т. XXX.
- [3] URL: http://ria.ru/tags/organization_BRIKS/#14174154339774&message=resize&relto=login&action=removeClass&value=registration
- [4] URL: <http://ru-trade.info/briks-budushhee-mirovoj-ekonomiki-2/>

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

АКТУАЛЬНЫЕ ВОПРОСЫ МОНГОЛО-РОССИЙСКИХ ТОРГОВЫХ ОТНОШЕНИЙ НА СОВРЕМЕННОМ ЭТАПЕ

Д. Моломжамц¹

<i>Классификация JEL:</i>	<i>Аннотация:</i>
A10, E20, F36, F53	В статье дан краткий обзор истории развития монголо-российских торгово-экономических отношений в постсоветский период (1990–2018 гг.), анализ современного состояния и перспектив двухстороннего сотрудничества по итогам 21-го заседания Монголо-Российской Межправительственной комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству (Москва, февраль 2018 г.), предложения автора по приоритетным направлениям развития двустороннего торгово-экономического партнерства в ближайшие годы, включая создание экономического коридора Россия-Монголия-Китай.
<i>Ключевые слова:</i>	
Монголия, Россия, торгово-экономическое сотрудничество, экономический коридор Россия-Монголия-Китай.	

Как и вся социалистическая экономика, до 1990-х гг. экономика Монголии развивалась в условиях жесткой командно-административной системы на плановой основе. Монгольская экономика по существу была интегрирована в экономику Советского Союза. На долю СССР к моменту его распада приходилось 78 процентов внешнеторгового оборота Монголии, в том числе более 80 процентов экспорта [1, С.122]. Иначе говоря, платежеспособность страны полностью зависела от СССР. Начало 1990-х гг. было непростым временем для Монголии и России в свете реалий, порожденных началом демократических и рыночных преобразований в обоих государствах, что вызвало спад в двухсторонних отношениях в силу нарушения хозяйственных связей, развивавшихся в период директивной экономики.

В годы перехода к рыночной экономике произошла переориентация внешней торговли Монголии с рынков России и бывших социалистических стран на китайский и западные рынки. В 1991 г. 95 процентов внешнеторгового оборота Монголии приходилось на страны-члены СЭВ. По состоянию на март 2018 года Монголия осуществляет торговое сотрудничество со 163 странами мира. В экспорте первое место занимает Китай (85,6 процентов), на втором – Великобритания (10,7 процентов), на третьем – Россия (1,1 процент), далее – Италия, Сингапур и др. В общем объеме импорта Монголии первое место занимает КНР (32,9 процента), второе – Россия (28,1 процент), третье – Япония (8,4 процента), далее – США (4,8 процента) и Южная Корея (4,6 процента).²

¹ Дэмчигжавын Моломжамц, доктор экономических наук, профессор, заслуженный экономист Монголии, старший советник Правления Международного инвестиционного банка, Москва; электронный адрес: molomjamts_d@yahoo.com

² Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. URL: www.nso.mn (дата обращения 30.06.2018).

Подобная смена приоритетов представляется закономерной, поскольку с либерализацией экономики внешнеэкономические связи Монголии стали определяться и рынком, и новыми геополитическими интересами страны.

Несмотря на диверсификацию внешнеэкономических связей и политику открытости, Россия остается одним из главных торгово-экономических партнеров Монголии. По данным монгольской статистики, в 2017 г. общий монголо-российский товарооборот вырос на 37 процентов по сравнению с 2016 г. и составил 1 284,9 млн. долларов США, в том числе экспорт из Монголии в Россию – 67,6 млн. долларов США, импорт из России в Монголию – 1 217,2 млн. долларов США [5]. За эти годы перехода к рынку структура экономики коренным образом изменилась. Движущей силой роста экономики стал уже частный сектор. По состоянию на 2017 г. на его долю приходится более 70 процентов производства валового национального продукта Монголии.³ Еще в конце мая 1993 г. Монголия перешла на режим плавающего валютного курса национальной денежной единицы. В 2017 г. экономический рост составил 5,1 процент и произошла девальвация местной валюты – тугрика, соответственно растет и монгольский экспорт.

Основными статьями монгольского экспорта в Россию являются минеральное сырье, железная руда, флюорит, продукты животноводства и легкой промышленности. В структуре российского экспорта в Монголию главное место занимают нефтепродукты, машины и оборудование, автомобили, продовольствие, химические продукты, строительные материалы, сигареты и табак, бытовая техника и электроэнергия. В последние годы наблюдается тенденция уменьшения объема монгольского экспорта в Россию по причине введения Россией высоких импортных пошлин на монгольские экспортные товары, а также их низкой конкурентоспособности на российском рынке.

Большое отрицательное сальдо в торговле с РФ говорит о еще не задействованном потенциале двухсторонних экономических связей. Монголия еще не в полной мере использует имеющиеся возможности и ресурсы для дальнейшего расширения двухсторонних торгово-экономических отношений. При грамотной внешнеторговой политике Монголия и Россия могут значительно увеличить торговый оборот за счет увеличения поставок из Монголии, в первую очередь, мяса и продуктов животноводства, минеральной продукции горнорудной промышленности, а также за счет увеличения поставок высокотехнологичной продукции из России. По нашему мнению, в целях обеспечения стабильного развития торгово-экономического сотрудничества с РФ монголам следует обратить особое внимание на несколько приоритетных направлений.

Первое направление – активизация работы по линии Евразийского экономического союза (ЕАЭС), членами которого являются Россия, Армения, Беларусь, Казахстан и Киргизия. Действительно, рядом с Монголией создан и

³ Баабар: Надад ийм мөрөөдөл байна // iKon.MN. 28.03.2018. URL: <https://ikon.mn/n/1976> (дата обращения 30.06.2018).

активно работает рынок с населением более 183,7 млн. человек⁴, и участие в нем для страны актуально. Заключение Соглашения о зоне свободной торговли между ЕАЭС и Монголией может состояться уже в текущем 2018 г. Следует начать работу в области технического регулирования, стандартизации, ветеринарных и санитарных мер в рамках сотрудничества между Монголией и Евразийским экономическим союзом. Все эти меры существенно облегчат доступ Монголии к рынку ЕАЭС, в том числе и к российскому.

Однако создание зоны свободной торговли с ЕАЭС – только первый шаг, в дальнейшем следовало бы подумать над членством ЕАЭС. В настоящее время не только в Монголии, но и в самом ЕАЭС активно обсуждается возможность вступления в него Монголии. Хорошо, что этот вопрос вызывает большой интерес среди монгольских политиков и экономистов. Вступление Монголии в этот клуб стран – большой плюс для расширения ее экономического сотрудничества не только с РФ, но и с некоторыми странами Центральной Азии, в том числе с Казахстаном и Киргизией, с которыми у Монголии традиционно хорошие связи. Помимо ЕАЭС, Монголия должна стать членом и Евразийского банка развития.

Второе направление – межрегиональное сотрудничество, охватывающее отношения между приграничными аймаками и областями двух стран. Это мощный локомотив не только для расширения приграничной торговли и обмена услугами, но и основа для обеспечения стабильного развития торгово-экономического сотрудничества между нашими странами. В настоящее время Правительство Монголии ставит задачу постепенного перехода от политики экспорта минерально-сырьевых ресурсов к развитию традиционного производства, особенно в приграничных с Россией аймаках. В развитии межрегионального и приграничного сотрудничества большое значение имеет специальная подкомиссия по региональному и приграничному сотрудничеству в рамках Монголо-Российской Межправительственной комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству (МПК). По линии подкомиссии проводится определенная работа по усилению межрегионального сотрудничества, однако уровень работы в целом недостаточен. Объем региональной торговли в общем товарообороте между нашими странами не растет и составляет около 10 процентов. У таможенных органов Монголии и России не имеется официальная статистика о приграничной торговле, что не дает возможности более точно оценить ситуацию; основная часть приграничных торговых операций должна быть отражена в статистике внешней торговли. Еще в 2000 г. было подписано Соглашение о принципах сотрудничества между аймаками Монголии и субъектами РФ. Однако основные положения соглашения во многом носят декларативный характер: власти российских областей и монгольских аймаков слабо заинтересованы в развитии приграничной торговли.

В этом отношении определенным шагом вперед стало парафирование проекта Соглашения между правительствами Монголии и Российской

⁴ Евразийский экономический союз. URL: <http://www.eaeunion.org> (дата обращения 30.06.2018).

Федерации о содействии межрегиональному и приграничному сотрудничеству; и оно состоялось в Москве 28 февраля 2018 г. в ходе 21-го заседания Монголо-Российской Межправительственной комиссии. Однако в деле углубления межрегионального сотрудничества и приграничной торговли по-прежнему существует ряд нерешенных вопросов: увеличение пропускной способности контрольно-пропускных пунктов (КПП) на границах двух стран, придание региональным КПП полноценного статуса, усиление контроля за качеством товаров, особенно за качеством пищевых и мясных продуктов, чтобы соответствовали ветеринарно-санитарным требованиям со стороны России.

Для жителей приграничных районов необходимо упростить выдачу многократных виз и снять ограничения на передвижение транспортных средств. Решение этих и других вопросов, связанных с развитием приграничной торговли, может активизировать движение к развитию свободных экономических зон на приграничных территориях наших стран – например, развитию Свободной экономической зоны (СЭЗ) «Алтанбулаг» в районе сомона Алтанбулаг Селенгийского аймака, расположенного на монгольско-российской границе. В настоящее время администрация СЭЗ «Алтанбулаг» заключила инвестиционные договоры с более чем 60 компаниями России, Японии, США, КНДР и сдает в аренду около 400 га земли; так, Республика Бурятия арендует в Алтанбулаге 14 га земли. С созданием свободной экономической зоны «Алтанбулаг» формируется новая среда для развития приграничной торговли с Россией.

Для Монголии одна из основных проблем в сотрудничестве с регионами России лежит в области взаимных расчетов. У малого бизнеса не хватает валютных средств для осуществления приграничных торговых операций. Наше предложение: производить некоторые расчеты в приграничной и региональной торговле в национальных валютах наших стран. Для этого необходимо заключить межправительственное соглашение о применении национальных валют, в частности рубля, в некоторых торговых расчетах, осуществляемых между хозяйствующими субъектами двух государств. С монгольской стороны и индивидуальные предприниматели, и юридические лица готовы к расчетам в рублях. Между тем использование и рубля, и тугрика еще больше увеличило бы взаимный торговый оборот. Самый главный вопрос – установить порядок расчетов в национальных валютах в рамках приграничной торговли: важно, чтобы приграничные торговые отношения уже отошли от бартера, и их надо бы развивать дальше.

Третье направление – введение безвизового режима, давшее сильный толчок расширению торгово-экономического сотрудничества, особенно приграничной торговли. С начала 2015 г. наблюдается рост товарооборота Монголии с Иркутской областью и Республикой Бурятия. В соответствии с Соглашением между Правительством РФ и Правительством Монголии об условиях взаимных поездок граждан от 14 ноября 2014 г. безвизовый взаимный въезд разрешается продолжительностью не более одного месяца. Благодаря

безвизовому режиму туристический поток из Монголии в летнее время в соседние регионы России резко возрастает. До этого монгольские бизнесмены в основном привозили товары массового спроса и продукты питания из приграничного китайского города Эрлянь (монг. Эрээн). В настоящее время торговые маршруты изменились в сторону России, резко возрос поток пассажиров через границу, и главный пропускной пункт с Монголией «Кяхта» не справляется с повышенной нагрузкой. С введением безвизового режима расширяется прямое сотрудничество между отдельными субъектами двух стран: между столицами Улаанбаатаром и Москвой; Селенгийским и Хэнтийским аймаками и Республикой Бурятия; Дорнодским аймаком и Забайкальским краем и т.д.

Уверен, что развитие межрегионального и приграничного сотрудничества выведет интеграционные процессы между Монголией и Россией на качественно новый уровень. Например, Монголия готова поставлять мясную продукцию по всей территории РФ, а не только в соседние регионы. Об этом Правительство Монголии официально заявило на Красноярском экономическом форуме в апреле 2018 г. В настоящее время главными потребителями поставляемого из Монголии мяса являются Бурятия, Забайкальский край и Иркутская область; ведутся переговоры о расширении квот на поставки монгольской говядины в РФ. По данным Национального статистического комитета Монголии, поголовье скота в Монголии достигло в 2017 г. рекордного количества – 66,2 млн голов.

Развивая торговлю продукцией животноводства, Монголия работает над привлечением инвестиций в освоение двух крупных месторождений – медно-золотого Оюу Толгой⁵ и угольного Таван Толгой⁶ на юге Монголии. Таким образом на юге страны могут сформироваться новые промышленные районы, что открывает возможности для развития межрегионального сотрудничества не только с Россией, но и с КНР.

Четвертое направление. Монгольскому бизнесу не хватает контактов для установления связей с российским рынком, поэтому с такой задачей могут справиться форумы и ярмарки. Проведение на постоянной основе форумов регионального сотрудничества с привлечением политиков, бизнесменов и работников пограничной, таможенной и ветеринарной служб может способствовать интеграционным проектам. Как известно, общая протяженность Монголо-Российской границы составляет 3485 км, и восемь монгольских аймаков граничат с Россией. С российской стороны в приграничной торговле ведущие места занимают Иркутская область, республики Бурятия, Алтай, Тыва и Забайкальский край.

⁵ Оюу Толгой («Бирюзовый холм»). Оцененные запасы – 35,8 млн. тонн меди и почти 2,8 тыс. тонн золота (данные 2010 г.). Сейчас основным акционером компании “Turquoise Hill Resources” (Оюу Толгой) является австрало-британский горнодобывающий гигант “Rio Tinto”, который выкупил контрольный пакет акций у канадской компании “Ivanhoe Mines” и в настоящее время владеет 66 процентами акций, остальные 34 процентов – у правительства Монголии.

⁶ Угольное месторождение Таван-Толгой («Пять холмов») является крупнейшим из неосвоенных в мире: его запасы составляют около 6 млрд. тонн угля, из них 40 процентов – коксующийся уголь.

Сейчас на Монголо-Российской границе имеется 16 КПП, четыре из них работают временно. Из постоянных 12 только три имеют международный статус, остальные – двусторонний. Самый загруженный пункт Алтанбулаг–Кяхта (авто)–Селенгинский аймак (международный); Наушки–Сухэ-Батор–Наушки (ж/д),–Селенгинский аймак (международный). Именно последний контрольно-пропускной пункт нуждается в реконструкции и модернизации. Со стороны Западной Монголии действует только один пограничный переход – многосторонний автомобильный пункт пропуска КПП «Цаган-Нуур»–«Ташанта» со стороны Республики Алтай, все иные переходы на территорию России и обратно не имеют международного статуса. В связи с этим предлагается изучить возможности повышения статуса контрольно-пропускного пункта «Арц Суурь» со стороны Завханского аймака Монголии и «Цагаан-Толгой» со стороны Республики Тыва от двустороннего до международного.

Пятое направление. Монголия рассчитывает на участие в реализации инициативы Китая «Один пояс, один путь». В настоящее время Монголия и Россия официально поддержали этот проект и подписали итоговый документ по этому вопросу. 24 июня 2016 г. в Ташкенте на саммите ШОС между РФ, КНР и Монголией было подписано Соглашение о создании экономического коридора Китай-Монголия-Россия. Программа создания такого коридора [4] предусматривает взаимодействие по следующим основным направлениям: взаимосвязанное развитие транспортной инфраструктуры; улучшение работы пограничных пунктов пропуска, совершенствование таможенного контроля; активизация промышленно-инвестиционного и торгово-экономического сотрудничества; расширение гуманитарных обменов; укрепление сотрудничества в сфере окружающей среды и экологии, а также продвижение регионального и приграничного сотрудничества.

Правительство Монголии должно встроить своей собственный проект «Степной путь»⁷ в глобальные проекты: «Один пояс, один путь» и экономический коридор Россия-Монголия-Китай. Активное участие в их реализации предполагает превращение территории Монголии в транзитное пространство между Россией и Китаем. Безусловно, все это повлечет за собой приток инвестиций в прилегающие регионы, усилит процессы регионального экономического развития и сотрудничества.

В программе создания экономического коридора центральное место занимает вопрос о реализации проекта №1 «Комплексная модернизация и развитие Центрального железнодорожного коридора» (Улан-Удэ–Наушки–Сухэ-Батор–Улан-Батор–Замын-Уд–Эрлянь–Уланчаб–Чжанцзякоу–Пекин–Тяньцзинь). Недостаточные мощности монголо-российского совместного акционерного общества «Улан-Баторская железная дорога» (АО «УБЖД») препятствуют реализации ее транзитного потенциала, из-за чего Монголия теряет большие возможности. Согласно статистическим данным, в 2016 г. из

⁷ Проект Монголии «Степной путь» переименован в «Путь развития».

Китай через Казахстан были произведены грузоперевозки 1700 контейнеров, через Маньчжурию – 1200, а через Монголию – всего 170⁸. Между тем транзит через территорию Монголии на 1135 км короче, чем через маньчжурский железнодорожный путь, связывающий Европу с Китаем, и на 1600 км короче, чем казахстанский. В рамках реализации проекта № 1 Программы «Комплексная модернизация и развитие Центрального железнодорожного коридора» увеличение пропускной способности Улан-Баторской железной дороги – первостепенная задача акционерного общества «УБЖД» и соответствующих министерств Монголии и РФ.

Во время визита президента РФ В.В.Путина в Монголию 2 сентября 2014 г. в Улаанбаатаре было подписано «Соглашение о стратегическом партнерстве по модернизации и развитию Улан-Баторской железной дороги», где было предусмотрено увеличить пропускную способность УБЖД до 100 млн. тонн в год путем строительства второго пути и электрификации. В настоящее время по линии Монголо-Российской межправительственной комиссии ведется согласование проекта Соглашения об условиях транзитных железнодорожных перевозок грузов между Россией и Монголией. Кроме того, благодаря этому соглашению будут созданы облегченные условия для процедур пересечения государственной границы при использовании железнодорожного транспорта.

Предложение Президента Монголии Халтмаагийн Баттулга, озвученное во время Восточного экономического форума во Владивостоке в 2017 г., о предоставлении монгольским компаниям права транспортировки угля через российскую территорию до порта Восточный, с тем чтобы монгольский уголь шел на рынки Японии и Южной Кореи, вписывается в контекст реализации Соглашения о создании экономического коридора Россия-Монголия-Китай и вызвало полное понимание российской стороны.

В 2004 г. Монголия присоединилась к Азиатской автодорожной сети и взяла на себя обязательство построить автомагистраль через свою территорию. Межправительственное соглашение о международных автомобильных перевозках по сети азиатских автомобильных дорог между РФ, КНР и Монголией было подписано 8 декабря 2016 г. в Москве. Согласно соглашению, стороны предоставляют перевозчикам право на осуществление международных автомобильных перевозок по территориям этих государств транспортными средствами, зарегистрированными на территории государства одной из сторон. В настоящее время соответствующие министерства РФ, КНР и Монголии активно работают над конкретными вопросами по реализации соглашения об автодорожной сети Азии с тем, чтобы открыть движение по новому автомобильному коридору Россия-Монголия-Китай уже во второй половине 2018 г. Как известно, вдоль Трансмонгольской железнодорожной магистрали уже существует автомобильная дорога, и в рамках Программы создания

⁸ Один пояс, один путь. Смогут ли монголы ухватиться за инициативу? (One Belt and one Road. Will the Mongols be able to grasp this initiative? Ulaanbaatar) // Монголия сегодня. 16.05.2017. URL: http://news.mongolnow.com/16_05_a01.html (дата обращения 30.06.2018).

экономического коридора прорабатывается проект строительства современной скоростной автомагистрали АН-3 сети азиатских автодорог (Улан-Удэ–Кяхта–Алтанбулаг–Дархан–Улан-Батор–Сайншанд–Замын-Уд–Эрлянь–Внешний Пекин–Тяньцзинь). Существуют планы строительства автодороги, напрямую связывающей свободную экономическую зону «Алтанбулаг» (Монголия) и Кяхту (РФ), что даст импульс для активизации приграничной торговли сопредельных монгольских аймаков и субъектов России (город Дархан и Селенгийский аймак Монголии и Республика Бурятия и Иркутская область РФ).

Шестое направление. Для Монголии расширение сотрудничества с Россией в социальной и гуманитарной сферах, образовании, науке, медицине и ветеринарном обслуживании остаются приоритетными направлениями. Основы современного образования, науки, культуры, медицины и ветеринарии в Монголии были созданы именно с помощью Советского Союза. Конечно, после 1990-х гг., когда Монголия перешла на рыночные отношения, произошли большие изменения в социально-экономической и политической структуре общества, но в социальной и гуманитарной сферах в основном было сохранено ядро кадров, получивших советское образование.

Сегодня в Монголии не хватает специалистов со знанием русского языка. Русский язык в Монголии до сих пор популярен, его изучают сотни тысяч учащихся общеобразовательных школ и студентов вузов. Правительство РФ почти каждый год увеличивает квоту на обучение монгольских студентов в российских вузах, например, в 2018/19 учебном году квота увеличена до 500 государственных стипендий [5], что на 50 человек больше по сравнению с предыдущим учебным годом. В Монголии действуют филиалы российских вузов, в том числе Российского экономического университета им. Г. В. Плеханова, Восточно-Сибирского университета и др. В них обучаются сотни монгольских студентов.

Развитие научного сотрудничества – один из приоритетов в отношениях между двумя странами. РАН оказывает содействие в исследовании недр Монголии, в подготовке высококвалифицированных кадров в области сейсмологии, геологии, географии, лесоведения и других направлений. Под эгидой ЮНЕСКО монгольские и российские ученые активно работают над изучением кочевой цивилизации. Следует подчеркнуть, что для развития экономики Монголии важное значение имеют научные и практические результаты деятельности совместных экспедиций на территории Монголии – комплексной биологической, палеонтологической, геологической, археологической и историко-культурной. Совместные достижения ученых наших стран носят еще и прикладной характер, способствуют развитию экономики Монголии и внедрению новшеств в народное хозяйство. Большую пользу для Монголии может принести совместное исследование процесса опустынивания Центральной Азии, проблем сохранения и восстановления водно-болотных угодий, совместное исследование и использование космического пространства.

В дополнение к факторам, способствующим развитию экономического сотрудничества, следует назвать и причины, тормозящие это сотрудничество. К ним относятся, в первую очередь, низкая диверсификация монгольского экспорта, слабо развитая транспортная инфраструктура страны, особенно северных и западных аймаков Монголии, сопредельных с Россией, низкая платежеспособность и нехватка валютных средств у многих предприятий и аймаков – потенциальных экономических партнеров России. Кроме того, наиболее значимые факторы, препятствующие развитию эффективного экономического сотрудничества Монголии с Россией, лежат непосредственно вне плоскости экономических отношений. Это внутренняя политическая нестабильность в Монголии, влияние представителей бизнеса на властные структуры как в Монголии, так и в России, и коррупционные интересы.

Несмотря на это, монголо-российские торгово-экономические отношения расширяются из года в год и имеют значительный потенциал, чтобы выйти на уровень, сравнимый с торговыми отношениями между странами ЕАЭС.

Литература / References:

- [1] Моломжамц Д. *Финансово-кредитная система Монголии*. М., 2017
[Molomjamts D. *Financial and Credit System of Mongolia*. Moscow, 2017].

Электронные ресурсы:

- [2] Баабар: Надад ийм мөрөөдөл байна [У меня есть такая мечта] // *iKon.MN*. 28.03.2018. URL: <https://ikon.mn/n/1976> (дата обращения 30.06.2018).
- [3] Один пояс, один путь. Смогут ли монголы ухватиться за инициативу? (One Belt and one Road. Will the Mongols be able to grasp this initiative? Ulaanbaatar) // *Монголия сегодня*. 16.05.2017.
URL: http://news.mongolnow.com/16_05_a01.html (дата обращения 30.06.2018).
- [4] Программа создания экономического коридора Китай – Монголия – Россия (The Program of China-Mongolia-Russia economic corridor creation) // *Минпромторг Республики Бурятия*. 2016. URL: <http://minpromtorg.govrb.ru/rus-ch-mn.pdf> (дата обращения 30.06.2018).
- [5] Протокол 21-го заседания Российско-Монгольской Межправительственной комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству (28.02.2018, Москва) (Protocol of the 21st meeting of the Russian-Mongolian Intergovernmental Commission for trade, economic, science and technical cooperation, Moscow) // *Посольство Российской Федерации в Монголии*. URL: https://mongolia.mid.ru/vizity/-/asset_publisher/n2MDy92jmPdw/content/v-moskve-proslo-21-e-zasedania-rossijsko-mongol-skoj-mezpravkomissii-po-torgovo-ekonomiceskomu-i-naucno-tehniceskomu-sotrudnicestvu?inheritRedirect=false (дата обращения 30.06.2018).
- [6] Евразийский экономический союз. URL: <http://www.eaeunion.org> (дата обращения 30.06.2018).
- [7] Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. URL: www.nso.mn (дата обращения 30.06.2018).

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Н.Отгонсайхан ¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
D51, F13, F18	Монгол Улс, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь олон жилийн түүхэн уламжлалтай юм. 1923 онд хоёр орны Засгийн газрын хооронд худалдааны анхны хэлэлцээр байгуулж, 1930 онд манай орон импортын барааны 70 гаруй хувийг ОХУ-аас, экспортын барааны 90 орчим хувийг ОХУ-д нийлүүлдэг байсан уламжлал 1990 оныг хүртэл хадгалагдсан. Энэ нөхцөл байдал нь зах зээлийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос огцом өөрчлөгдөж, 2017 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд ОХУ 12.2 хувь, импортод 28.1 хувь, экспортод 0.6 хувьд хүрч, БНХАУ-тай байр нь солигдсон юм. Энэхүү илтгэлд Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байдал, түүнд ОХУ-ын эзлэх байр суурийг судлахыг зорилоо.

1. Оршил

БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд 1923 оны 12 дугаар сард худалдааны анхны хэлэлцээр, “Монгол Улсын Засгийн газар, ЗХУ-ын Засгийн газар хоорондын худалдааны гэрээ”-г 1957 онд урт хугацаагаар байгуулж, уг гэрээгээр худалдааны тааламжтай нөхцөл, төрөл бүрийн хөнгөлөлтийг харилцан олгосон ажээ. Энэхүү гэрээний үндсэн дээр бараа эргэлт, худалдааны төлбөрийн тухай хэлэлцээрийг таван жилээр, худалдааны Протоколыг жил жилээр байгуулан хэрэгжүүлдэг байжээ.

1930 он гэхэд БНМАУ гадаадаас худалдан авдаг барааны 70 гаруй хувийг ЗХУ-аас, экспортод гаргадаг барааны 90 хувийг ЗХУ-д нийлүүлдэг байжээ. Ийнхүү 1990 он хүртэл Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ дийлэнх буюу 80 орчим хувийг эзэлж ирсэн.

1990 оны эхэн үеэс социалист тогтолцоо задарч, улс орнууд нийгэм, эдийн засгийн бүх салбарт өөрчлөлт, шинэчлэлийг хийх замаар зах зээлийн эдийн засаг руу шилжиж эхэлснээр манай хоёр орны өмнө ч энэхүү шинэ нөхцөлд бие биеийн эрх ашгийг хүндэтгэн, эрх тэгш, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх цоо шинэ хуудас нээгдсэн боловч Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд ОХУ-ын эзлэх хувийн жин огцом буурсаар 2017 онд нийт эргэлтэд 12.2 хувь, импортод 28.1 хувь, экспортод 0.6 хувьд хүрч, БНХАУ-тай байр нь солигдсон байна.

¹ Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн профессор. Цахим шуудан: otgonsaikhan32@gmail.com

Сүүлийн жилүүдэд хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг сэргээх олон ажил хийгдэж байна. Хоёр орон 2009 оноос Стратегийн түншлэлийг хөгжүүлж эхэлснээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг хамгийн анх ОХУ-тай тогтоожээ. 2010 оны 12 дугаар сард “Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр”, 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдөр “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хооронд хамтын ажиллагааны тухай санамж бичиг”², 2016 оны 4 дүгээр сард “Монгол Улс, Оросын Холбооны Улс хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”³ байгуулж, 2016 оны 6 дугаар сард ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн ээлжит хуралдааны үеэр “Орос, Монгол, Хятадын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт гарын үсэг зурсан билээ.

Түүнчлэн хоёр улсын төрийн тэргүүн нарын 2017 онд хүрсэн тохиролцоо ажил хэрэг болж, “Монгол-Оросын санаачилга-2018” цуврал арга хэмжээ 2018 оны 6 дугаар сарын 7-нд Улаанбаатар хотноо эхэлж, амжилттай хэрэгжиж байна. Уг арга хэмжээний хүрээнд тарифын болон тарифын бус саадыг арилгахад хоёр орны хууль тогтоох байгууллагууд хамтарч ажиллах талаар яриа эхлүүлсэн юм.

2. Монгол Улсын гадаад худалдаа

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа чухал байр суурь эзэлж, өргөжин тэлсээр байна. Зах зээлийн шилжилтийн эхэн үед гадаад худалдаа уналтад орж, 1991 онд өмнөх онтой харьцуулахад 57 орчим хувиар буурч худалдааны эргэлт 708.9 сая ам.долларт хүрч байсан бол, 1990-ээд оны дунд үеэс тогтвортой өссөн билээ. 2000 онд худалдааны эргэлт анх удаа нэг тэрбум ам.долларт хүрснээс хойш дэлхийн эдийн засгийн хямралын үеийг эс тооцвол тасралтгүй өсч 2003 он гэхэд 1990 оны худалдааны эргэлтэд дөхөж очиж байсан билээ. Үүнээс хойш 2011 онд экспорт 4817.5 сая ам.доллар, импорт 6598.4 сая ам.долларт хүрч, нийт бараа эргэлт өмнөх оноос 5307.3 сая ам.доллар буюу 86.9 хувиар, экспорт 1909.0 сая ам.доллар буюу 65.6 хувиар, импорт 3398.3 сая ам.доллараар буюу 2.1 дахин өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Монгол Улс 2017 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10538 сая ам.доллар, үүнээс экспорт 6201 сая ам.доллар, импорт 4337 сая ам.долларт хүрсэн нь нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2264 сая ам.доллар буюу 27.4 хувь, үүнээс экспорт 1285 сая ам.доллар буюу 26.1 хувь, импорт 979 сая ам.доллар буюу 29.2 хувиар тус тус өсжээ.

Гадаад худалдааны тэнцэл нь 1994-1995 оны боловсруулах үйлдвэрийн сэргэлт, 2006 оны эдийн засгийн өсөлтийг дагуулсан экспортын барааны гадаад зах зээлийн үнийн өсөлтийн оргил үед ашигтай, бусад онуудад алдагдалтай


² Монгол Улс, Евразийн гишүүн орнуудын бүх талын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, худалдааг хөгжүүлэхэд саад болж буй бэрхшээлүүдийг арилгах чиглэлээр хамтран ажиллаж байна.

³ Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тодорхой арга хэмжээ, зорилтууд тусгасан.

гарч, алдагдлын хэмжээ өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2012 онд алдагдлын хэмжээ түүхэндээ байгаагүй өндөр түвшинд буюу 2.4 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 32 хувиар буюу 573.4 сая ам.доллараар, 2010 онтой харьцуулахад 8 дахин өсчээ. Харин 2014 оноос эхлэн Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2017 онд ашгийн хэмжээ 1863 сая ам.долларт хүрч 2016 оноос 19.6 хувиар өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан гол шалтгаан нь эрдэс бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспортын хэмжээ өссөнтэй холбоотой юм (Зураг 1).

Зураг 1

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт
(сая ам.доллар 1990-2017 он)



Эх сурвалж: 1212.mn

2017 онд экспорт өмнөх оныхоос 26.1 хувиар өсч, Монгол Улсын түүхэнд хамгийн өндөр буюу 6201 сая ам.долларт хүрсэн байна. Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлт, тоо хэмжээ зэргээс нийт экспортын хэмжээ шууд хамааралтай юм. 2017 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос 41.6 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортоос ихээхэн хамаарч байгаа юм. Тухайлбал, 2017 онд нүүрсний экспорт 33.1 сая тн буюу 2256.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оныхоос 7.6 сая тн-оор буюу 1284.9 сая ам.доллараар нэмэгджээ. 2016 онд 1 тн нүүрсний дундаж үнэ 37.8 ам.доллар байсан бол 2017 онд 68.4 ам.доллар болж өссөн юм.

2017 онд махны экспорт 29.3 тн-д хүрч, өмнөх оноос 3.3 дахин өссөн бөгөөд сүүлийн хоёр жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний экспортын 89 хувийг зөвхөн адууны махны экспорт эзэлж байна. 2017 онд 26.1 мянган тонн адууны мах экспортолсон нь 2016 оныхоос 18.1 мянган тн-оор нэмэгдсэн ажээ.

Импортын бүтцийг авч үзвэл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, бензин, дизелийн түлш, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл 90 гаруй хувийг эзэлдэг.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт болон олборлолт нэмэгдэж байгаа нь дизель түлшний импортын хэмжээг нэмэгдүүлэх гол шалтгаан болж байна. Тухайлбал, 2017 онд дизель түлшний импорт 805.3 мянган тн-д хүрч 2016 оныхоос 279.6 мянган тн-оор буюу 184.2 сая ам.доллараар өссөн бол нэг тн дизель түлшний импортын дундаж үнэ 531.3 ам.долларт хүрч өмнөх оноос 67.8 ам.доллар буюу 14.6 хувиар өсчээ.

2017 онд бүх төрлийн тээврийн хэрэгслийн импорт 622.7 сая ам.долларт хүрч 2016 оныхоос 187.1 сая ам.доллараар өссөн бөгөөд суудлын автомашин 48870 ширхэг, ачааны автомашин 14155 ширхэг орж ирсэн нь өмнөх онтой харьцуулахад 11135 болон 7319 ширхгээр тус тус өссөн байна.


3. Монгол Улсын ОХУ-тай хийж буй худалдаа

Зах зээлийн харилцаанд шилжихээс өмнө Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд ЗХУ-тай хийх худалдаа 80 гаруй хувийг эзэлж байсан бол 1995 онд 32 хувь хүртэл огцом буурснаас хойш 2008 оныг эс тооцвол дэлхийн эдийн засгийн хямралын дараа манай орны худалдааны эргэлтэд ОХУ-тай хийсэн худалдааны эзлэх хувийн жин тогтмол буурч, 2017 онд 12 хувь, экспортод 0.6 хувь, импортод 28 хувийг (Зураг 2) эзэлж байна.

Харин тус оронтой хийх гадаад худалдааны нийт эргэлт 1995 оноос үнийн дүнгээр тогтвортой өсч, 2008 онд 1.3 тэрбум ам.долларт хүрч, анх удаа 1990 оны үеийн 1.23 тэрбум ам.долларын түвшингээс давсан. Хоёр орны гадаад худалдааны эргэлтийг ийнхүү өсөхөд ОХУ-ын экспорт чухал нөлөөтэй байж, манай орны гадаад худалдааны алдагдлыг ихээхэн нэмэгдүүлж, худалдааны нөхцлийг бууруулсан нь тийм ч таатай бус үзүүлэлт юм.

Зураг 2

Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ-ын эзлэх
байр суурь (хувиар)




Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2017. 2018, – Улаанбаатар.

Монгол Улсын ОХУ-тай хийж буй гадаад худалдааны тэнцлийн хувьд зөвхөн 1991 онд 3.1 сая ам.долларын ашигтай гарч байсан бол түүнээс хойш тогтмол алдагдалтай байж, улмаар жил тутам өсөн нэмэгдэж байгаад дэлхийн санхүүгийн хямралын үеэр 964.0 сая ам.доллар хүртэл буурч, харин 2012 онд хамгийн их буюу 1767.8 сая ам. долларын алдагдалд хүрснийг Зураг 3-аас харж болно. Харин ОХУ-аас Монгол Улстай хийж буй гадаад худалдааны тэнцэл байнгын ашигтай байдаг.

Зураг 3

Монгол Улсын ОХУ-тай хийж буй
худалдаа (сая ам.доллар)



Эх сурвалж: 1212.mn

Монгол Улсаас ОХУ-тай хийж буй худалдааны нийт бараа эргэлт 2017 онд 1,284 сая ам.долларт хүрч, импорт 1217.3 сая ам.доллар, экспорт 67.7 сая ам.доллар болсон бөгөөд худалдааны алдагдал 1149.6 сая ам.долларт хүрсэн нь хоёр орны худалдааны эргэлт 2016 онтой харьцуулахад 2017 онд 37 хувиар өссөнийг харуулж байна.


Монгол Улсын ОХУ-тай хийж буй гадаад худалдаа тогтмол алдагдалтай байгаа нь экспортын барааны хувьд тээврийн зардал өндөр, ОХУ-ын талын тарифын болон тарифын бус саад тогтор, манай орны мах, махан бүтээгдэхүүнд тавьж буй хорио цээртэй холбоотой бөгөөд манай орны экспортын барааны өрсөлдөх чадвар сул байгаа нь бас нөлөөлж байна.

Хоёр орны хоорондын худалдааны эргэлтийг сааруулахад олон хүчин зүйл нөлөөлсөн гэж үздэг. Тухайлбал, хоёр орны хооронд өмнө нь тогтсон аж ахуйн болон үйлдвэрлэлийн хэлхээ холбоо, бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ задарсан; хоёр орон хоёулаа бараа, бүтээгдэхүүний хомсдолд орж зах зээлээ нэн тэргүүнд шаардлагатай бараа, бүтээгдэхүүнээр хангах зорилгоор дэлхийн бусад орнуудтай гадаад худалдаа эрхлэх болсон; гадаад валютын нөөцийн хомсдол зэргийг дурдаж болно.

Монгол Улсаас ОХУ-д экспортлож буй гол нэрийн бүтээгдэхүүн нь жонш, мах (80-90 орчим хувь) бөгөөд үлдсэн 10-20 хувийг ноос, ноолууран хувцас, хивс, тэмээ болон хонины ноос зэрэг бүтээгдэхүүн эзэлдэг ба нэмүү өртөг шингэсэн эцсийн хэрэглээний ноос, ноолууран хувцас, эсгий бүтээгдэхүүн болон хивс 2017 онд нийт экспортын 8 орчим хувийг эзэлсэн нь том үзүүлэлт болжээ. Монгол Улсын ОХУ руу экспортолж байгаа барааны нэр төрөл маш цөөн, боловсруулалтын түвшин хангалтгүй байгаа юм.

Зураг 4

Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй үхрийн хөлдүү махны экспортын хэмжээ, үнийн дүн (мян.тн, мян. ам.доллар)




Эх сурвалж: ГЕГ-ын статистик мэдээлэл

Монгол Улсаас ОХУ руу 2017 онд 3.2 мян тн мах (үхэр 0.6, адуу 2.2) экспортолсон нь манай орны махны экспортын 11 хувийг эзэлж байна.

Монгол Улс 2002 онд хамгийн их буюу 15.3 мянган тн үхрийн хөлдүү махыг экспортолж байснаас 99 буюу буюу 15.1 мянган тн нь ОХУ-д ногдож байсан бол 2017 онд үхрийн хөлдүү махыг 100 хувь ОХУ-д экспортолсон ч 0.6 мянган тн болж буурчээ⁴ (Зураг 4).

Зураг 5

Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй адууны махны экспортын хэмжээ, үнийн дүн (мян.тн, мян. ам.доллар)



Эх сурвалж: ГЕГ-ын статистик мэдээлэл

Махны экспортыг нэмэгдүүлэх олон удаагийн хэлэлцээрийн үр дүнд манай орон жилд 60 орчим тн мах экспортод гаргах квот авдаг боловч мал эмнэлгийн зохих шаардлага, хорио цээрийн шаардлага хангахгүй, махны төлбөр тооцоо цаг хугацаандаа хийгдэхгүйгээс болж эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох, үнийн чөлөөт өрсөлдөөн байхгүйн улмаас зарим үед дээрх квотод хүргэж махаа экспортолж чадахгүй байна. Энэ тохиолдолд ОХУ-ын махны лицензтэй импортлогчид лицензээ бусдад зарах, эсвэл манайд өгөгдсөн лицензээр өөр улсаас мах импортлох тохиолдол гарч байдаг.

Монгол махны амт тэжээлэг чанарыг мэдэрч ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын хэрэглэгчид хэрэглэх сонирхол их байдаг боловч махны экспортын хэмжээ бага байгаа нь дараах бэрхшээлээс шалтгаалж байдаг гэдгийг судлаачид үздэг.⁵ Үүнд:

- Мах, махан бүтээгдэхүүний импортын лиценз, зөвшөөрлийг зөвхөн Москвагаас олгодог;
- Манай улсаас оруулж байгаа махыг зөвхөн ОХУ-ын Ариун цэвэр, хорио цээрийн хяналтын байгууллагын хяналтын дор стандартын

⁴ Монгол Улсын үхрийн махны экспорт 2016 онд нийт махны экспортод 7.8 хувийг эзэлж байсан бол 2017 онд 2.0 хувьд хүрч буурсан байна. 2017 онд 0.6 мян. тонн үхрийн махыг 1643.3 мян ам.доллараар экспортолсон нь өнгөрсөн оньхоос 95 тоноор бага боловч үнийн дүнгээр 51.0 мянган ам.доллараар их байна. Энэ хугацаанд 1 тонн үхрийн махны экспортын дундаж үнэ 448.1 ам.доллараар нэмэгдэж 2739 ам.долларт хүрчээ.

⁵ Монгол Улс, ОХУ хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн төслийн үндэслэл, 2012.

- дагуу Улаанбаатар, Дархан, Багахангайн мах комбинатад бэлтгүүлдэг;
- Зөвхөн Сүхбаатар-Наушкийн боомтоор гаргадаг;
 - Төмөр замын тээврээр оруулахыг зөвшөөрдөг гэх мэт бэрхшээл байна.
 - ОХУ-д нийлүүлэх махны экспортыг нэмэгдүүлэхэд манай талаас дараах бэрхшээл тулгарч байна. Үүнд:
 - Малын үржил селект, эрүүлжүүлэх сүлжээ байхгүйн улмаас малыг цаг хугацаанд нь вакцинжуулахад малчдад хөрөнгө байхгүй, тэд өөрсдөө санаачлагагүй ажилладаг;
 - Бэлчээрийн маллагааны мал учраас нэг малаас гарах махны гарц бага, махны бүтцэд булчинлаг хэсгийн хатуу мах илүү их хувийг эзэлдэг;
 - Төр, засгийн зүгээс махны экспортыг нэмэгдүүлэх талаар анхаардаг боловч малыг эрүүлжүүлэх, махны чиглэлийн малыг өсгөж үржүүлэх талаар хөрөнгө, санхүүгийн дэмжлэг бага байгаа зэрэг юм.


Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн малыг вакцинжуулах, эрүүлжүүлэх ажлын хүрээнд ОХУ-тай “Мал эрүүлжүүлэх” төслийг хамтран хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн эхний үе шат буюу 2011-2012 онд малыг эрүүлжүүлэх, мал эмнэлгийн албаны бэлэн байдлын чадавхийг сайжруулахад зориулан ОХУ-аас 375 сая рублийн үнэ бүхий шүлхий өвчнөөс сэргийлэх вакцины 37 сая ш. тун, ариутгал халдваргүйтгэлийн тусгай зориулалтын 22 автомашиныг тус тус нийлүүлсэн байна.

Төслийн II үе шат нь 2017-2018 онд хэрэгжиж байгаа бөгөөд төслийн хүрээнд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцины 4,2 сая тунг хүмүүнлэгийн тусламжаар нийлүүлсэн нь мах, махан бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээлд нийлүүлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тавьж буй хамтын хүчин чармайлтын хүрээнд хэрэгжиж буй дорвитой ажлууд юм.

Одоогийн байдлаар манай орноос ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий 29 аж ахуйн нэгжээс 26 аж ахуйн нэгжийн экспортын эрх идэвхтэй байгаа нь чухал ач холбогдолтой ч ОХУ-д мах импортлох эрхтэй ганцхан Бурятмясопром компани давуу эрхийг эдэлж байна.

Зураг 6

Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй жоншны экспортын хэмжээ, үнийн дүн (мян.тн, мян. ам.доллар)



Эх сурвалж: ГЕГ-ын статистик мэдээлэл

Хайлуур жонш нь манай орны ОХУ-д нийлүүлдэг экспортын хамгийн өндөр хувийг эзэлдэг чухал бүтээгдэхүүний нэг. Энэ төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ 2009 оныг эс тооцвол 2010 он хүртэл нэлээд тогтвортой өсч 272.8 мянган тн, 2011 онд үнийн өсөлт бий болж 66201.8 мянган ам.долларт хүрч байсан бол 2013 оноос огцом буурч 2017 онд биет хэмжээ 184.7 мянган тн, үнийн дүн 47415.8 мянган ам доллар болж, Монгол Улсын нийт жоншны экспортын 5.68 хувь болжээ (Зураг 6).

ОХУ нь экспортын бүтцийн хувьд манай оронтой төстэй буюу байгалийн нөөцөд тулгуурласан бөгөөд нефть, нүүрс, төмөр, ган, хөнгөн цагаан, алт, алмаз, никель, мод зэрэг нь нийт экспортын 60-70 хувийг эзэлж байгаа юм. Эндээс Монголын гаралтай уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-д худалдаалах боломж тааруухан байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн харьцангуй давуу талын индексийн судалгаанаас үзэхэд⁶, ОХУ-ын импортын харьцангуй давуу талтай барааны бүлэгт Монгол Улсын экспортын харьцангуй давуу талтай бараанаас мах, махан бүтээгдэхүүн, жонш орж байгаа учраас эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

“Мал эрүүлжүүлэх” төслийн хүрээнд урт хугацаанд хамтран ажиллаж, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй болов уу. Тухайлбал,

- Мах, сүү, арьс шир, малын гаралтай бүтээгдэхүүн;
- Сүлжмэл эдлэл, хувцас, гутал;
- Хүнсний бүтээгдэхүүн.

⁶ Otgonsaikhan, N. The Current Situation for Mongolian Foreign Trade and Cooperation with Northeast Asian Countries https://www.erina.or.jp/wp-content/uploads/2015/02/se12712_tssc.pdf


Дээрх бүтээгдэхүүнийг ОХУ руу экспортлоход тарифын болон тарифын бус хориг хязгаарлалт ихтэй тул ОХУ, Евразийн эдийн засгийн холбооны зах зээлд тарифын хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх, тарифын бус хүндрэлийг дээрх төслийн хүрээнд даван туулах асуудлаар холбогдох хэлэлцээр байгуулах, ОХУ-ын оролцоотой бүс нутгийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх, харилцан ашигтай түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх нь чухал байна.

ОХУ-аас импортоор авч буй бүтээгдэхүүний 60 гаруй хувь нь бензин, дизелийн түлш байдаг бол 25.0 гаруй хувийг хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн эзэлж байна.

Монгол Улс дизель түлшийг бараг 100 хувь ОХУ-аас импортоор авдаг бөгөөд 2012 онд хамгийн өндөр үнэтэй буюу 890240.2 мянган ам.долларын 775.2 мянган тн түлш (Зураг 7) импортолж байсан бол 2017 онд 423653.6 мянган ам.долларын 796.9 мянган тн түлш импортолсон нь Монгол Улсын нийт дизелийн түлшний импортын 98.9 хувийг эзэлжээ.

Зураг 7

Монгол Улсын ОХУ-аас импортоор авч буй дизель түлшний хэмжээ, үнийн дүн, Монгол Улсын дизель түлшний импортод ХУ-ын эзлэх хувийн жин



Эх сурвалж: ГЕГ-ын статистик мэдээлэл

Монгол Улс 2005 он (77.7 хувь), 2013 он (59.5 хувь)-оос бусад онд авто бензиний 90-ээс дээш хувийг ОХУ-аас импортоор авч байсан ажээ. 2012 онд хамгийн өндөр үнэтэй буюу 407830 мянган ам.долларын 336.5 мянган тн бензин (Зураг 8) импортолж байсан бол 2017 онд 235331.1 мянган долларын 395 мянган тн авто бензин импортолсон нь Монгол Улсын нийт авто бензиний импортын 96.1 хувийг эзэлжээ.


Үлдэж байгаа хувийг хүнсний бүтээгдэхүүн, бүх төрлийн өргөн хэрэглээний бараа, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн багахан хувийг тус тус эзэлж байна.

Манай орны газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээ тогтмол өсөж байгаа нь сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөнөөр гадаадын хөрөнгө оруулалтыг ихээхэн татах болж, геологи хайгуулын ажил, орд газрын ашиглалт, олборлолтын хэмжээ нэмэгдсэнээс гадна бүхий л төрлийн тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Монгол Улсын стратегийн бүтээгдэхүүн болох бензин, дизелийн түлшний хэрэгцээний 95-аас дээш хувийг зөвхөн ОХУ-аас авч байгаа нь эдгээр төрлийн бүтээгдэхүүний хувьд тус улсаас хэт их хамааралтайг харуулж байна.

Зураг 8

Монгол Улсын ОХУ-аас импортоор авч буй авто бензиний хэмжээ, үнийн дүн, Монгол Улсын дизель түлшний импортод ОХУ-ын эзлэх хувийн жин



Эх сурвалж: ГЕГ-ийн статистик

Олон улсын жишгээр стратегийн бүтээгдэхүүний хэрэглээнд импортоор авч буй газрын тосны бүтээгдэхүүн 35.0 хувиас илүү байх, тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний 20-иос дээш хувийг зөвхөн нэг улсаас импортолдог бол уг орон тэр орноос эдийн засгийн хараат болсон гэж үздэг билээ. Гэвч бид энэ төрлийн бүтээгдэхүүний хамаарлыг багасгах, газрын тос боловсруулах үйлдвэр барих талаар олон жил ярьж байгаа боловч одоогоор амжилтанд хүрээгүй л байна.

4. Дүгнэлт

Хоёр орны худалдаанд амжилт ололт их байсан ч дутагдалтай, хүндрэлтэй, шийдвэрээ хүлээсэн олон асуудал байсаар байна.

Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүд нь манай хоёр орны худалдаанд шинэ гарц, шийдэл, боломжийг олгох магадлалтай. Тухайлбал, хөрш гурван орны эдийн засгийн коридорын хүрээнд тээвэр,

ложистикийн дэд бүтэц сайжирч, олон улсын түвшинд хүрч чадвал Монгол Улс нь Зүүн Ази-Европыг холбосон чухал тээврийн коридор болох боломжтой. Ингэснээр үйлдвэрлэлийн салбарт өндөр технологи, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, түүхий эд, эрдэс баялгаа өндөр түвшинд боловсруулан хөрш хоёр орны зах зээл болон бусад гуравдагч зах зээлд нийлүүлэх боломж ч бий болно.

Транзит тээврийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд ОХУ-тай хил, гааль, тээврийн зангилаа, ложистик болон терминалын үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамтарч ажиллах зайлшгүй шаардлага байна.

Түүнчлэн ОХУ нь Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний гол зах зээл учраас “Мал эрүүлжүүлэх” төслийн III үе шатыг хэрэгжүүлэх талаар санал хүргүүлж, урт хугацаанд хамтран ажиллах замаар малыг эрүүлжүүлэн мах, сүү, арьс шир болон малын гаралтай бүтээгдэхүүн; сүлжмэл эдлэл буюу хувцас, гутал; хүнсний бүтээгдэхүүн зэрэг эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд юуны түрүүнд анхаарах нь зүйтэй.

Дээр дурдсан малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг ОХУ руу экспортлоход тарифын болон тарифын бус хориг хязгаарлалт ихтэй тул ОХУ, Евразийн эдийн засгийн холбооны зах зээлд тарифын хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх, тарифын бус хүндрэлийг хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх хэрэгтэй юм.

ОХУ-ын оролцоотой бүс нутгийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх, харилцан ашигтай түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх нь чухал байна.

Ном зүй:

- [1] Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн төслийн үндэслэл. судалгааны тайлан. (2012) МУИС-ийн хэвлэх үйлдвэр, – 9.4 хх.
- [2] Батнасан Н, Отгонсайхан Н, Нарандалай Д. (2012). “Худалдааны гол түнш орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл” бодлогын судалгаа BS 12/15.
- [3] Отгонсайхан Н., Даваасүрэн А. (2010). Орос-Монголын хоорондын худалдаанд тулгамдаж буй асуудал. Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “*Олон улс судлал*” сэтгүүл. – Улаанбаатар, – № 1-2 (87, 88 дахь тал).
- [4] Otgonsaikhan N. (2015). The Current Situation for Mongolian Foreign Trade and Cooperation with Northeast Asian Countries // The Economic Research Institute for Northeast Asia (ERINA) report, No. 127, P.8-14.
- [5] Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэл
URL: <http://customs.gov.mn/statistics/>
- [6] Монгол Улсын ХХААХҮЯ-ны цахим хуудас
URL: <http://mofa.gov.mn/exp/article/entry/1159>
- [7] Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан
URL: https://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L14&type=tables
- [8] Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны цахим хуудас
URL: http://embassymongolia.ru/?page_id=1901
- [9] Олон улсын худалдааны төвийн цахим хуудас
URL: <https://www.trademap.org/Bilateral>

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ДАХЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

Сорокина Е.М.¹, А.Өнөржаргал²

JEL ангилал:

H87, M16, M41

Түлхүүр үг:

нягтлан бодох
бүртгэлийн тайлан,
санхүүгийн тайлан,
нэгтгэсэн тайлан,
мэдээллийн чанар

Хураангуй:

Энэхүү илтгэлд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын ОХУ дахь хэрэглээний өнөөгийн байдлыг авч үзлээ. Эрх зүйн орчин, социологийн судалгаанд үндэслэн ОХУ-д СТОУС-ыг нэвтрүүлэх хоёр үе шатыг тодорхойлсон бөгөөд эдгээр үе шат тус бүрд үүссэн нөхцөл байдал, хийгдсэн ажлууд, үр дүнг дүгнэсэн юм. Тухайлбал, эхний шатанд ОХУ-ын компаниуд өөрсдийн санаачлагаар АНУ-ын стандарт буюу “Generally Accepted Accounting Principles (GAAP)”-ыг баримтлах хандлага байсан бол ОХУ-ын Засгийн газар 2011 оноос СТОУС-ыг албан ёсоор хүлээн зөвшөөрснөөр зарим аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартад нийцсэн тайланг заавал бэлтгэх үүрэгтэй болжээ. Мөн ОХУ-д СТОУС-ыг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал, олон улсын стандартын ач холбогдол, давуу талын талаар хэрэглэгчийн сэтгэл ханамж зэргийг авч үзлээ.

ОХУ-д Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ыг нэвтрүүлэх ажил 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн бөгөөд энэхүү үйл явц хоёр үе шатаар хэрэгжиж байна гэж үзэж байна. Эхний шатанд 1992-2010 оныг хамруулж болох бөгөөд бөгөөд энэ үеийг “**төслийн үе**” гэж, харин хоёрдугаар шат нь 2011 оноос эхэлсэн ба энэ үеийг “**эрх зүйн төлөвшилийн үе**” гэж нэрлэж болно. СТОУС-ыг нэвтрүүлэх **эхний шатанд** төр захиргааны байгууллагаас дараах хэд хэдэн баримт бичгийг баталсан байна. Үүнд:

- 1992 онд ОХУ-ын Дээд зөвлөлөөс “Нягтлан бодох бүртгэл, статистикийн тогтолцоонд олон улсын практикийг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”;
- 1997 онд ОХУ-ын Сангийн яамны арга зүйн хороо, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгчийн хамтарсан “Зах зээлийн эдийн засгийн нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлал” баримт бичиг;
- 1998 онд ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор “Нягтлан бодох бүртгэлийг СТОУС-д нийцүүлэн шинэчлэх” хөтөлбөр;

¹ Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор, ОХУ-ын Эрхүү хотын Байгалын улсын их сургуулийн Эдийн засаг, удирдлагын сургуулийн орлогч захирал. Цахим шуудан: SorokinaEM@bgu.ru

² Эдийн засгийн ухааны доктор, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш. Цахим шуудан: a.unur@yahoo.com

- 2004 онд ОХУ-ын Сангийн сайдын тушаалаар “ОХУ-д нягтлан бодох бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох дунд хугацааны үзэл баримтлал”-ыг тус тус баталсан ажээ.

Эдгээр баримт бичиг нь үндэсний бүртгэл, тайлагналыг тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэхэд чиглэсэн бөгөөд эхний жилүүдэд ОХУ-ын компаниуд олон улсын хөрөнгийн биржийн нэгэн адилаар АНУ-ын үндэсний стандарт болох Generally Accepted Accounting Principles (GAAP)–ыг баримтлах чиг хандлагатай байсан бол харин 1990-ээд оны сүүлээс эхлэн СТОУС-ыг нягтлан бодох бүртгэл, тайлангийн шинэчлэлийн үндсэн удирдамж гэж үзэх болсон ажээ. Дээрх төсөл, хөтөлбөрт СТОУС-ыг хэрэглэхийг уриалж байсан боловч заавал хэрэглэхийг шаардахгүй байсан тул ихэвчлэн гадаадын хөрөнгө оруулалттай томоохон компаниуд сайн дурын үндсэн дээр санхүүгийн тайлангаа СТОУС-д нийцүүлж бэлтгэж ирсэн байна. 2011 онд Засгийн газрын тогтоолоор “СТОУС ба Тайлбаруудыг хүлээн зөвшөөрөх тухай” тогтоол батлагдсан нь ОХУ-д СТОУС-ыг нэвтрүүлэхэд үндсэн өөрчлөлт болж энэхүү ажил *хоёр дах шатанд* шилжсэн ажээ. Энэхүү журамд зааснаар “хүлээн зөвшөөрөх” гэсэн ойлголтод СТОУС-ын Олон улсын сангаас СТОУС-ыг албан ёсны эрхтэйгээр худалдан авах, ОХУ-д ашиглагдах стандартыг орчуулах, ашиглах нөхцлийг тодорхойлж, хэвлэх ажил оржээ. Энэхүү ажилд төр засгийн болон мэргэжлийн олон нийтийн байгууллагын үүрэг, хариуцлага, оролцоог доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1

ОХУ-д СТОУС-ыг нэвтрүүлэх институцийн үндсэн бүтэц

Байгууллагын нэр	Гүйцэтгэж буй үүрэг
ОХУ-ын Сангийн яам	ОХУ-ын нутаг дэвсгэрт СТОУС-ыг мөрдөх, эсвэл мөрдөхгүй байх шийдвэр гаргах, энэ талаар өөрийн албан ёсны сайтаар мэдээлэх.
ОХУ-ын Сангийн яамны дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал ба аудитын үйл ажиллагааг зохицуулах алба	СТОУС-ыг мөрдөх талаарх баримт бичгийн эхийг бэлтгэх; СТОУС-ыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.
ОХУ-ын Санхүүгийн бүртгэл ба тайлагналын стандартын үндэсний сан (НСФО)	СТОУС-ын албан ёсны орчуулгыг ажлыг зохион байгуулах; СТОУС-ыг нэвтрүүлэх төслүүдэд оролцох.
ОХУ-ын Төв банк	СТОУС-ыг нэвтрүүлэх төслүүдэд оролцох.
ОХУ-ын СТОУС-ыг хэрэгжүүлэх салбар хоорондын ажлын хэсэг	СТОУС-ыг хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлуудыг шийдвэрлэх, энэ талаар тайлбар, зөвлөмж бэлтгэх; СТОУС-ын хэрэглээний талаар мэдээллүүдийг нэгтгэх, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх; СТОУС-ын санд ОХУ-ыг төлөөлөх ажлыг зохицуулах.

ОХУ-ын Мэргэшсэн нягтлан бодогч, аудитууудын хүрээлэн, судалгааны байгууллага	СТОУС-ын сургалтын хөтөлбөрүүд боловсруулах; СТОУС-ын багш бэлтгэх, гэрчилгээ олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах; СТОУС-ын талаар сургалтын материал бэлтгэх; Энэ талаар төрийн захиргаа, бизнесийн, мэргэжлийн олон нийтийн болон сургалтын байгууллагатай хамтран ажиллах.
---	---

Эх сурвалж: Судлаачийн тооцоогоор

2011 онд батлагдсан энэхүү журмаар ОХУ-д олон улсын 37 стандарт, 26 тайлбарын хамт хэрэглэх шийдвэр гаргажээ. Гэхдээ бүх аж ахуйн нэгжийг санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу гаргахыг шаардаагүй бөгөөд 2010 онд гарсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын тухай” хуульд заасан аж ахуйн нэгж, байгууллага (банк, санхүү, даатгалын байгууллага, хөрөнгө оруулалтын болон төрийн бус тэтгэврийн сан, клирингийн байгууллагууд, хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргасан төрийн болон хувийн өмчийн компани)-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхийг шаарджээ. Гэхдээ энэ журмыг тодорхой үе шаттайгаар мөрдөх, тухайлбал банк, санхүү, даатгалын байгууллага 2012 оны санхүүгийн тайланг 2013 онд багтааж, бусад байгууллага 2015 оны санхүүгийн тайланг 2016 онд багтааж, СТОУС-ын дагуу бэлтгэж толилуулахаар заасан байна. Харин улсын секторын олон улсын стандартын хувьд орос хэлнээ орчуулж, энэ салбарын үндэсний стандарт бэлтгэхэд удирдамж болгон ашиглаж байна.

Өнөөгийн байдлаар ОХУ-д “Санхүүгийн (нэгтгэсэн) тайлан”, “Нягтлан бодох бүртгэлийн (санхүүгийн) тайлан” гэсэн хоёр төрлийн тайлан бэлтгэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. “Нягтлан бодох бүртгэлийн тайлан” бол оросын аж ахуйн нэгж, байгууллагын хийдэг уламжлалт тайлан бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэгтэй бүх хуулийн этгээд энэхүү тайланг гаргадаг.

Харин СТОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-д заасны дагуу олон улсын стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан нь өөрсдийн хэрэгцээг хангах зорилгоор тусгайлсан мэдээлэл авах шаардлагагүй хэрэглэгчдэд зориулагддаг. Хэдийгээр санхүүгийн тайлан нь бүх төрлийн хэрэглэгч (хөрөнгө оруулагч, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, төрийн байгууллага, ажилтан, албан хаагч, зээлдүүлэгч, олон нийт)-д зориулсан боловч тэдний тус бүрийнх нь мэдээллийн тухайлсан хэрэгцээг хангаж чаддаггүй юм. Учир нь хэрэглэгч тус бүрийн санхүүгийн мэдээллийг ашиглах зорилго өөр байхаас гадна бүр эсрэг тэсрэг зорилготой ч байж болно. Жишээлбэл, хөрөнгө оруулагчийн хувьд бизнесийн эрсдэлийг үнэлэхэд чиглэсэн болон үр ашгийн үзүүлэлт чухал байдаг бол татварын байгууллага нь татвар ногдуулах орлогын хэмжээг чухалчилж үздэг. Харин СТОУС нь үндсэндээ хөрөнгө оруулагчдын хэрэгцээг хангахад чиглэж бүртгэлийн асуудлыг биш тайлагналын асуудалд чиглэгддэг, өөрөөр хэлбэл нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн үүргийг илүүд авч үздэг. Гэтэл нягтлан бодох бүртгэлийн үндсэн үүрэг бол түүний хяналтын үүрэг билээ.

1990-ээд оноос өмнө ОХУ-ын аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч байгаагүй, санхүүгийн тайланг зөвхөн татварын зорилгоор бэлтгэж байсантай холбоотойгоор нягтлан бодох бүртгэл нь хяналтын үүргээ гүйцэтгэж ирсэн түүхэн уламжлалтай юм. Бүртгэл, тайлагналын зохицуулалтын баримт бичиг нь татварын бүртгэл, тайлагналд зориулагдсан бөгөөд хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах талаарх нягтлан бодох бүртгэлийн үүргийг орхигдуулж ирсэн. Татварын тооцоолол, тайлагналыг буруу хийснийхээ төлөө аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцлага хүлээж байгаа боловч хэрэглэгчийн мэдээллийн хэрэгцээг бүрэн хангаагүйн төлөө хүлээх хариуцлага байхгүй байгаа билээ.

ОХУ-ын компаниуд санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу бэлтгэхэд дараах хүндрэл, бэрхшээл байна:

- СТОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэж, гадаадын хөрөнгө оруулагчдад танилцуулахад стандартын албан ёсны хэл болох англи хэл дээрх эхийг бүрэн ойлгосон байх шаардлагатай. СТОУС-д шилжих шийдвэр гарсан эхний үед судалгаанд хамрагдсан 2000 нягтлан бодогчийн 400 буюу 20 хувь нь СТОУС эзэмшсэн талаар олон улсын гэрчилгээ авсан байсан бол 2013 онд 2763 нягтлан бодогчийн 801 буюу 29 хувь нь энэхүү олон улсын гэрчилгээг авсан, 27 хувь нь сургалтанд сууж байна³ гэсэн судалгаа гарчээ. Эндээс үзэхэд, олон улсын гэрчилгээ эзэмшигчийн тоо өсч байгаа боловч санхүүгийн тайлан бэлтгэх үүрэгтэй нягтлан бодогчийн 44 хувь нь энэхүү гэрчилгээг авч чадаагүй л байна.
- СТОУС-ыг бүрэн эхээр нь орос хэлнээ орчуулсан боловч стандартын агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа нь СТОУС-ыг бодит хэрэглээ болгоход бас нэг саад болж байна.
- Дээр хэлсэнчлэн СТОУС-ыг хөрөнгийн биржид бүртгэлтэй болон нийтийн ашиг сонирхлын компаниудад заавал мөрдөхөөр шаардаж байна. Харин бусад компанийн хувьд СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх нь тооцоолох ажиллагаа, зардал ихтэй болж байна. Учир нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд бизнесийн зөвлөх, үнэлгээч, аудитор, хуульч зэрэг мэргэжилтний үйлчилгээ шаардлагатай юм.
- ОХУ-д тогтсон нягтлан бодох бүртгэлийн зарим нэр томъёоны уламжлалт ойлголт олон улсын стандартаас зөрүүтэй, мөн “бодит үнэ цэнэ”, “биологийн хөрөнгө”, “холбоотой талууд”, “хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө” зэрэг өмнө байгаагүй ойлголт байгаа нь СТОУС-ыг хэрэглэхэд бэрхшээл учруулж байна.
- ОХУ-ын компаниуд олон улсын стандартад нийцсэн тайланг дараах хоёр хэлбэрээр бэлтгэж байна:

³ <http://www.ifrs-professional.com>

- Бүртгэлийн анхан шатны баримт, мэдээнд үндэслэж ОХУ-ын хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлийн тайлан (бухгалтерская отчетность) бэлтгэхийн зэрэгцээ СТОУС-ийн дагуу санхүүгийн тайлан (финансовая отчетность) бэлтгэх;
- ОХУ-ын нягтлан бодох бүртгэлийн талаарх дүрэм журамд нийцүүлэн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тайланг СТОУС-д нийцсэн тайлан болгож хөрвүүлэх;

Судалгаанаас үзэхэд, 2012 онд компаниудын 74 хувь, харин 2016 онд 76 хувь нь санхүүгийн тайланг хөрвүүлэх замаар олон улсын стандартад нийцсэн тайлан бэлтгэж байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн программууд нь ОХУ-ын эрх зүйн орчинд нийцүүлэн хийгдсэн байдагтай ч холбоотой. Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн хөрвүүлж бэлтгэх нь зардал багатай боловч мэдээллийн эрсдэл ихтэй байна. Үүнээс гадна СТОУС-д нийцсэн тайлан нь хэрэглэгчдэд илүү итгэл үнэмшил төрүүлж байгаа нь ОХУ-д хийгдсэн судалгаагаар батлагдахгүй байна. Санхүүгийн тайлангийн 2124 хэрэглэгчийн 19 хувь нь СТОУС-д нийцүүлэн бэлтгэсэн тайлан “*илүү итгэл үнэмшилтэй байна*” гэж, 39 хувь нь “*мэдэхгүй*” гэж, харин үлдсэн 42 хувь нь “*тодорхой ялгаа байхгүй*” гэж үзжээ. СТОУС-д нийцсэн тайлангийн 12 давуу талаас оролцогчийн 67 хувь нь 4 хүртэл давуу талыг хүлээн зөвшөөрсөн бол үлдсэн 8 давуу талыг нийт оролцогчдын 1 хувь нь л тэмдэглэжээ. Энэ хандлага хөгжингүй орнуудад ч ажиглагддаг. ИБУИНВУ ба Уэльсийн мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс Европын Холбооны улсуудад хийсэн судалгаагаар, хөрөнгө оруулагчдын 24 хувь нь СТОУС-д шилжсэнээр мэдээллийн чанар буурсан, 49 хувь нь олон улсын стандартад шилжсэнээр санхүүгийн тайланг ойлгоход хүндрэлтэй болсон⁴ гэж үзсэн байна. Ялангуяа санхүүгийн хэрэглүүр, хойшлогдсон татвар, бизнесийн нэгдлийн асуудал нь хэрэглэгчдийг төөрөгдүүлдэг бөгөөд цахим ертөнцийн бусад мэдээллүүдэд СТОУС-ын эсрэг байр суурь агуулагдах боллоо.

Дүгнэлт

ОХУ нь гадаадын болон үндэсний томоохон хөрөнгө оруулагчдын мэдээллийн хэрэгцээг хангахын тулд СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж, энэ чиглэлээр дорвитой алхмыг хэрэгжүүлж байгаа боловч аж ахуйн нэгж, байгууллага нь олон улсын стандартад нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэх хүсэл сонирхолтой болох, хэрэглэгчдэд итгэл үнэмшил бий болгоход багагүй цаг хугацаа шаардлагатай болох нь харагдаж байна.

⁴ <http://www.monitoring.ru>

Ном зүй:

- [1] Сорокина Е.М. (2016). Возможности и проблемы применения международных стандартов финансовой отчетности в России // *Известия Иркутской государственной экономической академии*. Т.26, № 3, С. 469-477
- [2] Шеремет А.Д., Соловьева О.В. (2009). Проблемы применения Международных стандартов финансовой отчетности: Анализ международного опыта // *Аудит и финансовый анализ*. №1.
URL: <http://www.minfin.ru>
URL: <http://www.ifrs-pofessional.com>
URL: <http://www.monitoring.ru>
URL: <http://www.msfofm.ru>
URL: <http://www.nsfo.ru>
- [3] URL: <http://www.ipbr.org>

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭДИЙН ЗАСГИЙН БҮРТГЭЛИЙН АСУУДАЛД

Р.Бадамханд¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
M41, Q32, Q51, Q56 <i>Түлхүүр үг:</i> Хүрээлэн буй орчин, хүрээлэн буй орчны эдийн засгийн бүртгэл, эдийн засгийн өсөлт	Хүн төрөлхтний амьдралд шууд нөлөөллөө үзүүлж эхлээд байгаа цаг уурын дулаарал, байгаль экологийн тэнцвэрийн алдагдал зэрэг асуудалд онцгой анхаарах болсон өнөө үед аливаа бүртгэл, статистикийн тоо мэдээлэл, дүгнэлтийг хүрээлэн буй орчин болон эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор бүртгэн мэдээлэх олон улсын шинэлэг систем бий болгохоор мэргэжилтнүүд ажиллаж эхлээд байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлт, бууралт нь хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгаа болоод хүрээлэн буй орчны хувьсал эргээд эдийн засаг, хүн амын амьдралын түвшинд хэрхэн нөлөөлж буйг бүртгэн дүгнэж, үүгээр эдгээрийн уялдаа холбоог сайжруулах талын арга хэмжээг авахад туслах зорилготой юм.

1. Оршил

Дэлхий нийт тогтвортой хөгжлийнхөө чиг хандлага болгохыг зорьж байгаа аливаа нөөцийг үр ашигтай зарцуулдаг, байгаль орчныг бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай үйлдвэрлэлийг дэмжсэн, нийгмийн ялгааг арилгаж, ядуурлыг бууруулахын төлөөх эдийн засгийн шинэлэг тогтолцоо (ногоон эдийн засаг) -г буй болгоход юуны өмнө:

- Бидэнд (хүн төрөлхтөнд) юу байна вэ?
- Байгаа бүх зүйл маань хэрхэн хувьсан өөрчлөгдөж байна вэ?

гэдгийг бүртгэдэг нэгдсэн тогтолцоо шаардлагатай байна. Иймд 2015 оны 11 дүгээр сард БНХАУ-ын Шанхай хотод болсон олон улсын чуулганаас Хүрээлэн буй орчны эдийн засгийн бүртгэлийн систем (The System of Environmental-Economic Accounting – SEEA)-ийг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон юм.

Хүрээлэн буй орчин гэдэг нь байгаль төдийгүй хүний амьдралын эрүүл, аюулгүй орчныг нийтэд нь хамардаг ойлголт бөгөөд үүнийг бүртгэх нь:

- Хүний амьдрах, ажиллах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх;
- Байгаль орчныг хайрлан хамгаалах;
- Байгалийн болон бусад нөөцийг зүй зохистой ашиглах;
- Экологийн болон эдийн засгийн ашиг сонирхлыг хослуулах;
- Хууль тогтоомжийг сахин биелүүлж, ил тод үйл ажиллагаа явуулах;

¹ МУИС-ийн ахлах багш, “Оюу Толгой” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч.
Цахим шуудан: BadamkhandR@ot.mn

- Бусад байгууллага, иргэдтэй хамтын эко үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэгт ашиглагдах хэрэгцээтэй мэдээллийг бий болгоход чиглэгдэх ажээ.

Хүрээлэн буй орчны эдийн засгийн бүртгэл нь улс орны:

- Макро түвшний шинэлэг статистик бүртгэл;
- Микро түвшний нягтлан бодох бүртгэл, тайлагналын шинэлэг арга барил юм.

Энэхүү бүртгэл нь ДНБ, орлого, зардал, ашиг зэрэг эдийн засгийн уламжлалт хэмжүүрээр дагнан илэрхийлэгдэх боломжгүй тул хүрээлэн буй орчин болон хүн амын амьжиргааны түвшний уялдаа холбоонд анхаарал хандуулахыг зорьж байна. Ингээд улс орны хүрээнд өөрийн экосистемийн торлог (*нэгж талбай, эзлэхүүн*) -ыг үүсгэн тэнд байгаа бүх төрлийн хөрөнгийг Үндэсний дансны систем (SNA)-д бүртгэж эхлэх, хүрээлэн буй орчны хөрөнгийг биет (*биомасс гэх мэт нэгжээр*) болон мөнгөн хэлбэрээр илэрхийлэх, мөнгөн дүн нь тухайн үеийн үнэ цэнэ дээр үндэслэсэн байх, хөрөнгийг газар, байгалийн нөөц болон бүтээгдсэн гэж ерөнхийлөн ангилах зэргээр нэлээд асуудлыг тодруулаад байна. Тухайлбал, байгалийн нөөцийн хөрөнгийн дансанд бодит үлдэгдэл ба хөдөлгөөн (*олборлолт, нээлт, зүй тогтолт өсөлт, бууралт, гамшигийн нөлөө, доройтолт, ангиллын өөрчлөлт, үнэлгээний зөрүү*)-ийг тусгах гэх мэт болно.

Одоогоор Канад, Австрали, Европын Холбооны зарим улс орнууд, ӨАБНУ-д хүрээлэн буй орчны бүртгэлийг янз бүрийн хэлбэрээр нэлээд үр дүнтэй нэвтрүүлж эхлээд байна. Жишээлбэл, Голланд улсын Статистикийн газар 1990 оноос хойш дараахь бүртгэлийг хийсэн нь тус улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх олон арга хэмжээний үндэс суурь болжээ.²

Хүснэгт I

Хүрээлэн буй орчны Голланд улс дахь бүртгэл

Үйлдэл	Үзүүлэлт
Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн бүртгэл	- Үйлдвэрлэлд суурилсан хүлэмжийн хийн ялгаралт - Хэрэглээнд суурилсан хүлэмжийн хийн ялгаралт - Эрчим хүчний хэмнэлт - Сэргээгдэх эрчим хүчний ашиглалт - Шим тэжээлийн хангалт – илүүдэл - Материалын үр ашиг - Ус ашиглалт - Ус цэвэршүүлэлт
Байгалийн хөрөнгийн бүртгэл	- Модны нөөц - Загас үржүүлэг - Байгалийн хийн нөөц - Газрын сайжруулалт - Биологийн төрөл зүйлд тулгарч буй аюул

² SEEA brochure – SC, 2016.

Амьдралын чанарын бүртгэл	- Агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн асуудал гэх мэт
Бодлого, арга хэмжээний чиглэл *	*Ногоон патент олголт
	*Ногоон татварын хувь
	*Эрчим хүчний үнэ
	*Нүүрстөрөгчийн хязгаарлалт
	*Байгаль орчны хөрөнгө оруулалт
	*Ногоон ажил г.м.

Эх сурвалж: Судлаачийн тооцоогоор

Монгол Улс Тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан 1998 онд баталж, Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл байгуулан ажиллаж байсан билээ. Манай орны Засгийн газраас *“байгалийн баялгийг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатайгаар олборлох, боловсруулах, ашиглах, түүнээс орох орлогоор дотоодын үйлдвэрлэлийг хэрхэн дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн хуваарилах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд хамгийн зөв арга замыг эрэлхийлэхэд анхаарлаа хандуулж байна”*.³

Энэ ажлын хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас (*тэр үеийн нэрээр*) 2014 онд “Монголын бэлчээрийн тогтвортой байдал” сэдэвт судалгааг хийж, Экосистемийн үйлчилгээний төлбөр (ЭСҮТ) буюу бэлчээрээ зохистой ашиглах замаар байгалийн нөхөн үйлдвэрлэл (*биологийн олон төрөл байдал г.м.*)-ийг нэмэгдүүлсэн, мөн байгальд учирч байгаа сөрөг үр дагавар (*хөрсний элэгдэл, эсвэл нүүрстөрөгч ялгаруулалт*)-ыг багасгаж чадсан бэлчээрийн газар ашиглагчдыг урамшуулах нэг төрлийн арга хэрэгслэлийг авч үзсэн нь манай эдийн засгийн бие даасан үндсэн салбарын нэг болох мал аж ахуйн менежментийг сайжруулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх арга хэмжээнд хэрэглэгдэх чухал мэдээллийг бий болгожээ. Тухайлбал, газрын удирдлагыг хөгжүүлэх нэгдсэн зорилт хаана шаардагдаж буйг, менежментийн өөрчлөлтийн зардлыг ямар бүс нутагт хангалттай дааж, урамшуулж болох, мөн зах зээлд суурилсан ЭСҮТ-ийн хэмжээг хэрхэн тохиромжтой тодорхойлох зэргийг дурьдаж болно.

Мөн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга технологийг нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Засгийн газрын тогтоолоор батлан шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад “Ногоон байгууллага” гэрчилгээ, байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн түүхий эд материал ашиглаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Эко тэмдэг” олгох ба тэмдэг олгох шалгуур үзүүлэлтийг техникийн зөвлөл боловсруулан гаргасан. Гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гадаад, дотоодод хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл тусламж, авахад тусламж үзүүлэх, хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад давуу эрхтэйгээр оролцох, байгаль

³ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр – ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго, 2012.

орчны олон улсын шагналд нэр дэвшүүлэх, олон улсын ижил төстэй дэвшилтэд технологи бүхий байгууллагатай хамтарч ажиллахад зуучлах, байгальд ээлтэй технологи, үйлдвэрлэлийн стандарт боловсруулах, олон улсын стандартыг үндэсний стандарт болгоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэргээр тусгажээ.⁴ Эдгээр арга хэмжээ нь хүрээлэн буй орчны бүртгэлийг хөгжүүлэн, мэдээллийн системийг бий болгоход томоохон дэмжлэг, түлхэц болох юм.

Хүрээлэн буй орчны эдийн засгийн бүртгэл нь аж ахуйн нэгж буюу микро түвшинд тухайн бизнес болон тэнд оролцогч талуудын хооронд байгуулсан нийгмийн гэрээний тусгал болох ёстой. Иймд компанийн нийгмийн хариуцлага, хүрээлэн буй орчинд тухайн байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ шууд болон дам байдлаар хэрхэн нөлөөлж буйг хэмжих, нийтэд мэдээлж тайлагнах, ноцтой аюул гамшгаас сэргийлэхэд туслах бүртгэлийг бий болгохыг зорьж байна. Энэ чиглэлд мөн ахиц дэвшил гарсаар байгаа бөгөөд санхүүгийн тайланд хавсралт, эсвэл бие даасан олон төрлийн тайлан гардаг болж байна. Жишээлбэл, Байгаль орчны нөлөөллийн тайлан, Нийгмийн хариуцлагын тайлан, Хүрээлэн буй орчны хамгааллын тайлан, Ил тод байдлын тайлан, Компанийн хариуцлагын гэх мэт.

Манай орны хувьд олон компани нийгмийн хариуцлагын тайлан (КНХ)-г гарган нийтэд (*вэб хуудсаар голдуу*) мэдээлж, сонирхсон хэн бүхэнд нээлттэй байна. Үүнд МҮХАҮТ-иас нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулан, Олон улсын стандарт (*ISO-26000 гэх мэт*) жишигтэй тодорхой хэмжээнд нийцүүлж байгаа нь тайлагналыг өргөжүүлэхэд томоохон түлхэц болж байна. Түүнчлэн 2006 онд Монгол Улсын Засгийн газраас “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” (ОҮИТБС) буюу газрын тос, байгалийн хий, олборлох салбарт ил тод байдал, тайлагналыг сайжруулахад зориулсан дэлхий нийтийн стандартыг хүлээн авч байгаагаа зарлаж дагалдан хийгдэх ажлыг хэрэгжүүлж эхэлсний үр дүнд ил тодын тайланд олон аж ахуйн нэгж хамрагдах болжээ. Жишээлбэл, 2015 оны ОҮИТБС-ын тайланд 200 гаруй компани нэгдсэн байна. Гэхдээ дээрхи тайлан (*КНХ, ОҮИТБС*) нь тухайн аж ахуйн нэгжээс бусдад өгсөн хандив, тусламж, хуулийн хүрээнд төлсөн татвар хураамжийн дүн зэрэг тоон мэдээллээр хязгаарлагдан, сурталчилгааны хэлбэртэй байсаар байна.

Ер нь одоогийн ашиглаж буй бүртгэлийн систем хүрээлэн буй орчинд бизнесийн үйл ажиллагааны үзүүлж буй нөлөөллийг бүртгэх суурь буюу хэмжилтийн нэгдсэн системийн шаардлагад нь нэлээдгүй шалтгаанаар бүрэн нийцэх боломжгүй байгааг бид мэднэ. Тухайлбал, зөвхөн мөнгөн хэмжигдэхүүнтэй, ашгийн чиг баримжаатай, бизнест хэт төвлөрсөн, эрэлт-нийлүүлэлтийн эдийн засгийн онолоос хамааралтай, тоон үзүүлэлтэд суурилсан, бүртгэлийн систем нь техник ажиллагаа ихтэй гэх мэтийг дурдаж болно.

2. Тэгвэл шинэлэг бүртгэлийг юунаас эхлэх вэ?

Бидэнд тулгараад байгаа хүрээлэн буй орчны ноцтой асуудлаас үүдэх аюулыг бууруулахад хувь нэмрээ оруулах нь хүн бүр (*байгууллагын удирдлага,*

⁴ News.mn – мэдээ, 2017.09.28

санхүүгийн ажилтнаас эхлээд)-ийн хийх зүй ёсны үйлдэл гэдгийг юун түрүүнд ойлгосноор одоогийн бүртгэлийн системд тоог онцгойлон анхаарч, байгууллагын үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчны хохирлыг тооцдоггүй байдлыг өөрчлөх хэрэгтэй болж байна. Мөнгөн болон мөнгөн бус үнэлгээний хосолмол системийг инноваци, туршилтын нэг хэсэг болгон судалж, байгууллага удирдан манлайлах үүргийнхээ хүрээнд хүрээлэн буй орчны талаарх гүйцэтгэлээ нээлттэй мэдээлэх алхам хийх нь зүйтэй байна.

Байгууллагын орц, үйлдвэрлэл, гарцыг хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөлтэй холбон үнэлж тайлагнадаг байх санаачлагыг олон улсын бүртгэлийн практикт нэвтрүүлж эхлээд байна. Үүнд:

- Орц – эрчим хүч, ус, түүхий эд, материал (ялангуяа ховордсон, нэн ховор болсон), газар ашиглалт г.м. байгалийн гол нөөцийг олон талаас нь хэмжих;
- Үйлдвэрлэл – хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах, эрчим хүчийг хэмнэх, ажиллагсдын ажил, амьдралын нөхцлийг сайжруулах гэх мэт;
- Гарц – үйлдвэрлэлийн үр ашиг, хог хаягдал, бохирдлын хэмжээг харьцуулан авч үзэх зэрэг болно.

Энэхүү бүртгэлээр гарах мэдээ, тайлан нь хүрээлэн буй орчны олон төрлийн эрсдэлтэй холбоотой асуудлаар тайлбар өгөх боломжийг бий болгож, үйл ажиллагааны дотоод үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ (хог хаягдлыг бууруулж нөөцийн эх үүсвэр бий болгох г.м.)-ний гол үндэслэл болж байх ёстой юм. Ийм тайланг бэлтгэх нягтлан бодох бүртгэлийг Эко удирдлагын бүртгэл (ЭУБ) гэж нэрлэх нь түгээмэл болжээ. ЭУБ зөвхөн мэдээлэл ба аудитыг хамруулаад зогсохгүй:

- бүтээгдэхүүний орших эргэц (бий болгох эхний орцоос хэрэглэгдэж дуусах хүртэл);
- бүрэн өртөг (капиталжих болон тайлант үеийн бүх зардал)-ийн бүртгэл;
- эко хэрэглээний үр дүнгийн шинжилгээ, эко удирдлагын төлөвлөлтийг багтаадаг.

Үүгээр компанийн үйл ажиллагаанд нөөцийн хэрэглээг бууруулах боломжийг хайх, үйл ажиллагаа, бүтээгдэхүүний эко үнэлгээг хийж, “Ээлтэй үйлдвэрлэл” (*Cleaner production*)-д тэмүүлэх, энэ чиглэлд гарах зардлаа тооцох зорилготой юм. Хүрээлэн буй орчны холбогдох зардлыг (*Япон улсын бүртгэлд хэрэглэж буй жишгээр*) авч үзвэл:

- Хүрээлэн буй орчинд учруулж болох нөлөөллийг хянах зардал (*агаар, усны бохирдлоос сэргийлэх зардал, дуу чимээ, доргио чичиргээн, хорт утаанаас сэргийлэх зардал, хөрсний гулгалт, бохирдлоос сэргийлэх бусад зардал гэх мэт*);
- Арга хэмжээний зардал (*хүрээлэн буй орчны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх зардал, ажиллагсдыг сургах зардал,*

учруулсан нөлөөллийг удирдаж хэмжих зардал гэх мэт);

- *Хөгжүүлэлтийн зардал (хүрээлэн буй орчинд ээлтэй шинэ бүтээгдэхүүн гаргах зардал);*
- *Эко үйл ажиллагааны зардал (байгаль хамгаалах, ойжуулах, экологийн газарзүйн төрхийг сайжруулах, орон нутгийн үйл ажиллагааг дэмжих зэрэг);*
- *Хор хохирлыг барагдуулах зардал (орчныг нөхөн сэргээх, хорио цээр тогтоох, торгууль ногдуулах, шүүх ажиллагаа зэрэг зардал) гэх мэтээр ангилан тайлагнах боломжтой юм.*

Мөн эко удирдлагын бүртгэлийн хүрээнд:

- Эрчим хүч, усны хэмнэлттэй ба дахин хэрэглээ, хаягдал ашиглалтын биет хэмжээ ба үр дүнгийн талаархи мэдээлэл;
- Бохирдлыг бууруулах хувилбарын харьцуулалт;
- Эко системд нөлөөлөх зардлын хэмнэлт болон орлого;
- Хөрөнгө оруулалт болон капитал хөрөнгийн эко нөлөөллийг тодруулах, дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх;
- Байгалийн эрсдэл бүхий төслүүдийг үнэлэх;
- Байгаль орчны хохиролд төлөх татвар, торгууль ба нөхөн олговрын тооцоог хийх;
- Ажлын байрны эрүүл, аюулгүй орчны зохистой шинэ үзүүлэлтийг боловсруулан, бүртгэл тооцоог сайжруулах зэргээр удирдлагын эко шийдвэрт нөлөө үзүүлэх бүртгэл мэдээллийн системийг бүрдүүлэх хэрэгтэй.

Тухайлбал, эрчим хүчний хувьд нарны болон бусад сэргээгдэх эх үүсвэрийг ашиглах, агааржуулалт болон салхивчинд эрчим хүчний хямгатай хэрэглээг нэвтрүүлэх, гэрлийн шилийг солихоос эхлээд нүүрс, түлшээр ажилладаг машин механизм, хоцрогдсон технологийн нөлөөллийг бууруулах чиглэлд үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөө, үр дүн, зардал, орлогын тооцооны мэдээлэл гэх мэтийг дурдаж болно.

Ийнхүү хүрээлэн буй орчны бүртгэл нь шинжлэх ухааны бусад салбарын мэргэжилтнүүдийн хийсэн үнэлгээ, тооцооллыг эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн хүрээнд боловсруулан уялдаа холбоотойгоор тайлагнах тул нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдээс өргөн мэдлэг чадвар, дүн шинжилгээ, төлөвлөлтийн шинэ арга барил шаардаж байгаа учраас бид бүхэн хөл нийлүүлэн суралцах, мэргэжилтнээ бэлтгэх шаардлага амьдралаас урган гарч байна.

Ном зүй:

- [1] Монгол Улсын Засгийн Газар. (2012) “Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго – 2012”, УБ
- [2] БОНХЯам (2014) хийсэн “Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал” судалгааны ажил 2014, УБ
- [3] KPMG (2003). Guide to accounting for asset retirement obligations, An analysis of FASB statement No.143, USA
- [4] Жааваа, Т. (2011). Ногоон эдийн засгийн хөтлөгч ба тайлагналын дүр зураг”. ЭШ-ний хурлын илтгэл, УБ
- [5] Joy E. Hecht. (2000) Lessons learned from Environmental accounting: Findings from nine case studies, brochure, USA
- [6] Vernon P. Dorweiler (2004). Environmental accounting: An essential component of business strategy.
- [7] Бадамханд, Р. (2015) Уул уурхайн нягтлан бодох бүртгэлийн онцлог. Соёмбо, Улаанбаатар.
URL: seea@un.org
URL: <http://www.eea.europa.eu/publications/an-experimental-framework-for-ecosystem>
URL: www.iucn.org/places/usa/greenacct.html
URL: www.globio.info
- [8] URL: www.eitimongolia.mn/

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ АСУУДАЛД

Э.Бямбажав¹

Оюу толгойн далд уурхайн асуудлаар УИХ-аас ажлын хэсэг байгуулан ажиллуулж байгаатай холбогдуулан эдийн засагч, судлаач, профессор, Монгол Улсын гавъяат эдийн засагч Э.Бямбажав “Хөрөнгө оруулалтын гэрээ”², “Хувь нийлүүлэгчдийн гэрээ” (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон), “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” гэсэн гурван баримт бичигт зайлшгүй өөрчлөх, анхаарах шаардлагатай гэж үзсэн асуудлаар өөрийн санал бодлоо илэрхийлснийг Та бүхэнд толилуулж байна.

Нэг. Хөрөнгө оруулалтын гэрээний талаар

1.1. Гэрээний 1.3-д “Хөрөнгө оруулагчийн төлбөл зохих бүх татварыг тогтворжуулах”-аар заасан нь Хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн 14.1, 16.2.1 дэх заалтыг зөрчиж, уг хуульд заасан дөрвөн төрлийн татварыг 16 жил хүртэл хугацаагаар тогтворжуулж болох байтал гэрээнд бүх татварыг 30 жил+20 жил+20 жил, нийт 70 жил тогтворжуулахаар заасан нь Оюу толгойн уурхай Монгол Улсын доторх тусгай хуультай улс (компани) шиг байгааг өөрчлөх. Үүний тулд:

1.1.1. Гэрээний 1.3-д бүх татварыг 30жил+20жил+20жил тогтворжуулахаар заасныг хасах.

1.1.2. Гэрээний 2.1 дэх заалтаас 2.1.4; 2.1.6; 2.1.7 дахь заалтыг хасах. “Энэ нь онцгой албан татвар, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар”-ыг тогтворжуулах талаар Хөрөнгө оруулалтын хуульд заагаагүй атал гэрээнд тогтворжуулахаар заасан нь хууль зөрчиж байна. Эдгээр татвар нь хяналтын агуулгатай, хэмжээ бага бөгөөд бусдад сөрөг нөлөө үзүүлж, буруу жишиг болох тул энэ заалтыг цаашид үйлчлэхгүй болгох нь чухал. Гэхдээ 2.1 дэх заалтад “29 дүгээр зүйлийн 29.1.1” гэсний дараа “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 14.1, 16.2.1” гэж нэмж оруулах, мөн “дараах татваруудыг” гэсний дараа “16 (арван зургаан) жилийн хугацаагаар (тогтворжуулна)” гэж нэмж оруулах.

¹ Судлаач, профессор, Монгол Улсын гавъяат эдийн засагч.

Цахим шуудан: b_ikhtusch@yahoo.com

² “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” УИХ-ын 2009 оны долоодугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолд зааснаар Оюу толгой ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмшлийн доод хэмжээг 34 хувиар тогтоож, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрхийг Засгийн газарт олгосон байна.

URL: <http://www.lgalinfo.mn/law/details/6405>

1.1.3. Гэрээний 2.7-д хувь хэмжээг нь тогтворжуулсан бүх татварын талаарх заалт нь хууль зөрчиж байгааг хөрөнгө оруулагчтай сайтар ярилцаж, хэрэв тэдний хувьд зарчмын чухал заалт гэвэл уг заалтыг хугацаатай болгох, ялангуяа гэрээний эхний хугацаа дуусахад татварын тогтворжуулалтын талаарх бүх заалт цаашид үйлчлэхгүй байхаар тохирох.

1.2. Гэрээний 1.5; 1.1.1; 3.2; 3.5 дахь заалтад тусгай зөвшөөрөл бүхий талбайн гадаргуу болон хэвлийгээс ямар ч ашигт малтмал ялган авах, олборлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрхийг Хөрөнгө оруулагчид олгосон нь Оюу толгойн төслийн зэс, түүний дагалдах эрдсийг ашиглах, олборлох гэрээний үндсэн зорилтоос гажиж байгаа тул ямар ч ашигт малтмалыг энэ гэрээний нөхцлөөр “30жил+20жил+20жил” ашиглах, олборлохоор заасныг өөрчлөх. Гэрээнд заасан зэс, алт, мөнгө, молибден, хүдэр дэх металл эрдсээс бусад ашигт малтмал ашиглах, олборлох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бол тухайн үед жич гэрээгээр хөрөнгө оруулалтын энэ гэрээнд хамаарахгүйгээр Талууд хамтарч уг асуудлыг шийдвэрлэхээр заах. Иймд гэрээний 1.5; 1.1.1; 3.5 дахь заалтад: “энэ гэрээний 16.40-д зааснаас бусад ашигт малтмалыг ашиглах, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудалд энэхүү хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл үйлчлэхгүй бөгөөд Талууд тухайн үед жич гэрээгээр уг асуудлыг хамтран шийдвэрлэнэ” гэж нэмэлт оруулах.

1.3. Гэрээний 2.21-д экспортод гаргаж байгаа ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнээс бусад уул уурхайн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөхөөр заасан нь хууль зөрчиж байгаагийн хамт “бусад бүтээгдэхүүн” гэдэг нэрээр Оюу толгойн бүтээгдэхүүнүүд НӨАТ-аас чөлөөлөгдөж болохоор байгаа бөгөөд энэ нь уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдэд сөргөөр нөлөөлөх буруу жишиг болох тул 2.21 дэх заалтыг хасах.

1.4. Гэрээний 3.18-д уурхайн хаалтын менежмент, зардлын талаар тодорхой бус, бүдэг бөгөөд “30жил+20жил+20жил=70 жил” гэсэн урт хугацааны дараа хаалтын хөтөлбөр гаргах, хаалтын зардлыг эксроу дансанд түр байршуулахаар заасан нь олон жил ашиглах ийм том уурхайн хаалтын менежмент, уурхайг хаах хөрөнгийн бодитой эх үүсвэрийг шийдвэрлэж чадаагүй байна. Иймд уурхайн хаалтад зориулсан санг компанийн ашгаас Талуудад ногдол ашиг хуваахаас өмнө байгуулж, хөрөнгийг нь эксроу дансанд байршуулах журам тогтоохоор гэрээний 3.18 дахь заалтыг өөрчлөх нь зүйтэй юм. Гэрээнд зааснаар уг зардлыг хөрөнгө оруулагчийн татвар ногдох орлогоос хасах нь уурхайн хаалтын зардлыг Монголын талд хариуцуулж байгаа тул Талууд өөрийн эзэмшдэг хувьцааны хэмжээгээр хаалтын зардлыг хариуцдаг болох нь зүйтэй болно.

1.5. Гэрээний 3.19-д хөрөнгө оруулагч нь зэс хайлуулах үйлдвэрийг манай оронд барих, ажиллуулах асуудлаар зөвхөн судалгааны тайлан боловсруулахаар заагаад, үйлдвэр байгуулах үүргийг хөрөнгө оруулагчид эцэслэн хүлээлгээгүй, Монгол Улс дангаар, бусадтай хамтарч, эсвэл гуравдагч этгээд уг үйлдвэрийг барих юм шиг заагаад асуудлыг шийдвэрлээгүй, хөрөнгө оруулагчтай үүргийн

биелэлт ярих боломжгүй болгожээ. Иймд гэрээний 3.19; 3.20; 3.21; 3.23 дахь заалтыг өөрчилж, Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол Улсад барих асуудлыг Хөрөнгө оруулагч хариуцахаар заах нь зүйтэй юм.

1.6. Гэрээний 7.3-д цахилгаан станц барих асуудлыг мөн л шийдвэрлээгүй байгааг тодруулан Хөрөнгө оруулагчийн үүрэг болгон заах.

1.7. Гэрээний 7.19.4-д Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд “30жил+20жил+20жил” хөрөнгө оруулагч, түүний хамааралтай этгээд, гэрээт гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчид зам ашигласны бүх төлбөрөөс чөлөөлөгдөхөөр заасан нь ийм олон жилийн хугацаанд хамаарал бүхий этгээд, гэрээт гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч гэх нэрийн дор аливаа этгээд, хяналтад байдаг, шууд ба шууд бусаар хамтрагч, үйл ажиллагаанд оролцогч, үйлчилгээ үзүүлэгч, ханган нийлүүлэлтэд оролцогч гэх зэрэг олон нэрээр аливаа компани, хувь хүн замыг үнэгүй ашиглах нь амьдралд болон замын ашиглах хугацаатай нийцэхгүй байгаа тул зөвхөн хөрөнгө оруулагч гэрээний эхний хугацаа дуусах хугацаанд (*гэрээнд зааснаар 30 жил*) зам ашигласны төлбөр төлөхгүй байхаар 7.19.4 дэх заалтад өөрчлөн тусгах.

1.8. Гэрээний 7.19.5-д авто зам нь олон улсын чанартай учраас хөрөнгө оруулагч нь хуулийн хариуцлага хүлээхгүй гэсэн нь “зам”-ыг муу, стандарт бус аваарь ослын нөхцөлтэйгээр барьсан байсан ч, зам муугаас болж гадаад, дотоодын тээвэрлэгч, үйлчлүүлэгч хохиролд орсон ч зам барьсан этгээд хариуцлага хүлээхгүй байхаар болжээ. Иймд юуны урьд олон улсын стандартын шаардлагыг хангасан байхаар замыг барьж байгуулахыг гэрээний 7.19.5 дахь заалтад тусгах, уг зам дээр өөрсдийн буруугаар гарсан аливаа осол аваар, замыг зүй бусаар ашигласантай холбоотой хохирол, төлбөрийг хөрөнгө оруулагч хариуцахгүй гэж тодруулан заах.

1.9. Оюу толгой компани нь бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд борлуулан ихээхэн орлого олдог боловч уг орлого, түүний гүйлгээ тэр бүр Монгол Улсын банкаар дамждаггүй, бүрэн тооцдог эсэх нь тодорхойгүй, экспортлосон бүтээгдэхүүний биет хэмжээ, орлого бүрэн эсэхэд Монгол Улсын байгууллага, олон нийт, иргэд мэдээлэл хомс болохоор итгэл үнэмшилгүй, хардах, сэтгэл зовох байдал их байгааг цаашид арилгах зайлшгүй шаардлага байна. Гадаадын хөрөнгө оруулагч, Оюу толгой компанийн борлуулалтын орлогыг хураах, хязгаарлах, тэдний орлогоо эзэмших эрхийг нь зөрчих, багасгах, хасах, хаах оролдлого монголчуудад байхгүй, зөвхөн бүтээгдэхүүний борлуулалтын орлого нь бүрэн бүртгэгдэж, Оюу толгой компанид бүрэн ордог, данс тайланд тусгагддаг байх, Оюу толгой компанийн орлого, өртөг зардал ил тод байх, зардлаас илүү орлогоо зохих журам, хууль, бүртгэл тооцооны дагуу гадаад, дотоодод чөлөөтэй эзэмших, зарцуулахыг хэзээ ч хориглоогүй, хязгаарлахгүй, зөвхөн ил тод, бүртгэл тооцоонд хамрагдаж, орлого, өртөг зардал, ашиг, ногдол ашиг бүрэн тооцоотой байхыг л хүсээд байгааг гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгуулах нь чухал. Үүнтэй холбогдуулан гэрээний 9.10-д заасан хөрөнгө оруулагчийн хөрөнгө, валют, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг эзэмших, зарцуулах, төлбөр

тооцоо хийхтэй холбогдсон заалтыг тодруулан өөрчлөх нь зүйтэй. Тухайлбал, Оюу толгой ХХК нь бүтээгдэхүүнээ гадаадад ачуулах, хилийн боомтоор бүтээгдхүүн гарах үед заавал аккредитив нээсэн, эсвэл компанийн дансанд мөнгө нь орсон байх, тэр нь компанийн болон Монгол Улсын экспортын орлого болон бүртгэгдэж байдаг болох шаардлагатай юм. Иймд аккредитив нээгдээгүй, эсвэл үнэ нь төлөгдөөгүй бүтээгдэхүүнийг хилээр гаргахгүй байхаар журамлавал зохино. Энэ нөхцөлд Оюу толгой компанийн экспортын бүтээгдэхүүний биет хэмжээ, орлого бүрэн бүртгэгдэж, ил тод байх нөхцөл бүрдэх болно. Гэрээний 9.10.2; 9.10.3-д гадаад улсад хөрөнгө чөлөөтэй зарцуулах, гадаадад олсон орлогоо гадаад улсад хадгалах, чөлөөтэй зарцуулах гэх зэргээр тодорхой бус, бүх хөрөнгө, орлогод хамааруулсан заалтыг өөрчилж, Оюу толгой компани нь өөрт үлдэх ашгаа чөлөөтэй гадаадад гуйвуулах, зарцуулах, байршуулах эрхтэй байх заалт болгох. Мөн гэрээний 9.10.1-д: “... *шаардлагатай гэж үзвэл гадаад валютыг төгрөгт шилжүүлэх*” гэсэн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гарах бүх зардлаа манай орны үндэсний валют – төгрөгөөр тооцох, зарцуулах, тайлан тэнцэл, бүртгэл тооцоонд тусгах талаарх Монгол Улсын хуулийн заалтыг зөрчиж байгааг өөрчлөн найруулах.

1.10. Гэрээний 3.1; 15.11-д гэрээний эхний хугацааг тогтоох, цаашид сунгах талаар тогтоосон журмыг өөрчлөх шаардлагатай байна. Энэхүү гэрээгээр тогтоосон анхны хөрөнгө оруулалтыг урамшуулсан, татвар төлбөрөөс эхний үед чөлөөлсөн, эсвэл тогтворжуулсан, тааламжтай нөхцөл тогтоосон журмыг цаашид “30+20+20=70 жил” хэвээр нь мөрдөх, Оюу толгой компани нь улсын доторх улс (компани) болж, өөрийн хуультай ажиллахаар журамд тохирсныг өөрчлөх нь зүйтэй байна. Гэрээний хугацааг сунгахдаа анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний (ТЭЗҮ-ээр бол ? жил) дараа (*гэрээнд зааснаар 30 жилд 2 дахин гаруй нөхнө*) Талууд аль болох ижил нөхцөлд, гэхдээ Монголын төр (ТӨК) орд газрын эзний хувьд илүү нөхцөл эдлэхээр (*Айвенхоу хөрөнгө оруулалтаа 2 дахин гаруй нөхсөн тул*) тохирох нь чухал. Гэрээний 15.11-д гэрээний хугацааг сунгахын тулд “*хангах нөхцлүүд*” гэж заасан нь учир дутагдалтай, гэрээний эхний 30 жилийн хугацаа хэт удаан, хөрөнгө оруулалтаа нөхөөд, зохих хэмжээний цэвэр ашиг олсны дараа гэрээний эхний хугацаа дуусахаар тогтоож чадаагүй байна. Хэрэв гэрээний эхний хугацааг 30 жилээр тогтоох нь хөрөнгө оруулагчийн хувьд маш чухал, гэрээ байгуулсан зарчмын нэг гол асуудал гэж үзэж буй бол гэрээний эхний хугацаа дууссаны дараа энэхүү гэрээний дараах заалт үйлчлэхгүй болох талаар гэрээнд нэмж тусгах:

- 1.10.1. Гэрээний 1.3; 2.1; 2.2; 2.3; 2.4; 2.5; 2.6; 2.7; 2.8; 2.9; 2.10; 2.11; 2.12; 2.13; 2.16; 2.18; 2.20; 2.21; 2.22; 2.29; 2.30; 2.32 дахь заалтууд (татвар тогтворжуулалттай холбогдсон бүх заалт);
- 1.10.2. Тухайн үеийн хууль эрх зүйн дагуу мөрдөгдөх нь зүйтэй тул доорх заалтыг өөрчлөх, хасах:
 - а. Гэрээний 3.13 дахь заалт (*ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр*);

- b. Гэрээний 5.6 дахь заалт (*татвар ногдох орлогоос газар ашигласны төлбөрийг хасах*);
 - c. Гэрээний 6.14 дэх заалт (*усны төлбөрийг татвар ногдох орлогоос хасах*);
 - d. Гэрээний 7.8 дахь заалт (*эрчим хүчний зориулалтаар ашиглах газрын төлбөр, хураамжийг татвар төлөх орлогоос хасах*);
 - e. Гэрээний 7.19.2 дахь заалт (*авто зам барих зардлыг татвар ногдох орлогоос хасах*).
- 1.10.3. Гэрээний эхний хугацаа дуусах үед гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахаар заах:
- a. Гэрээний 1.6-д: төрийн эзэмших энгийн хувьцаа 34 хувь гэдгийг Талууд 50:50 гэсэн харьцаагаар хувьцаа эзэмшдэг болох, үүний тул компанийн нийт хувьцааны 16 хувийг хөрөнгө оруулагч (Айвенхоу) нь Монголын төрд үнэ төлбөргүй, болзолгүйгээр шилжүүлэн өгөхөөр заах (*Энэ нь Айвенхоу оруулсан хөрөнгө оруулалтаа энэхүү 30 жилд 2 дахин гаруй нөхөн олсонтой холбоотой*);

Хоёр. Хувь нийлүүлэгчдийн гэрээний талаар (нэмэлт, өөрчлөлт оруулсан)

2.1. Гэрээний 5.8; 5.10-ын “б”-д ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг дийлэнх олонхийн саналаар гаргахаар заасан нь дэндүү шударга бус, Монголын төрийн (ТӨК) оролцоог үгүйсгэсэн, тэд эсрэг саналтай байсан ч Айвенхоу компанийн хувь нийлүүлэгчид, түүний томилсон ТУЗ-ийн гишүүд (*тэд олонх учраас*) бүх шийдвэрийг гаргах боломжтой болжээ. Иймээс өнөөгийн байдлаар Монголын төр (ТӨК), Монголын талаас томилсон ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааны талаар Монголын байгууллагууд, олон нийт, иргэд шүүмжлэлтэй, Оюу толгойн гэрээ Монголд ашиггүй, Монголын хойч үед их өр үлдээгээд ногдол ашиг ч авч чадахгүй нөхцөл тохирсон гэдэг яриа хэл, гомдол, шүүмж туйлын их болоод байгаагийн нэг шалтгаан нь шийдвэр гаргах талаарх дээр дурдсан шударга бус журамтай холбоотой билээ. Иймд хувь нийлүүлэгчид, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг дийлэнх олонхийн саналаар гаргах боловч уг шийдвэрийг Айвенхоу ба ТӨК-ийн тус бүр нэг нэг төлөөлөл зөвшөөрсөн нөхцөлд гаргах, ийм төлөөлөл зөвшөөрөөгүй шийдвэр хүчингүй байх талаар дээрх заалтуудад нэмж тусгах.

2.2. Гэрээний 7.2-ын “а”, “б” заалтад менежментийн багийг Айвенхоу нь нэг буюу түүнээс дээш хамаарал бүхий компанийг дангаар нь, эсвэл бүлэг болгон авч ажиллуулах журам тогтоосон нь бас л шударга бус, Монголын төр (ТӨК) 34 хувийн хувьцаа эзэмшигчийн хувьд Оюу толгой компанийн үндсэн үйл ажиллагаанд ямар ч оролцоогүй, тийм эрхгүй, компанийн өдөр тутмын бүх асуудлыг зөвхөн Айвенхоу шийдвэрлэхээр өрөөсгөл, нэг талын сонирхлыг хэт хамгаалсан журам тогтоосон байна. Иймд менежментийн багийг Айвенхоу болон ТӨК-ийн төлөөлөл харилцан тохиролцож томилдог байхаар уг заалтыг өөрчлөх.

2.3. Гэрээний 7.4-д менежментийн багийн үйлчилгээний төлбөрийг үндсэн хөрөнгийн болон үйл ажиллагааны зардлын нийт дүнгээс бодохоор заасан нь маш буруу, менежментийн баг нь үйл ажиллагааны зардлыг аль болох өсгөх, тэр хэмжээгээр тэдний орлого нэмэгдэж байх ямар ч логикгүй, эдийн засгийн хөшүүрэггүй журам тогтоосон байна. Менежментийн багийн үйл ажиллагааны чиг үүрэг (*гэрээний 7.3 дахь заалт*)-т хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгийн зардал ямар ч хамааралгүй байхад уг зардлын дүнгээс менежментийн багийн хөлсийг тооцож олгох ямар ч үндэслэлгүй, тэдний хөлсийг илүү ихээр олгох арга болгосныг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Иймд менежментийн үйлчилгээний төлбөрийг зардлын дүнгээс бус, Оюу толгой компанийн орлогоос тооцдог байхаар өөрчлөх нь орлогоо өсгөхийн төлөө ажиллах хөшүүрэг болно. Уг заалтад менежментийн багийг өөрчлөх асуудлыг зөвхөн Айвенхоу компани шийдвэрлэхээр заасныг Айвенхоу болон ТӨК хамтран шийдвэрлэхээр өөрчлөх.

2.4. Гэрээний 9, 10, 11 дэх заалтад “*Оюу толгой компанийн санхүүжилт*”-ын тухай заахдаа бүтээгдэхүүнээ борлуулаад орлого олж, түүгээр зардлаа санхүүжүүлдэг аж ахуйн тооцоотой компанийг нийтлэг жишиг, зарчмаар бус, хувь нийлүүлэгчдээс үйл ажиллагааны зардал шаарддаг (*төсвийн байгууллага шиг*), тэд нь компанийн зардалд зориулж хувьцаа гаргах, түүнийг санхүүжүүлэх нэрээр хувь нийлүүлэгчид нэг нь нөгөөдөө зээл олгосон нэр зүүж, Монголын талын өрийг компанийн жил бүрийн төсөвт зардлын хэмжээгээр (34 хувь) нэмэгдүүлж байх журам тогтоосон нь эдийн засгийн үндэслэлгүй, Монголын төрийн (ТӨК) өрийг нэмэгдүүлэх арга хэлбэр болгосон журам тогтоосныг үндсээр нь өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Компани нь бүтээгдэхүүнээ борлуулж, ихээхэн орлого олж байхад яахаар түүний төсөвт зардлыг нөхөхөд зориулж Айвенхоугийн хувь нийлүүлэгч нь шаардсан мөнгөн хөрөнгийн хэмжээгээр санхүүжилт хийх, ТӨК-ийн эзэмшлийн хувь хэмжээ (*ТӨК өөрөө санхүүжүүлээгүй бол*)-гээр түүнд Айвенхоу компани зээл олгосноор тооцож, зээлийн гэрчилгээ олгох талаарх заалтыг өөрчилж, аж ахуйн тооцоот, өөрөө орлого олоод, түүнээсээ төсөвт зардлаа санхүүжүүлдэг нийтлэг журмаар ОТ компанийг ажиллуулах нь зүйтэй тул дээрх 9, 10, 11 дэх заалтыг үндсээр нь өөрчлөх.

2.5. Компанийн жил бүрийн төсөвт зардлыг санхүүжүүлэх нэрээр ТӨК-д зээл олгосноор (*компани нь өөрөө олсон орлоготой атал*) тооцож, уг зээлийн дүнг Libor+6,5 хувь гэсэн өндөр хүүгээр нэмэгдүүлэх, түүгээр ч зогсохгүй АНУ-ын хэрэглээний үнийн индексээр бас өсгөн нэмэгдүүлж, хүүнээс хүү бодон өсгөж байх журмыг энэ гэрээгээр тогтоосон нь орлогоороо зардлаа нөхөж, аж ахуйн тооцоогоор үйл ажиллагаа явуулах ёстой Оюу толгой шиг баялаг ордод ажиллаж байгаа компанийн хувьд ямар ч эдийн засгийн үндэслэлгүй, “*уг компанийн зардлыг яаж өсгөх вэ? Монголын төр (ТӨК)-ийн өрийг ямар аргаар нэмэгдүүлэх вэ?*” гэсэн арга сүвэгчилсэн журам болсон байна гэж үзэхээр болжээ. Тухайн жилийн төсвөөр манай орны нутаг дэвсгэрт төгрөг (*үндэсний валют*)-өөр гарч буй зардлыг АНУ-ын хотуудын үнийн дундаж индексээр өсгөн нэмэгдүүлэх нь ямар ч үндэслэлгүй, жил бүрийн төсвийн зардалдаа Оюу толгой компани нь хувь

нийлүүлэгчдээс хөрөнгө шаардах ямар ч хэрэгцээ байхгүй байхад ийнхүү журам тогтоосныг нэн даруй өөрчилвөл зохино. Тэрчлэн зээлийн хүү гэгчийг “*Libor + 6,5 хувь ба 9,9 хувь*” гэсэн нь маш өндөр бөгөөд Монголын талын өрийг ингэж тооцоход туйлын ихээр өснө. Иймд 6,5 хувийг багасгах, АНУ-ын индексээр зээлийн өрийг өсгөн нэмэгдүүлэх заалтыг хасах.

2.6. Гэрээний 11.4; 15.2-т зааснаар бол хөрөнгө оруулалтын зээлээс (34 хувь) гадна компанийн жил бүрийн төсөвт зардлын хэмжээ (34 хувь)-гээр зээлийн өрөнд Монголын төр (ТӨК) орж, ойрын ирээдүйд болон үйл ажиллагааны бүх хугацаанд ч Монгол улсад ямар ч ногдол ашиг орж ирэхээргүй журам тогтоосон нь нэн харамсалтай байна. Хөрөнгө оруулалтын зардалд Монголын төр (ТӨК) зээл (34 хувьд ногдох) авч болох боловч түүнийг далимдуулан Оюу толгой компанийн жил бүрийн үйл ажиллагааны төсөвт зардалд 34 хувийн зээл авах талаар гэрээнд заасан журмыг өөрчлөхгүй, тийм зээл одоо олгосоор байгаа бол энэ уурхайг цаашид ажиллуулахгүйгээр шууд зогсоох шаардлагатай. Иймд энэ гэрээний 11, 12, 13, 14, 15, 16, 18 дахь заалтыг өөрчилж, хөрөнгө оруулалтын зардлын 34 хүртэл хувьд Монголын төр (ТӨК) Айвенхоу компанийнийн хөрөнгө оруулагчаас зээл авч болох (*хөрөнгө оруулалтын гэрээний заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр*) асуудлыг Оюу толгой компанийн жил бүрийн үйл ажиллагааны зардалтай хольж хутгахгүйгээр аж ахуйн байгууллага нь өөрийн төсөвт зардлаа (*бүтээгдэхүүний орлого, өртөг*) орлогоосоо санхүүжүүлэх, эргэлтийн хөрөнгийн түр дутагдал гарвал Монголын арилжааны банкны зээлээр санхүүжүүлэх заалт болгон хөрөнгө оруулалтын зардал, аж ахуйн тооцоот байгууллагын зардал тооцох журмыг тус тусад нь зааглан тусгах нь зүйтэй байна. Ийнхүү журам тогтоосноор компанийн үйл ажиллагааны төсөвт зардлыг санхүүжүүлэхэд Монголын төр (ТӨК) Айвенхоугийн санхүүжүүлэгчээс зээл авах, түүнийгээ ногдол ашгаас төлөх ямар ч шаардлага гарахгүй, үйл ажиллагааны зардлын хэмжээ (34 хувь)-гээр Монголын төр (ТӨК)-ийн өр нэмэгдэхгүй байх боломжтой болно.

2.7. Гэрээний 16.10-д гэрээний эхний хугацаа дуусах (30 жилийн дараа) үед ТӨК нь Оюу толгой дахь хувь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлэх талаар маш чухал, зөв зүйтэй асуудлыг тусгасан боловч чухам ямар нөхцлөөр Айвенхоу компанийн хувь нийлүүлэгч 16 хувиа шилжүүлэхийг заагаагүйн дээр хэдийгээр Талуудын хувь эзэмшил 50:50 болох боловч компанийн удирдлага, эрх мэдэл, менежмент болон хувь нийлүүлэгчид, ТУЗ-ийн эрх мэдэл бүгд Айвенхоу компанид хэвээр байхаар заасан (16.10-ын “г” заалт)-ыг өөрчлөх шаардлагатай юм. Айвенхоу компани нь 30 жилийн дараа өөрийн эзэмшлийн 16 хувийг ямар нэг болзол, төлбөргүйгээр ТӨК-д шилжүүлэн өгөхөөр заах.

2.8. Гэрээний 18-д Айвенхоу компани, эсхүл Рио Тинтод хамаарал бүхий аливаа этгээдийн төлөх ёстой татварыг Монголын тал (ТӨК) төлөхөөр заасан нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.27 дахь заалттай зөрчилдөж байгаагийн хамт ТӨК нь ийм үүрэг амлалт авах эдийн засгийн ямар ч үндэслэл байхгүй тул энэ гэрээний 18 дахь заалтын “а”, “б”, “д” хэсгийг хасах, эсвэл энд заасан

шилжүүлэг, хураамж, төлбөр, татварын хэмжээгээр Оюу толгой компанид ТӨК-ийн оруулсан хөрөнгийг нэмэгдүүлэх заалт болгон өөрчлөх.

Гурав. “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний талаар

3.1. Энэхүү “төлөвлөгөө” гэж нэрлэсэн баримт бичгийг Талуудын хооронд байгуулан мөрдөж байгаа Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээний хэд хэдэн заалтыг зөрчин дээрх хоёр гэрээ байгуулахад оролцоогүй, уг гэрээнүүдийн заалтыг өөрчлөх эрхгүй Туркойс Хилл ресурсес, Ти Эйч Ар Оюу толгой зэрэг хуулийн этгээд оролцон байгуулсан учраас Талуудын хооронд мөрдөх хууль, эрх зүйн баримт бичиг гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна. Үүний хамт энэхүү “төлөвлөгөө” гэх баримт бичигт нотолгоо, үндэслэл нь тодорхойгүй олон тоон мэдээлэл оруулсан байх боловч эдгээр нь Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээний заалтаар баталгаажихгүй байна. Жишээлбэл:

- 3.1.1. Төлөвлөгөөний 2.2-ын “b”-д Монгол Улсын Засгийн газар Оюу толгой төслийн үр ашгийн 53 хувийг татвар, роялтийн төлбөр, ногдол ашгийн хэлбэрээр хүртэхээр заасан нь дээрх гэрээнүүдээр Монголын төр “Хөрөнгө оруулалтын” 34 хувьд өндөр хүүтэй, АНУ-ын үнийн индексээр нэмэгддэг зээл авахаас гадна Оюу толгой компанийн жил бүрийн үйл ажиллагааны зардлын 34 хувьд мөн өндөр хүүтэй зээлийг ТӨК-д олгохоор заасан нөхцөл, журмын дагуу тооцоход Монголын төрд (ТӨК) Оюу толгойн төслийн үр ашгийн 53 хувь нь ногдох үндэслэлгүй байна.
- 3.1.2. Төлөвлөгөөний 3.1-д Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөг дотоодод нутаг дэвсгэрт зарцуулагдах зардлын хэмжээгээр үйл ажиллагааны долоон жилд 9 тэрбум ам.доллар гэсэн эдийн засгийн үр ашгийн үндэслэл нь тодорхой бус, Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчийн гэрээний заалтын дагуу бол зөвхөн Монголын төрийн өр энэ долоон жилд Монголын нутагт гарах зардлаас 3.4 тэрбум ам.доллар болохоор тооцоог хүснэгтээр гаргасан нь Монголд “их үр ашигтай” төсөл гэж монголын олон нийтийн “толгойг угаах” гэсэн тооцоолол гэж хардахаар, энэ “төлөвлөгөө” гэх баримт бичигт ийнхүү нотолгоогүй мэдээлэл оруулах үндэслэл, тийм зайлшгүй шаардлага харагдахгүй байна.
- 3.1.3. Дээрх хүснэгтэд “Хөрөнгө оруулалтын зардалд ногдох НӨАТ ба бусад татвар долоон жилд 0.6 тэрбум ам.доллар” гэсэн атлаа Монгол Улсын Засгийн газарт шууд төлөх төлбөр долоон жилд 2.2 тэрбум ам.доллар буюу жилд 300 сая ам.доллар гэсэн нь хоорондоо хэт их зөрүүтэй, үнэмшил багатай, хийсвэр тооцоо гэж үзэхээр байна. Иймээс дээрх тоон мэдээллийг үндэслэлтэй, ХӨОГ (Хөрөнгө оруулалтын гэрээ), Хувь нийлүүлэгчдийн гэрээний заалттай нийцтэй болгох, эдгээр тоон мэдээлэл бодит гүйцэтгэлээр гарахгүй бол Компанийн бүх удирдлага, менежментийг хариуцагч Айвенхоу

компани ямар хариуцлага хүлээхийг нэмж оруулах.

3.2. Төлөвлөгөөний 3.4-д *“Төлбөрийн чадамж сайжруулах механизмын төсөөлөл”*-ийг ОТ ХХК, Туркойс Хилл бэлтгэж, цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгжид өгөх, Айвенхоу компани цахилгаан станцад дэмжлэг үзүүлэх эсэх нь станцын төслийн хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчтэй хийх яриа хэлэлцээнээс хамаарахаар заасан нь Хөрөнгө оруулалтын гэрээний Айвенхоугийн хөрөнгө оруулагчийн хүлээсэн үүргийг эзэнгүйтүүлж, цахилгаан станц барих асуудлыг шийдвэрлээгүй хойшлуулсан байгаа тул Айвенхоу компанийн үүрэг болгох.

3.3. Төлөвлөгөөний 3.5-д Зэс хайлуулах үйлдвэр байгуулах эдийн засгийн боломжийн талаарх судалгааны тайланг ОТ ХХК боловсруулснаар ХөОГ-ээр түүний хүлээсэн үүрэг биелсэнд тооцохоор гэрээний заалтыг өөрчилж, түүнийг цаашид мөрдөж байгаа нь Засгийн газартай байгуулсан гэрээний заалтыг уг гэрээ байгуулахад оролцоогүй хуулийн этгээд оролцсон баримт бичгээр төлөөлүүлж *“гэрээ зөрчсөн”* байх тул уг 3.5 дахь заалтыг цаашид мөрдөх үндэслэлгүй гэж үзэж байна. ХөОГ-ээр *“барих, ашиглах”* нөхцөлөөр Зэс хайлуулах үйлдвэр барих Айвенхоугийн үүргийг *“эдийн засгийн боломжийн судалгаа”* хийснээр хаах нь Зэс хайлуулах үйлдвэрийг ОТ ХХК барихгүй, оролцохгүй гэсэнтэй адил утгатай болгожээ.

3.4. Төлөвлөгөөний 4.2-д ОТ төслийн ТЭЗҮ-ийг *“тодорхойгүй, магадлашгүй хүчин зүйлийн төсөөлөлд тулгуурласан, ОТ-н үйл ажиллагаанд заавал мөрдөх баримт бичиг биш”* гэж тодорхойлсон нь Хөрөнгө оруулалтын гэрээг зөрчиж, ТЭЗҮ нь эдийн засгийн ямар ч үндэслэлгүй, хэрэггүй цаас гэсэн утгаар тодорхойлж, аль ч үйлдвэр байгуулахад түүнийг барьж байгуулагч, ашиглагч төлөвлөгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч, ажиллуулагч, менежмент гүйцэтгэгч бүх байгууллагад удирдлага, чиглэл, мөрдөх баримт бичиг байдаг зүй тогтнолыг үгүйсгэсэн нь нэн харамсалтай байна. ТЭЗҮ-д зохих нэмэлт, өөрчлөлт, тодруулга гарч болох бөгөөд тэр дагуу уг ТЭЗҮ-ийг тодруулан шинэчилж, батлан мөрддөг. Энэ нь ТЭЗҮ-ийг мөрдөхгүй дураараа ямраар ч үйлдвэрийг барьж ажиллуулах гэсэн утга агуулдаггүй. Иймээс энэ заалтын *“... мөрдөх баримт бичиг биш”* гэснийг өөрчлөх.

3.5. Төлөвлөгөөний 4.4; 4.5-д ОТ ХХК-ийн 2010-2014 оны таван жилийн тайланг таван хоногийн дотор хүлээн авахыг Сангийн яаманд, монголын талаас үзүүлсэн татварын хөнгөлөлт нь 646.2 сая ам.доллараас “багагүй” болохыг УТЕГ нь ажлын хоёр хоногийн дотор баталгаажуулах яаралтай үүргийг тус тус хүлээлгэсэн нь Монгол Улсын хуулийг илт зөрчсөн, яахаар жил бүр Сангийн яаманд тушаах ёстой тайлан тэнцлийг таван жил өгөөгүй байсан, яагаад бөөндөж тайланг тушаах болсон, яагаад жил бүр, эсвэл гэрээ байгуулсан даруйд хийх татварын хөнгөлөлтийн 2009-2012 оны тооцоог 4-6 жилийн дараа 2015 онд хийх болсон, яахаар уг хөнгөлөлтийн дүн 646.2 сая ам.доллараас бага байж болохгүй, заавал илүү байх үүргийг татварын байгууллагад өгч, хууль зөрчсөн байсан ч баталгаажуулах ёстой вэ? Яагаад аливаа компани нь тухайн улсын

санхүү, татварын байгууллагатай хуулийн дагуу жил бүр хийдэг татварын тооцоог Засгийн газраас үүрэг авч гүйцэтгэх болсон бэ? гэсэн асуулт гарч байна. Хэрэв энэхүү “төлөвлөгөө” гэх баримт бичгийг гэрээтэй дүйцүүлж, Талуудын тохиролцоо, гүйцэтгэх үүрэг, эрх зүйн баримт бичиг гэж үзэж байгаа бол энэ нь буруу бөгөөд урьд жилүүдэд хийгээгүй ажлаа, эсвэл зөрчил гаргаснаа ийнхүү баримт бичгээр далимдуулан Гэрээний заалтыг өөрчлөх гэж байгааг засах нь зүйтэй гэж үзэж байна. Нөгөө талаар, татварын хөнгөлөлт (*урьд оны*) нь 646.2 сая ам.доллар болсон бол Монголын төр (ТӨК)-өөс ОТ ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт мөн энэ хэмжээгээр нэмэгдэх үндэслэл байгааг ярих нь чухал юм. Түүнчлэн алдагдлын хэмжээ хэд болохыг Компанийн тайлан тэнцлийг үндэслэн тооцдог бөгөөд энд заасан шиг 4-6 жил өнгөрсний дараа 2009-2012 оны алдагдлыг 2015 оны тавдугаар сард тодорхойлох ямар ч үндэслэл байхгүй учраас дээрх 4.4; 4.5 дахь заалтыг өөрчлөх шаардлагатай байна.

3.6. Төлөвлөгөөний 5.5-ын “v”-д Рио Тинто-ийн баталгааны шимтгэлийг санхүүжилтийн үндсэн дүн, хүү, шимтгэл, төлбөрийн нийт дүнгээс 1.9 хувиар тооцож олгохоор заасан нь хэт өндөр бөгөөд уг баталгааны шимтгэлийг тооцоход зээлийн хүү, шимтгэл, бусад төлбөр ямар ч хамаагүй бөгөөд зөвхөн санхүүжилтийн дүнгээс тооцох нь зүйд нийцэх учраас энэ заалтаас нэн түрүүнд “хүү, шимтгэл, төлбөр” гэснийг хасах.

3.7. Төлөвлөгөөний 5.6-д Монгол Улсын Засгийн газар нь зээлийн барьцаанд Оюу толгойн уурхайн ашигт малтмалын бүх тусгай зөвшөөрөл, ХөОГ, ХНГ-д тусгагдсан бүх эрх, ОТ ХХК-ийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалахыг зөвшөөрсөн. Гэтэл уг баримт бичигт зааснаар, ОТ-н ордоор барьцаа болгон баталгаа гаргах Рио Тинто баталгааны өндөр шимтгэл авч байгаа атал Монголын төр (ТӨК) шимтгэл авахгүй байгаа нь дэндүү шударга бус, монголын өрийг яаж өсгөх вэ? гэсэн бас нэг луйврын арга болгож, монголын орд газар барьцаалсан баталгааны шимтгэлийг нь Рио Тинто ганцаар авах эдийн засгийн үндэслэл огт байхгүй. Энэ заалтаар Монголын тал хэтэрхий мэдлэггүйгээс Рио Тинто-д буулт хийж, зээл, хүү, шимтгэл, төлбөрийн дүнгээс 1.9 хувиар бодож монголын өрийг өсгөхийг зөвшөөрснийг өөрчлөх, юуны түрүүнд ТӨК бас шимтгэл авдаг болохоор өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Зөвхөн ОТ ХХК-ийн үл хөдлөх хөрөнгө барьцаалахад 34 хувь нь Монголын талын хариуцах дэнчин шүү дээ. Гэтэл шимтгэл буюу шангийг нь зөвхөн Рио-Тинто өндөр хувиар авах нь арай ч хэт нэг талын сонирхол бус уу? Иймд баталгааны шимтгэл төлөхгүй болгох, эсвэл Рио Тинто, ТӨК адилхан шимтгэл авдаг болгохоор дээрх 5.5; 5.6 дахь заалтыг өөрчлөх.

3.8. Төлөвлөгөөнд АМНАТ-ыг зөвхөн зэс, алт, мөнгө зэрэгт төлөхөөр заагаад, бусдыг орхигдуулсан байна. Ядахдаа ХөОГ-д заасан молибденд АМНАТ төлөх учиргүй гэж тохирсон нь үндэслэлгүй байна. Тэрчлэн хүдэр дэх металл эрдэс бүтцүүдэд ч “ $30+20+20=70$ ” жилд АМНАТ төлөхгүй байх үндэслэл байхгүй. Иймд 6.2-д “молибден” гэж нэмэхийн хамт хүдэр дэх металл эрдсүүдийг АМНАТ-т хамааруулах асуудлыг Талууд тухайн үед хамтарч

шийдвэрлэх заалт нэмж оруулах.

Дөрөв. Дүгнэлт, санал

4.1. Оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, мөрдөх нөхцөл, журам болж буй ХөОГ, ХНГ болон Төлөвлөгөө гэх баримт бичгүүдэд зохих өөрчлөлт, тодруулалт хийж, хэт шударга бус, нэг тал буюу Рио Тинто-ийн үлэмж сонирхлоор байгуулсан, Монголын төр (ТӨК)-ийг явал өр ихтэй болгож, түүнд ногдол ашиг төлөхгүй байх вэ? гэсэн агуулгаар тохирсон нөхцөл, заалтыг даруй өөрчлөх нь нэн чухал байна.

4.2. Монголын олон нийтээс зөвхөн ОТ ХХК-д зориулсан, 30 жил, цаашид 50 жил, 70 жил баримтлах нөхцөл, журамтай, тэдгээр нь хэт хөнгөлөлттэй, Монголын ижил аж ахуйн нэгжээс бага татвар төлдөг, тэр нь 70 хүртэл жил өөрчлөгдөхгүй мөрдөгдөх, тэрчлэн аль болох Монголын төрийн өрийг нэмэгдүүлэх агуулга, журмаар тохирсон, “Улсын доторх улс” гэж үзэгдэх Оюу толгой гэж баялаг орд, байгалийн хишгийн үлэмж хэсгийг гадаадынхан үндсэндээ хүртсэн уурхай байхыг эсэргүүцэх нь зүй ёсны хэрэг гэж үзэж байна.

4.3. ОТ-н уурхайн дээрх баримт бичгүүдэд бидний саналын дагуу нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд ил тод болгон хэрэгжүүлбэл “төлөвлөгөө” гэгчид заасан ОТ уурхайн үр ашгийн 53 хувь Монголд ногдоно гэсэнтэй ойролцоо тоо гарах боломж бий болно.

4.4. Хэлэлцээ хийх, санал боловсруулахад дараах асуудлыг онцлон анхаарах:

- a. Татварын хөнгөлөлт, тогтворжуулалтын заалт бүх татварт хамаарах бус, хуульд заасан дөрвөн нэрийн татварт тогтворжихоор тохирох. Юуны түрүүнд гэрээний эхний хугацаа дуусахад (*гэрээгээр 30 жил*) татварын хөнгөлөлт, тогтворжилтийн талаарх заалтыг цаашид мөрдөхгүй болгох;
- b. Уурхайн хаалтын менежмент, журам, хаалтын сангийн талаар тодорхой заах, гэрээнд зааснаар хаалтын санг ганцхан Монголын төр хариуцах бус, компани нь ногдол ашиг төлөхийн өмнөх ашгаас гаргадаг болгох;
- c. Зэс хайлуулах үйлдвэр, цахилгаан станц барих асуудлыг шийдвэрлэж, хөрөнгө оруулагчийн үүрэг болгох (*гэрээнд шууд заагаагүй, шийдвэрлээгүй заалт орсон*);
- d. Оюу толгой ХХК-ийн бүтээгдэхүүн борлуулалтын орлого болон биет хэмжээ бүрэн бүртгэгддэг, өөрт үлдэх ашгаа гадаад, дотоодод чөлөөтэй зарцуулах журмыг баримт бичгүүдэд Монгол Улсын хууль, аж ахуйн байгууллагын орлого, зарлагаа тооцдог нийтлэг журам, бүртгэлийн олон улсын стандартын дагуу зааж, ил тод бус, эргэлзээ төрүүлсэн зүйлгүй болгох журам мөрдөхөөр тохирох;
- e. Гэрээний эхний хугацаа дууссаны дараа ОТ ХХК нь Монголын ижил төрлийн аж ахуйн нэгжийн адилаар ялгаварлан гадуурхахгүй журмаар тухайн үед Монгол Улсад мөрдөж байгаа хууль, эрх зүй, дүрэм,

- журмаар ажилладаг, татварыг ч мөн ижил зарчим, хэмжээ, журмаар төлдөг байхаар баримт бичгүүдийг өөрчлөх;
- f. Хувь нийлүүлэгчид, ТУЗ нь шийдвэр гаргахдаа “олонх” гэдэгт Айвенхоу, ТӨК-ий нэг нэг төлөөлөл (гишүүн) заавал оролцож, зөвшөөрсөн байвал шийдвэр хүчинтэй болохоор ХөОТ-д өөрчлөлт оруулах;
 - g. Менежментийн багийг томилох, ялангуяа үйлчилгээний төлбөр төлөх журмыг заавал өөрчилж, орлого илүү олох сонирхол, хөшүүргийг нэмэгдүүлсэн журам тогтоох;
 - h. Компанийн жилийн төсөв, санхүүжилттэй холбогдуулан Монголын өрийг өсгөхөөр заасан ямар ч утгагүй, үндэслэлгүй журам, заалтыг өөрчлөх;
 - i. “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” гэх баримт бичгээс далд уурхайтай шууд хамаарахгүй “Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө” гэсэн мэдээлэл, дүгнэлт болон Сангийн яам, татварын байгууллагад яаралтай үүрэг өгсөн заалт, татварын хөнгөлөлт болон алдагдлын хэмжээ зэргийг хасах;
 - j. ХөОГ ба ХНГ-ий зарим заалтыг зөрчиж, “Төлөвлөгөө” гэх баримт бичигт заасан, буулт хийсэн хэсгийг манай саналын дагуу өөрчлөх.

* * *

УИХ-аас томилогдсон Ажлын хэсэг нь дээрх гурван баримт бичгийн журам, заалт 2009 оноос хойш хэрхэн мөрдөгдөж ирсэн, татвар хэрхэн төлсөн, чөлөөлсөн, тогтворжуулсан, Монголын төрд хичнээн зээлийг юунд зориулж олгосон, түүний хүү, АНУ-ын үнийн индексээр нэмэгдүүлсэн байдал, Оюу толгой компанийн жил бүрийн төсөвт зардлаар Монголын ТӨК нь урьд онуудад хичнээн зээл авсан, төлбөр нь хэрхэн хийгдэж байгаа, компанийн удирдлага, шийдвэрт Монголын тал ямар ч оролцоогүй буй эсэх, олонхийн шийдвэр хэрхэн нөлөөлж буй гэх мэт олон асуудлыг бодитоор судалж, дүгнэлт хийхэд гэрээнүүдэд ямар өөрчлөлт хийх шаардлагатай болох нь тодорхой болох бөгөөд баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийг түүнд тулгуурлан хийвэл зохино.

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТОВЧ ТОЙМ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Л.Дамбадорж¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
A22, D51, E69	Аливаа үйл ажил, тухайлбал, сансарт ниссэн ч, газрын гүн рүү өрөмдсөн ч, айл саахалтдаа очиж цайлуулж, дайлуулсан ч, хүүхдээ сургууль цэцэрлэгт нь хүргэсэн ч, нэг харандаа авсан ч эдийн засагтай л холбоотой үйлдэл. Эдийн засагтай холбоотой үйлдэл бүхэн арилжаа наймаагаар л хэрэгждэг.
<i>Түлхүүр үг:</i>	
Ардын хоршоо, худалдааны салбар, гадаад худалдаа, экспорт, импорт	

Ардын хувьсгал ялсны дараа өөрийн гэсэн үндэсний эдийн засгийн суурь тавих зорилт тулгарсан нь зүйн асуудал. Ингээд Д.Чагдаржав, гүн Цэдэвсүрэн нарын санаачилгаар юуны өмнө ардын хоршоо байгуулахаар болж хөрөнгө цуглуулж эхэлжээ. Үүнд зориулж хандив цуглуулах ажлыг 1921 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлснээр гүн Цэдэвсүрэн, Богд Жавзандамба, эх дагина Дондогдулам, баатар ван Наваан-Юндэн (*МУИС-д багш байсныг тухайн үеийнхэн мэднэ дээ*), Шүүх яамны тэргүүн сайд Магсаржав (*манай улсын цэргийн нэртэй жанжин*), гүн Цогтбадамжав (*Ардын хувьсгал ялахад жанжин Д.Сүхбаатарт бэлэглэсэн байшин нь одоогийн Улаанбаатарын музей гэж Монгол бөхийн өргөөний хажууханд байгаа*), Их Нацагдорж, ван Ширнэндамдин, ёнзон хамба Лувсанхаймчиг (*Богд хааны дүү гэдэг*), С.Буянэмэх (*зохиолч*), сэцэн хаан Навааннэрэн (*Чингисийн алтан ургийн хаадын сүүлчийнхний нэг*), Х.Чойбалсан, Д.Чагдаржав, Д.Сүхбаатар, Сангийн яамны сайд С.Данзан, Ерөнхий сайд Д.Бодоо, Жалханз хутагт Дамдинбазар, жинхэнэ орлогч сайд Б.Цэрэндорж, Намын төв хорооны дарга Ц.Дамбадорж, Жамъян гүн зэрэг алдар цуутай түүхт хүмүүс, энгийн ард, лам хувраг, ноёд түшмэд, цэрэг, залуучууд зэрэг 116 нөхөд 5 лангаас 500 лан хүртэл мөнгө хандивласан нь 1922 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр болоход буюу хоршоо байгуулах кампанит ажил эхлээд 32 хоног өнгөрөхөд нийт 5963 лан цалин цагаан мөнгө болоод байжээ (*манайхан ийм л гарамгай шуурхай, идэвх санаачлага сайтай, шинэ юмыг дэмжимтгий ард түмэн дээ*). Ардын хоршооны анхны гишүүд нь дээрх 116 хүн болж 1921 оны 12 дугаар сарын 16-нд хоршоо буюу манай улсын эдийн засгийн нэг гол чухал том салбар – худалдаа байгуулагдсан түүхтэй. Дотоод, гадаад худалдаа эрхлэх анхны газрыг байгуулах ажлыг түргэтгэх үүднээс 1921 оны 11-р сарын 15-нд Засгийн газар

¹ МУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн профессор, Монгол Улсын гавъяат багш. Цахим шуудан: a.unur@yahoo.com

шийдвэр гаргаж нэг түм 10 лан цалин цагаан мөнгө (*1 лан=37.3 грамм, нийт 3 тонн 733 кг 730 грамм*) ирүүлснийг Хоршоо байгуулахаар сэдсэн нөхөд хүлээж авч байжээ.

1921 оны 2 дугаар сарын 18-нд Хиагт хотоос гамин цэргийг хөөхөд ундуй сундуй үлдсэн хятадын пүүсийн эд барааг жанжин Д.Сүхбаатар хулгай дээрмээс хамгаалж Оросын Центросоюзын агуулахад хадгалуулсан байсныг ердийн хөсгөөр лам Мөржав нарын жинчид 1921 оны 10 дугаар сарын 20-нд авчирч хоршооны нярав Дугар, орос Даш, буриад Бадамжав нарт хүлээлгэн өгсөн нь 22971 лан 2 цэн 9 пунгийн үнэ бүхий хөрөнгө болж байсан гэдэг (*тун нарийн тооцдог байж*).

Үндэсний худалдаа байгуулах үйл хэрэг ийм байдлаар зохих хэмжээний хөрөнгөтэй болж, тэр үеийн аймаг, хошуу, хүрээ хийд төвлөрсөн газар нутагт эд хэрэглэгчдийн буюу харилцан туслалцах хоршоо байгуулагдаж эхэлсэн байна. Хамгийн эхнийх нь Хатгал харуулд (*ЗХУ-аас бараа импортлох, манайхаас түүхий эд экспортлоход хамгийн дөхөм газар*) хоршооны анхны салбар нээсэн, дараа нь Сайнноён хан аймгийн Заяын хүрээ (*Архангай аймгийн төв*), Түшээт хан аймгийн Сэцэн вангийн хошуу (*Төв аймаг, Дэлгэрхаан*), Сэцэн хан аймгийн жонон вангийн хошуу (*Хэнтий, Өмнөдэлгэр*), мөн аймгийн Санбэйсийн хүрээ (*Дорнод, Чойбалсан хот*), Улиастай хот (*Завхан аймгийн төв*), Сайнноён ханы хүрээ (*Өвөрхангай, Уянга*), Алтанбулаг (*Сэлэнгэ аймгийн төв*) гэхчлэн бүх аймаг, хошууд болон одоогийн Өвөр монголын Хаалганд хоршооны салбар байгуулж байсан аж.

Манай орны Харилцан туслалцах хоршоо 1922 онд 1988 гишүүнтэй, 58.8 мянган төгрөгийн хувь хөрөнгөтэй болж, 122.6 мянган төгрөгийн бараа худалдаж, 61.4 мянган төгрөгийн түүхий эд бэлтгэж, 22 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байжээ (*энэ тоо одоо үед өчүүхэн харагдавч тэр үед идэшний ирэг 20-30 мөнгө хүрч байсан уу, үгүй юү, 1947 оны үед идэшний хонь 5 төгрөг хүрэхтэй үгүйтэй байсан гэдэг*). 1925 онд хоршооны гишүүд нь 3481, хувь хөрөнгө нь 138 мянган төгрөг болж 5,133.6 мянган төгрөгийн бараа худалдаж, 2,907 мянган төгрөгийн түүхий эд бэлтгэснээр дотоод зах зээл дэх бараа эргэлтийн 20-25 хувийг эзэлж байсан нь тэр үедээ томоохон амжилт болж байсан гэдэг.

Монгол-Оросын худалдааны анхны гэрээг 1923 оны 6 дугаар сард Москва хотноо байгуулсан бөгөөд тэр үеэс эхлэн Оросын худалдааны Сибторг, Монгол шерсть, Кожсиндикат, Центросоюз зэрэг гадаад худалдааны салбар манайд нээгдэж шинэ тутам буй болсон Харилцан туслалцах хоршоотой хамтран ажиллаж эхэлснээр зөвлөлтийн бараагаар хангагдаж хятадын олон пүүс, америк, герман зэрэг гадаадын худалдааныхантай амжилттай өрсөлдөж эхэлсэн байна. Энэ өрсөлдөөндөө барааны үнийг тэднийхнээс хямдаар ард түмэнд худалддаг, түүхий эдийн үнийг тэднийхнээс илүү үнээр ард түмнээс худалдан авдаг байж. Ийнхүү яван явсаар дотоод, гадаад худалдаанд манай улс дангаар ноёрхох эзэн нь болж чадсан түүхтэй.

Эд хэрэглэгчдийн хоршоодын байгууллага өсөж хөгжсөөр, хөдөөд сум бүрт хоршооны бараа, түүхий эдийн агуулахтай, дэлгүүр мухлагтай, баг бүрт худалдаа бэлтгэлийн нэгээс хоёр агенттай болж, бараа татан авах болон түүхий эдийг экспортлох дамжлага баазад хүргэх тээврийн системтэй, худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөтэй, худалдаа бэлтгэлийн ажил гүйлгээний авцаа, өгцөөний тооцоог дав даруй гүйцэтгэх банк, тооцооны салбартай болсон юм. Эд хэрэглэгчдийн хоршооны салбар төлөвшин тогтож бааз суурьтай болсныг түшиглэж, нийтийн хоолны газар, хүүхдийн цэцэрлэг, тариа, ногооны болон гахай, тахианы аж ахуй, нүүдлийн кино, хөдөө аж ахуйн машин, техникийн засварын газар зэргийг байгуулан ажиллуулж байсан ба улсын төсвийн орлого бүрдүүлэхэд хоршоо худалдааны байгууллагуудын оролцоо их байсан (*анхны үед улсын төсвийн орлогын 90 хүртэлх хувийг бүрдүүлдэг байсныг статистикийн тоо мэдээнээс харж болно*) нь тухайн үеийн түүх юмаа. Хувьсгалын эсэргүү гэгдэх ардын бослогын үед, мөн хязгаар нэвтрэлтийн үед хоршооны байгууллагууд дээрэм тонуулд өртөж шатаалгаж, ор мөргүй болж, ажилтан албан хаагчид нь амь хохирч байжээ. Эд хэрэглэгчдийн хоршооны салбарыг 1959 онд улсын худалдаа болгосноор Хоршоодын төв холбоо нь Худалдаа, бэлтгэлийн яам, аймгуудын Хоршооны холбоод нь Худалдаа, бэлтгэлийг удирдах газар, сумдын анхны хоршоод нь Худалдаа, бэлтгэлийн анги гэгдэх болж өөрчлөгдөн хөгжиж ирсэн юм.

Дайны жилүүдэд ЗХУ-аас авах барааны хэмжээ төрөл ихээхэн багассан нь мэдээж, гэхдээ л зөвлөлтөөс зохих хэмжээгээр бараа авсаар л байж. Харин улсын бэлтгэлийн ажлыг ихэд шамдангүй зохион байгуулж, улаан цэргийн хэрэгцээг бага ч гэсэн хангахад чадах чинээгээрээ оролцож байсан юм. Манай хотын хүн ам цөөн байсан ч гэсэн дэлгүүр хоршоонд шороотой улаан давснаас өөр юмгүй болж, бараа таваар тун их хомсодсоноос нэлээд зутарч дайны жилүүдийг өнгөрөөсөн бол хөдөөгийн айл өрхүүд агт морьдоо фронтод бэлэглэж, заримыг нь худалдаж байсан ба ноос үс, арьс шир, мал сүргээ зөвлөлтөд худалдахын зэрэгцээгээр ан амьтдыг агнаж, их хэмжээний мах бэлтгэн нийлүүлж байсан бөгөөд айл бүр арьс нэхий элдэж, дээл хувцас, бээлий, хантааз хийж улаан армид бэлэглэж байсан. Ингэлээ гээд манай ард түмэн өлсөж цангаагүй, даарч хөрөөгүй, ядарч туйлдаагүй нь ямар ч зардал сүйтгэлгүйгээр цаг ямагт өсөн үржиж байдаг таван хошу малынхаа буянаар дайны хүнд үеийг царагтай давсан байдаг юм.

Ардын хувьсгалын анхны жилд үүсгэн байгуулсан манай улсын эдийн засгийн анхны байгууллага – хоршоо худалдааны өгөөж буян маш ихийг үнэлж барамгүй билээ. Ардчилсан хувьсгал болж хуучин тогтолцоог нураан унагаагаад цааш явахад эдийн засгийн үндэс буюу хөрөнгө мөнгө зайлшгүй шаардагдана. Ардын хувьсгал болоход гадаадынхны боолчлол дарлалаас чөлөөгдсөнөө мэдэрсэн ард түмэн нийтээрээ шахам хандив хөрөнгө цуглуулсан бол ардчилсан хувьсгал болоход тэр хувьсгалын үр өгөөжийг ард түмэн огт мэдэхгүй, ойлгоогүй, ойлгуулж ч амжаагүй байсан учраас хэнээс ч, хаанаас ч, аль ч улсаас эдийн засгийн тусламж харах боломж байгаагүй нь тов тодорхой.

Ардчилсан хувьсгалчид маань хөрөнгө босгох мэргэн арга олсон нь худалдаа, бэлтгэл, нийтийн хоолны газруудад байгаа эд барааны социализмын үеийн явцуу, зах зээлийн үнийг дэлхийн зах зээлд хүргээгүй, хүргэж болохгүй байсан ч гэсэн зохих хэмжээгээр нэмсэн нь билээ. Тийнхүү нэмсэн үнийн хөрөнгөөр ардчилсан хувьсгалын шинэ засгийн ажил үйлийг хэрэгжүүлэхэд нэмэр тус болж эхэлсэн гэдгийг үгүйсгэх хүн үгүй биз ээ. Энэ бол дотоод, гадаад худалдаа, бэлтгэл, нийтийн хоолны бүх газар байгууллагын өгөөж хаялга, энэ салбарыг батжуулж хөгжүүлэхэд амь биеэ зольж ирсэн үе үеийн зүтгэлтэн нөхдийн гавьяа мөнөөс мөн гэж бодном.

Монголын эд хэрэглэгчдийн хоршоодын төв холбооны даргаар 1922 оноос 1940 он хүртэл ажиллаж байсан Дамбын Чагдаржаваас Цагааны Дариймаа (*цаазлуулсан энэ хүний нэрээр нь бодвол эмэгтэй хүн бололтой. Говь-Алтайн Цээл сумын харъяат гэнэ*) хүртэлх 15 хүнээс 8 нь хилс хэргээр цаазлуулсан, хоёр нь учир битүүлгээр нас барсан, нэг нь 10 жилийн ял авсан, дөрөв нь зөнгөөрөө бурхан болсон гэдэг. Худалдааг удирдаж хөгжүүлэх үйлс нь удирдан хөтлөгчдийн хувьд амь насанд нь аюул учруулдаг осолтой ажил болж байжээ.

Ардчилсан хувьсгалын дараа бүх юм өөрчлөгдөж, эрх чөлөөтэй болсны үрээр манай залуучууд ганзагалж, гахай чирж явсаар худалдаа, наймаагаар эдийн засгаа шинээр босголцоод улам хөгжсөөр дэлхийн жишигт хүрсэн гадаад, дотоод арилжаа наймааны тогтолцоотой болгож чадсан нь үнэн гайхамшиг. Хотод ч, хөдөөд ч худалдааны том том дэлгүүр, захын сүлжээтэй боллоо, өнгөрсөн зууны тавиад оны үеийн Улаанбаатарт ганцхан ресторантай, хэдхэн дэлгүүртэй байсан бол өнөө үед өнцөг булан тойрох бүрт шахам том том дэлгүүр, баар ресторан, зочид буудал тааралдах болж, худалдаа үйлчилгээний ийм газрын тоо нэмэгдэх хэрээр хүмүүн ардын хэрэгцээ хангагдаж, худалдаа, үйлчилгээний газарт ажиллагчдын орон тоо нэмэгдэж, тэдгээр хүмүүс цалин хөлстэй болж ар гэрийнх амьжиргаа нь дээшилж байна. Татвар тушаалтаараа улсынхаа эдийн засгийг тэжээхэд буюу хүчжүүлэхэд ихэд тус дэм болж байна. Өнөө үед худалдаа үйлчилгээний тухайд дутагдаж гачигдаад байгаа юм үнэхээр “нүдний гэм” гээч болсон мэт.

Гэхдээ өө сэв байхаас аргагүй, өндөг шиг өөгүй юм гэж хаана байхсан билээ. Хамгийн гол нь дээрээ зааж залруулах, хянаж шалгах, тогтоон төвхнүүлэх харьяаны дээд газар байгууллагагүй учраас манай худалдаа үйлчилгээнийхэн “*намайг хэн хэлэхэв, нохойг хэн саахав*” гэдэгчилэнгээр аль нэг шалтгааныг далимдуулаад ч юм уу, ямар ч шалтгаан үндэслэлгүйгээр үнэ ханшийг хэт хөөрөгдөөд, өөрсдийнхөө орлогыг ч багасгаад, бор өдөр, хар шөнийг арай ядан өнгөрөөж байгаа ядуусаа болон нэмэгддэггүй шахам цалин, тэтгэвэртэй ард олныхоо амин зуулгыг улам л хүндрүүлээд байх шиг.

Улс орон бүхэн худалдааны яамтай, худалдааны хуультай байдаг шиг байгаа юм, худалдааны яамгүй, худалдааны хуульгүй улс орон манайхаас өөр хаана байдаг бол гэж бодном. Өнөө үед манай худалдааны нэрний “Х” үсэг аль нэг яамны нэрний товчилсон олон үсэг дотор харагдаж байдаг ч тэрнийг

нь “Худалдаа” гэж мэддэг, уншдаг хүн их цөөн. Худалдаа, бэлтгэлийн яамны болон гадаад худалдааны салбар гэгдэж байсан төрийн байгууллага устсанаас тэр бүтцэд ажиллаж байсан нөхөд хойно хойноосоо залгах үегүй болж өнөө үед үлдэзнээд байгаа хэд нь цөмөөрөө дал, наян насны дээс алхацгаачихаад, тэр “Х” үсэг нуугдаж байгаа газарт жилд нэг удаа очигсдын тоо жилээс жилд ертөнцийн жамаар цөөрөн цөөрсөөр нэгээхэн ч хөгшин ирэхээ болих нь тодорхой болжээ.

Шинэ цагийн худалдааны яамтай, төгс боловсронгуй хуультай болж, төр засгаас ард түмнийхээ болон цогцлон бүрдээд байгаа худалдаа, үйлчилгээний салбарын олон түмэн хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалж хянаж зохицуулж, улсын бодлогоор хөгжүүлж баймаар байна. Эрх чөлөөтэй болсноос хүн бүр шахам худалдаа, үйлчилгээний ажил эрхлэх гэж оролдоод байгаа ч гэсэн энэ том салбарын тухай нэгдсэн мэдээлэлгүй, зах зээлийн хэрэгцээ хандлагыг тэр бүр ойлгох аргагүй байдаг, хууль, дүрэм журам, зохицуулалт байдаггүй учраас оруулж ирсэн бараа нь гүйгддэггүй, эсвэл бусадтай ижил юм байдгаас лангуугаа сахиж, амьдралынхаа бүтээлч цаг хугацааг хий дэмий өнгөрөөсөөр лангууныхаа түрээсийг төлж чадахгүйд хүрч өдрийн зээлийнхэнд идүүлсээр дампуурах тийш хандах нь ихэсдэг бололтой.

Худалдаа, үйлчилгээг төрийн бодлогоор удирдан хянаж зохицуулдаг дээд байгууллагатай болох аваас импортоор орж ирж байгаа барааны чанар чансаа, гарал үүсэл, жинхэнэ үү, хиймэл үү? гэдгийг нь тодорхойлох, хүмүүн ардын эрүүл мэндэд хортой хүнс тэжээл, хувцас хунар, тоглоом наадгай, будаг шунх мэтийг шалгаж ялгаж, хорио цээр тогтоох, экспортлогч руу нь буцаах зэрэг ажлыг хэрэгжүүлэхэд харъяа лабораторитой баймаар байгаа юм. Орж гарч байгаа барааны үнэ цэнийг нь гаальд үнэн шудрагаар толилуулдаг болгоход ч тустай баймаар. Худалдаа хариуцсан яам байгуулахад төсөв, хөрөнгөнд дарамт нэг их үүсгэхгүй, харин ч төсвийн орлогыг үнэн магад бүрдүүлэхэд ч, хэрэглэгчидэд хүргэх үнийг үнэн зөв үндэслэлтэй болгоход ч, үнэ ханш хөөрөгдөлтийг хянаж тогтоон барьж байхад ч тустай болох буй заа.

“Хүн хэлээр, мал хөлөөр” гэдэгчлэн хэн нэгэн анзаарах ч юуны магад гэж мунхагласны учир Николай Рёрих (1874 онд төрсөн уран зураач, археологч, Шамбал судлаач, аялан жуулчлаач тэрбээр 1926 онд Монголд ирж жил шахам хугацаанд судалгаа хийж, монгол сэдвээр олон зураг зураад, тэр зурагнуудаасаа “Шамбалын хаан Рэгдэндагва” хэмээх уран зургаа манай Засгийн газарт бэлэглээд 1927 онд Түвд, Энэтхэг руу явсан. Энэтхэгт ажиллаж, аж төрж байгаад 1947 онд өөд болсон гэдэг)-ийн “Хорвоо ертөнцийн долоон их нууц” хэмээх том номондоо **Шинэ эриний ойлголт** (Шинэ эрин гэж Загасныхаас Бумбын эринд 2012 оны эцсийн янар шилжсэн 2160 жил үргэлжлэх үеийг хэлжээ) гэсэн гарчиг доор дурдсан нэгэн айлдварыг нь онцлон толилуулсу: “Дорно дахины орчин үеийн сургаал ёсоор энэ эриний хувьсалын үе шат нь, нэгдүгээрт, **хамтын ажиллагаа** буюу **хоршоолол**; хоёрдугаарт, **эмэгтэйчүүдийн бүрэн эрх мэдэл**; гуравдугаарт, **сэтгэл зүйн энергийг буюу эрчимт увидасыг судлахуй**; дөрөвдүгээрт, **сэтгэцийн учир утгыг ойлгохуй** юмаа. Хувьсал өөрчлөлтийн

энэ дөрвөн өгөгдлийг бүхэл бүтнээр нь, салангид бишээр авч үзэх ёстой” гэжээ. Цаашлаад хамтын ажиллагаа бол оршихуйн болон цогцлон бүтээхүйн үндэс, нэг нэгэндээ итгэхгүй бол хамтын ажиллагаа нь “*лаазанд хийсэн хорт аалзнууд дугаа адил*” болж төрийн хөнөөлт хүчин чадал улам ихсэж ард олныг ихэд дортгох болой. **Хамтын ажиллагаа** нь бүтээн байгуулалтын үндэс болсон тэр цагт, **эмэгтэйчүүд** нь соёл уламжлалын хамгаалагч болж чадсан тэр цагт, **сэтгэл зүйн энерги** нь байх ёстой байр сууриа эзэлсэн тэр цагт, **бүтээлч сэтгэлгээний** ач холбогдлыг хүмүүн төрөлхтөн ухаарсан тэр цагт бүхий л аж амьдрал өөрчлөгдөн шинэчлэгдмүй гэхчлэн бичсэн байгаа юм. Ийнхүү хувьсалын дөрвөн үе шатны өгөгдлийг нэгэн доор нэгтгэж чадвал чи тэр намынх, би энэ намынх; чи муу, би сайн; чинийх буруу, минийх зөв; чи хар, би цагаан; чи долоог авсан, би долоохоныг авсан; танай хүүхдийн буруу, манай хүүхдийн зөв гэхчлэн эцэс төгсгөлгүй маргалдаж цэцэрхэхгүйгээр нэг нэгнээ сайтар ойлгоод эв эе олохыг урьтал болгоод буруу бол буруугаа засаад, зөв бол зөвөө улам бататгаж дэлгэрүүлээд байж чаддагсан бол манайх шиг цөөн хүн амтай, юугаар ч дутахааргүй баялагтай орон ямар ч саад тотгоргүйгээр хөгжиж дэвжсээр байж болмоор мэт.

“Ажил үйл хийдэггүй хүн

Алдаа мадаг гаргах нь үгүй,

Алдаа эндэл гаргадаггүй тэрбээр

Арга ухааныг юунаас сурахсан билээ дээ” гэж нэгэн ухаантан айлдсан нь буй. Иймээс алдаагаа мэдээд арилгаад зөв чиг замаар дээшилж болмоор. Энэ бүхнийг мэддэггүй, ойлгодоггүй хэн гуай ч байхгүй, гэхдээ л болгоож болдоггүйн шалтгаан нь нэг нэгнээ уучилж, эвлэрч чаддаггүй, эвлэрч эвсэхээр тэрнийг нь буруутгаж сурталдаад, үүний чинь цаана ийм тийм олз ашиг нуусан байгаа юм, эд нар ингэж хуйвалдаад идэж уух нь, ард түмнийг хохироох нь энэ тэр гэж хазайлгаж мурийлгаад нэг их том гэмтэнгүүдийг илрүүлээд байгаа юм шиг дүр төрх үзүүлээд мэдээллийн хэрэгслээр шуугиан дуулиан болгоод байдагт ч бас байж мэдэх.

Сэдвээсээ хазайлаа гэж бүү бодтугай. Аливаа үйл ажил, тухайлбал, сансарт ниссэн ч, газрын гүн рүү өрөмдсөн ч, айл саахалтдаа очиж цайлуулж, дайлуулсан ч, хүүхдээ сургууль цэцэрлэгт нь хүргэсэн ч, нэг харандаа авсан ч эдийн засагтай л холбоотой үйлдэл. Эдийн засагтай холбоотой үйлдэл бүхэн арилжаа наймаагаар л хэрэгждэг. Ийм учраас худалдааны сэдвийнхээ дуусгал болгож ийн чадан ядан бичиглэвэй.

Болгоотугай эрхэм хүндэт нөхөд минь!

L.Dambadorj

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

МОНГОЛ УЛСЫГ ИННОВАЦИЙН ЧИГ ХАНДЛАГААР ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Л.Оюунцэцэг¹

JEL ангилал:

D04, E60,

Түлхүүр үг:

мэдлэгт суурилсан эдийн засаг, инноваци, аж үйлдвэрийн IV хувьсгал, үндэсний хөгжил, шинэ парадигм

Хураангуй:

Орчин үеийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлага “мэдлэгийн эдийн засаг”-ийг бүтээн байгуулахад чиглэгдэх боллоо. Аливаа улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд шинжлэх ухаан, технологи (ШУТ), инновацийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацийн үйл ажиллагаа эрчимжиж, аж үйлдвэрийн хувьсгал 4 дүгээр шатанд шилжин орсноор нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ хандлага бий болжээ. Энэ нөхцөлд манай орны тухайд ирээдүйн хөгжлийн чиг баримжаагаа зөв, үндэслэлтэй тодорхойлсон оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал юм. Энэхүү бүтээлд мэдлэгийн эдийн засаг, инновацийн хөгжил, аж үйлдвэрийн IV хувьсгалтай уялдуулан Монгол Улсын хөгжлийн чиг хандлагын асуудлыг авч үзлээ.

1. Дэлхий дахины хөгжлийн чиг хандлага

Өнөө үед дэлхий нийтийг хамарсан нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны глобаль асуудлууд илүү хурцадмал шинжтэй болж, улс үндэстэн хоорондын харилцан хамаарал улам бүр нэмэгдэн, даяаршлын үйл явц эрчимжиж, хүн төрөлхтөн хөгжил дэвшлийн цоо шинэ эрин үед шилжин орж байна.

Энэхүү үйл явц нь улс үндэстэн хоорондын эдийн засаг, аж ахуйн харилцааг хөнгөвчилж, хялбар дөт болгож, нийгэм-эдийн засаг, ШУТ, оюунлагийн хүрээн дэх хүн төрөлхтний тэргүүний ололтыг өргөнөөр түгээн дэлгэрүүлэх, харилцан солилцох өргөн боломж бүрдүүлэн, улс орнуудын хөгжилд түлхэц үзүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг эерэг нөлөө үзүүлж буй юм. Гэвч түүний сөрөг тал цөөнгүй байгааг улс орнуудын үйлдвэрлэл, эдийн засгийн үйл явц гадны сөрөг нөлөөнд нээлттэй болдог, бүс нутгийн шинжтэй эдийн засгийн доголдол нь богино хугацаанд хурдацтай тархдаг (*Жишээлбэл, дэлхийн санхүүгийн хямрал болон өрнөсөн Ази, Латин Америкийн 1997-1998 оны хямрал, Евро бүсийн хямрал г.м.*), улс дамжсан богино хугацаат капиталын урсгал, санхүүгийн луйвар, эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал дэлхий дахинд үүсэхэд нөлөөлдөг зэргээс харж болно.

“Баян” ба “ядуу” (*буурай*) орнуудын хүн амын амьжиргааны түвшин, даяаршлын үйл явцад хамрагдах оролцоо харилцан адилгүй, ихээхэн ялгавартай

¹ ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Бизнесийн ахисан түвшний сургуулийн профессор. Цахим шуудан: l.oyuntsetseg@must.edu.mn

байна. Хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгө нөөц хангалтгүй, үндэсний эдийн засаг, удирдлага зохицуулалт, эрх зүйн тогтолцоо боловсронгуй бус байдгаас шалтгаалсан даяаршлын үйл явцад дасан зохицох чадвар дутагдаж, улмаар хүчирхэг “*тоглогчдын*” тоглоомын дүрмийг өөртөө ашиггүйгээр хүлээн авахад хүрдэг ажээ [1, 2]. Түүнчлэн, эдгээр орнуудад технологийн түвшин, хөдөлмөрийн үнэлэмж доогуур байдгаас оюуны нөөцийн гадагшаа чиглэсэн урсгал явагдаж, ажилгүйдэл өсөн нэмэгдэж, зохион байгуулалттай гэмт хэргийн цар хүрээ тэлж, олон улсын шинжтэй болж байна.

Дээрх нөхцөл байдал нь улс орнуудын хөгжлийн орчинг ихээхэн тогворгүй, тодорхойгүй болгож байгаа юм. Иймээс хүн төрөлхтөний ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг таамаглах, зураглал боловсруулах чиглэлээр цөөнгүй судалгаа бүтээлүүд гараад байгаа ба эдгээрийн дотроос АНУ-ын Үндэсний тагнуулын зөвлөлөөс гаргасан “*Глобаль чиг хандлага-2030. Альтернатив ертөнц*” хэмээх томоохон тайлан-илтгэлийг дурдаж болно [3]. Уг бүтээлд дэлхий дахины эдийн засаг, геополитик, ШУТ-ийн дэвшлийн хүрээнд гарч буй гол өөрчлөлтийг харгалзан дэлхийн хөгжлийн 2030 хүртэлх үеийн таамаглалыг боловсруулсан байна. Энд шинжээчид дараах үндсэн дөрвөн “мегатренд”-ийг тодорхойлжээ. Үүнд:

- *Мегатренд 1.* Хүний хөгжил, хувь хүний үзүүлэх нөлөөний өсөлт: Боловсролын хүртээмж, үр нөлөө, чанар дээшилж, эрүүл мэндийн салбар, харилцаа холбоо, үйлдвэрлэлийн технологийн хөгжлийн үрээр ядуурал буурч, хүн амын дунд орлоготой бүлгийн тоо нэмэгдсэнээр хүмүүст илүү өргөн боломж нээгдэх ажээ. Өөрөөр хэлбэл, хувь хүний нийгмийн үүрэг, оролцоо, нөлөө нэмэгдэнэ гэсэн үг.
- *Мегатренд 2.* Дэлхийн нийгэмлэг дэх олон туйлт хандлагын гүнзгийрэл: 2030 он гэхэд ДНБ, хүн амын тоо, цэрэг, батлах хамгаалах болон технологийн хөгжлийн зардлаар Азийн улс орнууд дэлхийн тавцанд давамгайлах ба БНХАУ эдийн засгийн чадавхаар АНУ-ыг гүйцэж, дэлхийд тэргүүлнэ. АНУ манлайлагчийн байр сууриа алдаж, тэргүүлэгч улс орнуудын нэг болох аж.
- *Мегатренд 3.* Хүн ам зүйн хүрээний томоохон өөрчлөлт: 2012 онд 7.1 тэрбум байсан дэлхийн хүн ам, 2030 он гэхэд 8.3 тэрбумд хүрэхийн зэрэгцээгээр насжих процесс үргэлжилнэ гэжээ. Энэ үзэгдэл нийгэм-эдийн засгийн олон үр дагавартай.
- *Мегатренд 4.* Хоол хүнс, ус, эрчим хүчний эрэлт хэрэгцээний өсөлт: Дурдсан хугацаанд хүн амын хүнсний хэрэгцээ 35 хувь, усны хэрэгцээ 40 хувь, эрчим хүчний хэрэгцээ 50 хувиар нэмэгдэнэ гэсэн тооцоо гаргажээ. Үүний улмаас Африк, Ойрх дорнодын бүс нутаг нь хоол хүнс, усны үлэмж хэмжээний дутагдалд орох магадлалтай гэсэн таамаглал дэвшүүлсэн байна.

Уг тайланд дээрх томоохон өөрчлөлтийн зэрэгцээ ихээхэн уршигтай, урьдчилан таамаглах боломжгүй үйл явц, үзэгдэл тохиож болзошгүйг

анхааруулж, тэдгээрийн тоонд дэлхий нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт, евро бүсийн дампуурал, цөмийн дайн, дэлхийн соронзон оронд хүчтэй нөлөө үзүүлэх наран дээрх дэлбэрэлт гэх зэргийг хамруулжээ. Эдгээрийг “*хар хун*” гэж нэрлэсэн байна.

Ойрын ирээдүйд хүн төрөлхтөний түүхэнд ШУТ-ийн эргэлт гаргахуйц томоохон технологийн дэвшил бий болохын зэрэгцээ, дэлхий дахины хөгжлийн гол цөм барууны ертөнцөөс Азийн орнуудад шилжих хандлага эрчимжих ажээ. Ялангуяа мэдээлэл харилцаа, үйлдвэрлэлийн технологи, автоматжуулалт, нөөц ашиглалт, эрүүл мэндийн салбарт дэвшилтэт технологиуд улам бүр нэвтэрч томоохон боломжуудыг бий болгоно гэж үзэж байна. Эдгээрийг мэдээллийн технологи (*IT-Information Technologies*), үйлдвэрлэлийн технологи (*MT-Manufacturing Technologies*), нөөцийн технологи (*RT-Resource Technologies*), эрүүл мэндийн технологи (*HT-Health Technologies*) гэж томъёолжээ. Эдгээрийн комбинаци байдлаар хөгжих хандлагатай байгаа цоо шинэ технологи болох “*3D-Printing*” нь олон салбарт хувьсгалт өөрчлөлт авчирч болзошгүй байгааг цохон заажээ.

Түүнчлэн тайланд дэлхийн ирээдүйн үндсэн дөрвөн хувилбар (*scenario*)-ыг дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

I. *Унтарсан хөдөлгүүр (Stalled Engines)*: Дэлхийн эдийн засаг зогсонги байдалд орж, протекционизм эрс нэмэгдэн, даяаршлын үйл явц саарна;

II. *Нэгдэл (Fusion)*: Нэгдмэл дэлхий буюу улс орнууд эв нэгдэлтэй, идэвхтэй хамран ажиллах замаар эдийн засаг, геополитикийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ;


III. *Суллагдсан бэрл (Gini-Out-of-the-Bottle)*: Олон улс оронд нийгэм-эдийн засаг, улс төрийн тогтворгүй, хурцадмал байдал бий болж, сөргөлдөөн, тэмцэл газар авч, томоохон цар хүрээтэй хямрал үүснэ;

IV. *Засаг, төргүй дэлхий (Nonstate World)*: Дэлхий дахинд тулгарч буй глобаль асуудлыг шийдвэрлэхэд улс орнуудын төр, засгийн үүрэг оролцоо багасан, үндэстэн дамнасан корпорациуд шийдвэрлэх нөлөөтэй болно.

Нөгөө талаар, дээр дурдсанчилан, дэлхий дахинд уламжлалт эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үйл явц эрчимтэй өрнөж, энэ хүрээнд ШУТ, инновацийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Энэхүү “шинэ эдийн засаг”-ийн хүрээнд хүнийг хөгжүүлэх (боловсрол, мэдлэг, чадвар олгох, бүтээлч сэтгэлгээ, эерэг хандлагыг төлөвшүүлэх) болон мэдээллийн технологийн хүртээмжийн асуудал анхаарлын төвд оршиж байна. Учир нь мэдлэгт суурилсан эдийн засаг (*knowledge-based economy*)-ийн гол нөөц нь чадвартай, бүтээлч хүний нөөц хэмээн үздэг. Мэдлэгийн эдийн засгийн үндсэн шинжүүдийг нэгтгэн дараах байдлаар тодорхойлж болох юм (Зураг 1) [4].

Зураг 1

Мэдлэгийн эдийн засгийн үндсэн шинж



Тайлбар: 1- Глобал инновацийн тогтолцоо, 2-Үндэсний инновацийн тогтолцоо, 3- Бүсийн инновацийн тогтолцоо, 4- Салбарын инновацийн тогтолцоо, 5-Компани, байгууллагын инновацийн тогтолцоо

Эх үүсвэр: Оюунцэцэг Л. “Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол-арга зүйн үндэс (Монгол улсын жишээн дээр)”, Эдийн засгийн шинжлэх ухааны докторын дисс. ОХУ, Г. В. Плехановын Эдийн засгийн академи, Монгол Улсын ШУА, ШУТИС, КтМС, 2009, -264 х.

Түүнээс гадна, ШУТ-ийн дэвшлийн үр нөлөөгөөр нийгэм-эдийн засгийн бүхий л хүрээнд зарчимын, суурь шинжтэй, хувьсгалт өөрчлөлтүүд богино хугацаанд, түргэн хурдацтай явагдаж, инновацийн хөгжил эрчимжин, киберфизикийн системүүд аж үйлдвэрт өргөн хүрээтэй нэвтэрч, “Бүрэн автомат үйлдвэрлэл”, “BigData-analyse”, “Internet of Things”, “Virtual & Augmented reality”, “3D-printing”, “Blockchain” зэргийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн цоо шинэ хэлбэрүүд бий болж байгааг бүхэлд нь “*Аж үйлдвэрийн 4 дөрөвдүгээр хувьсгал*” хэмээн нэрлэх болсон ба үүний гол үзэл санааг Дэлхийн эдийн засгийн чуулганыг үндэслэгч Клаус Шваб дэвшүүлж, 2017 оны Давосын ээлжит чуулганаар уг асуудлыг тусгайлан хэлэлцсэн билээ. Анх 2011 онд ХБНГУ-ын бизнес эрхлэгчид, улс төрчид, эрдэмтэд хамтран тус улсын аж үйлдвэрийн салбарын хөгжлийг цоо шинэ шатанд гаргаж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн “Аж үйлдвэр 4.0” (Industry 4.0) санаачилга дэвшүүлснийг аж үйлдвэрийн IV хувьсгалын эхлэлтэй холбон авч үзэж байна [5, 6].

Ер нь хүн төрөлхтөний хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн аж үйлдвэржилтийн үйл явц XVIII зуунаас эхлэлтэй бөгөөд аж үйлдвэрийн хөгжилд гарсан томоохон хувьсгалт өөрчлөлтүүд, дэвшлүүдийг бүхэлд нь “Аж үйлдвэрийн хувьсгал” (Industrial Revolution) хэмээн нэрлэх болжээ. Уг нэр томъёог анх Францын эдийн засагч Жероме Бланк (1798-1854) шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан гэж үздэг.

Энэхүү үйл явцыг дараах үе шатаар авч үзэх болжээ [5].

1. XVIII зууны дунд–XIX зууны эхэн үе. *Аж үйлдвэрийн I хувьсгал: “Машины эрин үе”*
2. XIX зууны сүүлч–XX зууны хоёрдугаар хагас. *Аж үйлдвэрийн II хувьсгал: “Технологийн эрин үе”*
3. XX зууны хоёрдугаар хагас –XXI зууны эхэн үе. *Аж үйлдвэрийн III хувьсгал: “Тоон технологийн эрин үе”*
4. XXI зууны эхэн үеэс. *Аж үйлдвэрийн IV хувьсгал: “Дижитал технологийн эрин үе”*

Аж үйлдвэрийн I хувьсгалын гол хөдөлгөгч хүч нь гар хөдөлмөрөөс машинт үйлдвэрлэлд шилжихэд гол түлхэц болсон уурын машин байсан бол II хувьсгал цахилгаан эрчим хүчний хэрэглээ, дамжлагын масс үйлдвэрлэлээр; III хувьсгал нь тоон технологи буюу компьютерын техник, мэдээллийн технологийн; IV хувьсгал дижитал технологийн эрчимтэй хөгжлөөр тус тус тодорхойлогдож байна.

Аж үйлдвэрийн IV хувьсгалын талаар олон тооны судлаач судалгаа бүтээл туурвиж эхлээд байгаа бөгөөд түүний нийгэм-эдийн засгийн үр нөлөөг дараах байдлаар тодорхойлоод байна [6]. Үүнд:

Эдийн засаг, үйлдвэрлэл, бизнесийн хүрээ. Их хэмжээний мэдээллийн бааз, эх сурвалжид хандах боломжтой, банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүй, даатгал, удирдлага, зөвлөгөө өгөх болон аудитын үйлчилгээ, хэмжил

зүй, эрүүл мэндийн салбаруудад шийдвэр гаргалтын чанар эрс дээшилж, түргэн шуурхай, далайцтай үйл ажиллагаа явуулах бололцоо бүрдэнэ. Энэ хүрээнд Клаус Шваб дараах үндсэн дөрвөн үр нөлөөг тодорхойлжээ.

- Захиалагчийн өсөн нэмэгдэх хүлээлт;
- Бүтээгдэхүүний чанарын дээшлэлт;
- Хамтын инноваци;
- Зохион байгуулалтын шинэ хэлбэрийн үүсэл.

Компаниудын тухайд олон хүнийг өвөрмөц хэлбэрээр нэгтгэх талбар (*платформ*) үүсгэж чадсан байгууллага илүү давуу талтай болох аж. “Uber” компани өөрийн такси парк байхгүй, “Facebook” өөрийн контент бүтээдэггүй, дэлхийн хамгийн том онлайн-дэлгүүр болох “Alibaba” өөрийн бараа, бүтээгдэхүүнгүй зэргийг жишээ болгон дурдаж болно.

Экологи, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, эдийн засгийн нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн “*дахин ашиглалтын эдийн засаг*” (Circular economy)-ийн цоо шинэ хандлага бий болоод байна.

Ажиллах хүч, ажил хөдөлмөр эрхлэлт. Хэдийгээр үйлдвэрлэлийн процесс, үйл ажиллагааны бүрэн автоматжилтын дүнд хүмүүс хүнд хүчир, нэгэн хэвийн хөдөлмөрөөс ангижрах боловч, үйлдвэрлэлээс тусгаарлагдаж, хамааралгүй болсноор ажлын байраа алдах эрсдэлтэй тулгарна. Түүнчлэн технологийн хөгжил нь капитал эзэмшиж болон хөдөлмөрлөж олох орлогын хоорондын зөрүүг эрс нэмэгдүүлж, нийгмийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж болзошгүй. Боловсрол, ур чадварын түвшин доогуур ажиллагчдын эрэлт хэрэгцээ эрс багасна. Иймээс мэргэжилтнүүдийн зүгээс улс орнууд энэхүү шинэ хувьсгалд бэлтгэлтэй байх талаар анхаарах талаар зөвлөж байгаа ба ялангуяа хөдөлмөрийн хөлсний түвшин доогуур улс орнууд өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад энэхүү давуу талаа алдаж болзошгүйг анхааруулж байна. Ажиллагчдаас мэдлэг, ур чадвар бага шаарддаг, өдөр тутмын, нэгэн хэвийн ажил, үүргийг машин гүйцэтгэх болсноор олон тооны ажлын байр үгүй болох боловч хүмүүс бүтээлч ажил, үүрэгт голлон төвлөрөх, илүү хөгжиж өргөн боломж нээгдэх ажээ.

Хувь хүний хөгжил, нөлөөлөл. Тоон технологийн энэхүү шинэ эрин үе нь бие хүнийг ихээхэн өөрчлөх бөгөөд ёс зүйн болоод гоо зүйн цоо шинэ зарчим бий болно гэж үзэж байна. Хувь хүн нь бараа таваар, үйлчилгээг өөрийн хүссэнээр өөртөө тохируулж, зөвхөн тухайн хүнд таалагддаг орчныхоо “*үргэлжлэл*”-ийг бий болгох боломж бүрдэнэ. Гэсэн хэдий ч хүн тоон орчинд автах тусам өөрийн дотоод ертөнц, мөн чанараасаа алслагдаж, туйлшрал бий болох хандлагатай хэмээн үзэж байна. Төрийн мэдэлд байгаагаас ч илүү хэмжээний хөнөөлт зэвсэг ард иргэдийн гарт төвлөрч болзошгүй хэмээн дэлхийн эдийн засгийн форумын дарга сэрэмжлүүлсэн байна. Түүнээс гадна дунд ангийн нөхцөл байдал дордож, улс төрийн тогтолцооны тэнцвэрт байдал алдагдан, популизм, радикализм, фундаментализм болон милитаризм зэрэг сөрөг үзэл санаа түгэх эрсдэл бий

болж, глобаль түвшний тодорхойгүй байдал улам бүр нэмэгдэнэ гэжээ.

Нийгмийн хувьсал. Үйлдвэрлэлийн автоматжилт, робот технологи нэвтэрснээр 2020 он гэхэд 5.1 сая хүн, нэн түрүүнд захиргааны ажилтнууд ажилгүй болох магадлалтай гэжээ. Гэхдээ хоёр сая инженер-техник, компьютерийн болон санхүүгийн ажилтнуудын хэрэгцээ бий болохоор байгаа аж. Иймээс улс орнуудын хувьд цаг алдалгүй боловсролын болон мэргэжилтэн бэлтгэх сургалтын тогтолцоо, дэд бүтцээ өөрчлөн шинэчлэх, баялгийн шударга хуваарилалтыг дэмжихэд татварын механизм, эрх зүйн зохицуулалтаа чиглүүлэх хэрэгтэй байгааг цохон заажээ.

Бодит байдал дижитал ертөнцтэй улам бүр нягт уялдах тусам интернэтийн сүлжээний тусламжтайгаар хүсэшгүй үйл явцыг хянах, өөрчлөх илүү өргөн боломж бүрдэх ба шинэ технологийн үрээр иргэд улс төрийн амьдрал нөлөөлөх бололцоо бий болно. Гэвч аюулгүй байдлын асуудал илүү хурцадмал шинжтэй болж, ирээдүйд гарч болзошгүй дайн байлдаан огт өөр шинж байдалтай, зөрчил мөргөлдөөн гибрид хэв маягтай, нарийн төвөгтэй, хил хязгаарыг тодорхойлох боломжгүй болох аж.

“Аж үйлдвэрийн интернэт”-ийн сүлжээ бий болсноор масс хэлбэрээр тодорхой хэрэглэгчид тохирсон, хувийн шинж чанар агуулсан “ухаалаг” бүтээгдэхүүнийг “ухаалаг” тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэж, нийлүүлэх боломж бүрдэнэ. Үйлдвэрлэл бүхэлдээ “ухаалаг” болж, хүмүүсийн шууд ороцоогүйгээр автоматаар тохируулга хийгддэг, тасралтгүй явагддаг, интернэтээр удирдагддаг болох ба үүний тулд бүх машиныг “нэг хэлээр ярьдаг” болгох, корпорациар хязгаарлагдахгүй байгууллагууд өөр хоорондоо нэгдэж, өргөн хүрээнд хамтран ажиллах хэрэгтэй болно хэмээн үзсэн байна.

Дээрхээс үзэхэд, дэлхийн дэг журам үндсэндээ өөрчлөгдөж, шинэ нөхцөл байдал төлөвшин тогтох хандлага илэрхий болжээ. Энэ нөхцөлд манай орны хувьд ирээдүйн хөгжлийн бодлого, стратегия эргэж харах, ул суурьтай, зөв оновчтой боловсруулж, хэрэгжүүлэх явдал нэн чухал байна. Ялангуяа үндэсний хөгжлийн бодлого, стратегийн хүрээнд мэдлэг, оюунд суурилан инновацийн чиг баримжаагаар хөгжих хандлагыг илүү чухалчлан авч үзэх шаардлагатай байна.

2. Монгол Улсын ирээдүйн хөгжлийн таамаглал

Монгол Улсын 2014 оны эдийн засгийн чуулганаар ашигт малтмалын нөөц, түүнээс олсон орлогыг үр өгөөжтэй, оновчтой ашиглаж, үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхэц болохуйцаар зарцуулах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар дан ганц уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн бүтцийг олон тулгууртай болгох асуудал ихээхэн хөндөгдөж, олон талын санаа бодол, шийдэл хэлэлцэгдсэн билээ.

Уг арга хэмжээний үеэр Дэлхийн эдийн засгийн чуулганы шинжээчдийн тусламжтайгаар боловсруулсан манай орны ирээдүйн хөгжлийн таамаглал болох “Монголын хөгжлийн хувилбарууд-2040”-ыг танилцуулсан юм (1-р хүснэгт) [7].

Хүснэгт 1

Монголын хөгжлийн хувилбарууд 2040

№	Хувилбар	Таамаглалын нөхцөл	Зураглал
1.	“Бүс нутгийн сэргэн мандалт”	“Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулахад ХЯЛБАР байна”.	Зүүн хойд Азид интеграцичлал идэвхжиж, эдийн засаг өснө. Энэ нь Монголд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ ашигтай борлуулж, эдийн засгаа төрөлжүүлэх боломж олгохоос гадна, экспортын орлогоо оновчтой ашиглаж, эдийн засгийн хэт халалт, нийгмийн тогтворгүй байдлаас сэргийлэх шаардлагыг бий болгоно.
		“Монгол улс уул уурхайгаас өөр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах, борлуулах ЧАДВАРТАЙ байна”	
2.	“Хятад ногоорох нь”	“Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулахад ХЭЦҮҮ байна”	БНХАУ-д хүрээлэн байгаа орчныг хамгаалах хүрээнд хувьсгалт өөрчлөлт гарснаар “тойрог эдийн засаг”-ийн хөгжлийн загвар орон болж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ. Ингэснээр Монголын уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт буурах боловч, “ногоон” бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх боломж бий болгоно.
		Монгол Улс уул уурхайгаас өөр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах, борлуулах ЧАДВАРТАЙ байна.	
3.	“Баялгийн хямрал”	“Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулахад ХЭЦҮҮ байна”	Бүс нутагт геополитикийн хямрал газар авч, байгалийн баялгийг улс төрийн явцуу сонирхлоор ашигласнаас үүдэн худалдааны нөхцөл байдал хүндэрнэ. Монгол Улс эрдэс баялгаа боловсруулан нийлүүлэх зах зээл, санхүүгийн эх үүсвэр олох боломж хумигдах боловч бус нутгийн бусад орны хүндэтгэлийг хүлээсэн, төвийг сахисан байр суурьтай сайн хөрш болох боломжтой.
		“Монгол Улс уул уурхайгаас өөр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах, борлуулах ЧАДВАРГҮЙ байна”	

Эх сурвалж: Монголын хөгжлийн хувилбарууд / Дэлхийн орнуудын хөгжлийн зураглал-цуврал. Дэлхийн эдийн засгийн форум. 2014, - 42 х.

Дээрх дурдсан таамаглалыг Монгол Улсын ирээдүйн хөгжлийн бодлого, стратегид харгалзаж, хөгжлийн зорилт, хүрэх үр дүнгээ нарийвчлан тогтоож, үндэстэй томъёолох шаардлагатай. Нөгөө талаар, өөрийн орны хөгжлийн ирээдүйн хандлага, таамаглалыг бид өөрсдөө ул суурьтай боловсруулах тал дээр анхаарах цаг болжээ.

Өнөөдөр манай оронд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль тогтоомж гарснаар улс орны хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтын механизм харьцангуй сайжраад байгааг дурьдах нь зүйтэй [8]. Гэвч батлагдсан бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр дүн төдийлөн хангалттай биш байна. Энд улс төрийн

хүчин зүйлийн нөлөө их байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй юм. Бодлого боловсруулагчид, эрх баригч улс төрийн хүчнүүд улс орны алс ирээдүйн хөгжлийг хангах урт хугацааны бодлого, стратеги боловсруулж, хэрэгжүүлэхийг эрмэлзэхийн оронд сонгуулийн жилээр баримжаалсан богино хугацаанд үр дүн нь гарах асуудалд голлон анхаарч ирсэн нь төрийн бодлого, үйл ажиллагааг алсын хараагүй болгож байна. Түүнчлэн үндэсний хөгжлийн бодлого, хүрэх үр дүнгийн талаар нийтэд мэдээлж, улс нийтээрээ юунд зорьж байгааг сайтар ойлгуулах (*Монгол Улс хэдэн онд хөгжлийн ямар түвшинд хүрсэн байх, ямар улс болсон байх г.м.*), бодлого боловсруулахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, залгамж холбоог хангах, хэрэгжилтийн үр дүнг гаргаж, үнэлэлт дүгнэлт өгч, хяналт, мониторингийг ул үндэстэй хийж байх тал дээр анхаарах шаардлагатай байна.

3. Монгол Улсын хөгжлийн бодлогын шинэ чиглэл: Мэддэгийн эдийн засаг, инновацийн чиг баримжаа

Өнөөдөр манай орны хувьд дэлхийн эдийн засгийн интеграцчилалд хэрхэн үр дүнтэй оролцох, үндэсний өрсөлдөх чадвараа ямар арга замаар нэмэгдүүлэх тал дээр ул үндэстэй ажиллаж шаардлага урьд өмнөхөөс илүүтэй тулгарч байна.

Энэ нь манай орны цаашдын хөгжлийн чиг баримжааг тодорхойлох сонголттой шууд холбоотой юм. Тодруулбал, Монгол Улсын өмнө дэлхийн мэдлэгийн эдийн засгийн бүрэн эрхт гишүүн болж хөгжих, эсвэл түүхий эд бэлтгэлийн бааз хэвээр үлдэх хоёр зам байна. Эдийн засгийн онол, практикт түгээмэл хэрэглэж буй хандлагаар авч үзвэл, манай орон түүхий эдийн үе шатандаа оршиж байгаа нөөцийн эдийн засагтай орон юм. Цаашид хөрөнгө оруулалтын болон инновацийн үе шатаар дамжин хөгжилд хүрнэ. Энэ нөхцөлд улс орны хөгжлийг эрчимжүүлэх гол арга зам нь инновацийн буюу мэдлэгийн эдийн засгийн үндэс суурийг бий болгохтой шууд холбоотой бөгөөд үүнийг Үндэсний инновацийн тогтолцоо (ҮИТ) бүрдүүлж хөгжүүлэх замаар шийдвэрлэж ирсэн туршлага дэлхий дахинд түгээмэл байна [5].

Монгол Улсын хөгжлийн стратегийн шинэ хандлага нь үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх замаар улс орны өрсөлдөх давуу талыг бэхжүүлж, байгалийн нөөц баялгийг оновчтой зүй зохистой ашиглаж түүхий эдийн үе шатаас хөрөнгө оруулалтын үе шатад шилжиж, улмаар мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэхүү хандлагыг хэрэгжүүлэхэд улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн парадигмыг шинээр авч үзэх шаардлагатай гэж үзэж байгаа болно.

Учир нь манай орон бол байгалийн арвин баялаг нөөцтөй, геополитикийн хувьд стратегийн чухал ач холбогдол бүхий газар зүйн байршилтай, шинэчлэлд нээлттэй оюун санааны чиг баримтлал бүхий харьцангуй залуу хүн амтай, евроазийн шинж төрхтэй соёлын өв уламжлалтай, нээлттэй жижиг эдийн засагтай орон юм. Нээлттэй жижиг эдийн засаг нь зах зээлийн багтаамж багатай, нийгэм-эдийн засгийн янз бүрийн хүчин зүйлийн нөлөөнд автамтгай, дэлхийн эдийн засагт нөлөө үзүүлэх чадавхи сул, олон улсын хөдөлмөрийн хуваарьт

хамрагдах оролцоо багатай гэх мэт сул талтай боловч, динамик шинжтэй, маневрлах чадвар сайн, инерци багатай тул богино хугацаанд хөл дээрээ босч хөгжих илүүтэй өргөн боломжтой зэрэг давуу талтай гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, жижиг эдийн засгийг жижиг бизнестэй зүйрлүүлж болно. Эндээс жижиг эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн нийгэмлэгт жижиг дунд бизнесийн үүрэг гүйцэтгэж болно гэсэн санааг дэвшүүлж байгаа юм. Манай орны хувьд хөгжлийн бодлого, үйл ажиллагааныхаа хүрээнд жижиг эдийн засгийн сул талыг голчлон харгалзаж ирсэн талтай билээ.

Иймээс манай үндэсний хөгжлийн шинэ парадигмыг **“Эдийн засгийн нөөцийг үр өгөөжтэй ашиглах, үндэсний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх хурдасгуур болгохуйц Үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх замаар инновацийн, динамик, жижиг эдийн засгийг хөгжүүлэх явдал мөн”** хэмээн томъёолж болно.

Дээрх парадигм нь манай орны инновацийн чиг баримжаатай хөгжлийн бодлогын гол үндэслэл болох ба үүнийг хэрэгжүүлэх гол механизм нь ҮИТ байх боломжтой гэж үзэж байна. Монгол Улсад ҮИТ бүрдүүлж хөгжүүлэхдээ олон улсын ололт, туршлагыг харгалзахын зэрэгцээ өөрийн орны нөхцөл байдалд тулгуурласан өвөрмөц загвар боловсруулах шаардлагатай байна. Учир нь дэлхий нийтийн туршлагаас үзэхэд улс орны нийгэм-эдийн засгийн болон соёл иргэншлийн өвөрмөц онцлог, нөхцөл байдал нь ҮИТ-ний архитектурыг тодорхойлдог болох нь харагдаж байгаа юм. Зохиогчийн үзэж байгаагаар Монгол Улсын инновацийн хөгжлийн загвар нь ҮИТ-оор дамжуулан хөгжлийн таатай орчин бүрдүүлэх замаар эдийн засагт кластерийн үр нөлөөг бий болгох санаанд үндэслэж байгаа болно.

Олонх постсоциалист орны адилаар манай орны хувьд эдийн засгийн бодлого боловсруулж хэрэгжүүлж ирсэн уламжлал нь эдийн засгийг зохицуулах зах зээлийн бус захиргааны механизмыг бий болгосон билээ. Энэ бодит байдлыг харгалзан үзэж, ҮИТ-г төрийн эдийн засгийн хөгжлийн болон инновацийн бодлого хэрэгжүүлэх механизм, улс орны хөгжлийг эрчимжүүлэх, хоцрогдлыг даван туулах үндэсний аюулгүй байдлыг хангах систем хэмээн үзэж бүрдүүлж хөгжүүлэх нь илүү оновчтой байх талтай юм. Нөгөө талаар, уг тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх эхний үе шатанд төрийн үүрэг оролцоо өндөр байдгийг дэлхий дахины туршлага харуулж байгаа юм.

Дээрхийг тодруулбал, ҮИТ-г улс орны эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хурдасгуур (*катализатор*)-ийн үүрэг гүйцэтгэх үндэсний эдийн засгийн тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг төрийн хувьд түүний эдийн засгийн хөгжил, ШУТ-ийн болон инновацийн бодлогыг хэрэгжүүлэх механизм хэмээн үзэж бүрдүүлж хөгжүүлэх нь манай орны хувьд илүү оновчтой юм. Манай орны хөгжил нөөцийн эдийн засгийн түвшинд байгаа нь ҮИТ-г бүрдүүлж хөгжүүлэх суурь нөхцөл бэлэн байдлыг хангалтгүй гэж үзэхэд хүргэж байгаа боловч хөгжлийн хоцрогдлыг богино хугацаанд даван туулахын тулд уг тогтолцоог цаг алдалгүй хөгжүүлэх шаардлагатай.

ҮИТ бүрдүүлж хөгжүүлэхэд төрийн гүйцэтгэх үүрэг, оролцоо дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

Нэгд, төрийн байгууллага, институцийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах интеграцийг хангах;

Хоёрт, эдгээр субъектын зохистой нэгдэл болон нийгмийн төрөл бүрийн салбарын бодлогын хэрэгжилтыг хангах;

Гуравт, улс орны хөгжлийн нийгэм-эдийн засгийн зорилго, зорилт, түүнд хүрэх бодлого, стратегийн харилцан уялдаа, нэгдмэл байдлыг хангах;

ҮИТ бүрдүүлж хөгжүүлэхийн тулд төрийн зүгээс инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тогтолцооны субъект хоорондын харилцааг зохицуулах, тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, ялангуяа оюуны өмчийн эрхийн хамгааллын хэрэгжүүлэх боломж олгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай. Одоогийн мөрдөж байгаа хууль эрх зүйн баримт бичигт шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэгт шинжлэх ухаан–боловсрол–бизнесийн хүрээн дэх хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлийг тодорхой тусгах; шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн, бизнес эрхлэгчдийн зүгээс гаргаж байгаа үүсгэл санаачлагыг аль болох дэмжих, идэвхжүүлэх оновчтой арга механизмыг хэрэгжүүлэх; орлогын болон гаалийн татварын хуульд инновацийг хөгжүүлэх чиглэлээр явуулж байгаа байгууллагын үйл ажиллагааг дэмжихүйц заалт оруулах, тодруулбал, шинжлэх ухааны судалгаа, туршилтын хүрээнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаас олсон орлогыг албан татвараар чөлөөлөх, хөнгөлөх; гадаад хамтын ажиллагаа, олон улсын байгууллагын шугамаар нийлүүлэгдэж байгаа шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, туршилтын сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гаалийн татвар ноогдуулахгүй байх; бизнесийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжээс их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын ШУТ-ын инкубацийн үйл ажиллагаанд зориулан гаргасан зардлыг татвар ногдуулах орлогоос чөлөөлөх; аж ахуйн нэгж, байгууллагаас шинжлэх ухаан, технологийн инкубацийг хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, хандив, тусламжийг татвараас чөлөөлөх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн 2012 онд батлагдсан Инновацийн тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг нэн даруй боловсруулж, батлан мөрдөх хэрэгтэй байна [9]. Инновацийн талаар төрөөс баримтлах бодлого 2018 онд батлагдсан нь сайшаалтай [10].

Иймд дээр дурдсан зүйлсийг хэрэгжүүлэх стратегийн чиглэлийг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

1 үе шат (2018-2020 он). Нөөцөд тулгуурлан мэдлэгийн эдийн засгийн үндэс суурийг тавих: Энэ үе шатанд инновацийн эдийн засаг болон ҮИТ-ны үндэс суурь тавигдана. Стратегийн гол чиглэл нь:

- Инновацийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

- Инновацийн үйл ажиллагааны болон дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх механизм бүрдүүлэх;
- Инновацийн хүний нөөцийг бэлтгэх;
- Үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийх;
- Шинжлэх ухааны салбарын техникийн бааз суурийг сайжруулах, бэхжүүлэх;
- Боловсрол, ялангуяа дээд боловсролын чанарыг дээшлүүлэх.

II үе шат (2020-2025 он). Хөрөнгө оруулалтанд тулгуурлан мэдлэгийн эдийн засгийн хөгжлийг хангах: Энэ үе шатанд инновацийн эдийн засаг болон ҮИТ-ны үндэс суурийг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх үйл ажиллагаа голчлон хэрэгжинэ. Стратегийн үндсэн чиглэл нь:

- Инновацийн хөгжилд дэмжлэг үзүүлж чадах санхүү, эдийн засгийн механизм бүрдүүлэх;
- Инновацийн үйл ажиллагааны болон дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх механизмыг бүрэн бүрдүүлэх;
- ШУТП, кластер, технополис болон инновацийн ЖДҮ-ийн сүлжээ байгуулах;
- ШУТ-ийн үр ашигтай салбарыг бий болгох;
- Шинжлэх ухааны багтаамж өндөртэй салбар, өрсөлдөх чадвартай боловсруулах үйлдвэр бүхий аж үйлдвэрийн комплекс бий болгох;
- Инновацийн хөгжлийн шаардлагад нийцсэн дээд боловсролын хөгжингүй тогтолцоо бүрдүүлэх;
- Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад сурч ажиллаж байгаа өндөр мэдлэг чадвартай монгол залуус, мэргэжилтнүүдийг татах замаар инновацийн субъектүүдийг инновацийн хүний нөөцөөр хангах;

III үе шат (2025-2030 он). Мэдлэгт тулгуурласан инновацийн эдийн засгийг хөгжүүлэх үндсийг бүрдүүлэх:

Энэ үе шатны стратеги нь үндсэндээ ҮИТ-г байгуулж дуусгахад чиглэгдэх ба Монгол Улсад мэдлэгийн эдийн засаг жинхэнэ утгаараа хөгжих баттай үндэс бүрдэнэ. Стратегийн үндсэн чиглэлд:

- Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хүчирхэг хурдасгуур болж чадах үр ашигтай ҮИТ-г бүрэн байгуулах;
- ШУТП, кластер, технополис болон инновацийн ЖДҮ-ийн сүлжээг эрчимтэй хөгжүүлэх;
- Хөрөнгийн хөгжингүй зах зээл, венч болон эрсдэлийн хөрөнгө оруулалт, лизинг зэрэг санхүүгийн бусад дэвшилтэт хэлбэр бүхий үр ашигтай санхүү, эдийн засгийн механизм бий болгох;
- ШУТ-ийн үр ашигтай салбарыг эрчимтэй хөгжүүлэх;
- Шинжлэх ухааны багтаамж өндөртэй салбар, өрсөлдөх чадвартай

боловсруулах үйлдвэр бүхий аж үйлдвэрийн комплексийг бүрэн байгуулах;

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий дээд боловсролын хөгжингүй тогтолцоо бий болгох;
- Инновацийн хүний хүчний хангалттай нөөц бий болгох;
- Инновацийн соёлыг өндөр түвшинд хүргэх таатай орчин бүрдүүлэх
- зэргийг хамруулж болно.

Эдгээрийг санал болгохдоо Монгол Улсын ШУТ, инновацийн чадавхийн судалгаанд үндэслэсэн боловч цаашид тооцоо судалгааг нарийвчлан гаргах, бодлого, арга хэмжээг илүү тодорхой болгох шаардлагатай юм.

4. Дүгнэлт

1. XXI зуунд улс орнуудын эдийн засгийн өсөлтөнд ШУТД болон эдийн засаг, аж үйлдвэрийн голлох салбаруудын оюунжилт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь улам тодорхой боллоо. Үүнтэй холбоотой боловсрол нь улс орнуудын эдийн засаг, соёлын хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох амин чухал салбарын нэг болон хувирч байна. Өнөөдөр олон улс орны хувьд инновацийн үйл ажиллагааны үр дүн эдийн засгийн өсөлтөнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна. Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн глобаль өрсөлдөөнд инновацийн хөгжлийн тааламжтай орчин бүрдүүлж чадсан улс орон хожих нь улам бүр тодорхой болжээ.

2. Дэлхийн дэг журам үндсэндээ өөрчлөгдөн, шинэ нөхцөл байдал төлөвшин тогтох хандлага илэрхий болж байгаа өнөөгийн нөхцөлд манай орны хувьд ирээдүйн хөгжлийн бодлого, стратегиа эргэж харах, ул суурьтай, зөв оновчтой боловсруулж, хэрэгжүүлэх явдал нэн чухал байна. Ялангуяа үндэсний хөгжлийн бодлого, стратегийн хүрээнд мэдлэг, оюунд суурилан инновацийн чиг баримжаагаар хөгжих хандлагыг илүү чухалчлан авч үзэх шаардлагатай байна.

3. Монгол Улсын хөгжлийн бодлого, стратегийн хүрээнд алс ирээдүйг харсан, томоохон зорилго дэвшүүлж, түүнд хүрэхийн төлөө улс нийгмээрээ чармайн хөдөлмөрлөх шаардлагатай байна. Энэ нь “Хөгжингүй Монгол Улсыг бүтээн байгуулах явдал” мөн. Харин одоо, энэхүү хөгжингүй Монгол орны дүр төрхийн бодит төсөөллийг бий болгож, нийгэмд таниулах, Монголын ард түмнийг бүтээн байгуулалтад уриалан дуудах, идэвхжүүлэн чиглүүлэх, эрмэлзэн зорих жанжин шугам болгох хэрэгтэй байна. Улс төрийн нам, хүчнүүд Монгол Улсыг түүхэн богино хугацаанд ХӨГЖИНГҮЙ ОРОН болгоход чиглэсэн мөрийн хөтөлбөрөөр өрсөлдөж, энэ зорилгыг хэрэгжүүлэх чиглэлд юу хийсэн, ямар үр дүнд хүрснээр үнэлэгддэг байвал зохилтой.

Ном зүй:

- [1] Павлючук Ю.Н., Козлов А.А. (2001). *Инновационные аспекты глобализации как актуальной проблемы мирового экономического развития* // Инновации.
- [2] Негутарова А. Кабанец М. (2013). *Современные тенденции развития мирового хозяйства*.
URL: http://www.rusnauka.com/15_NPN_2013/Economics/
- [3] *Global Trends 2030: Alternative Worlds*, (2012). National Intelligence Council, USA, December 10, URL: <http://www.dni.gov/nic/globaltrends/>
- [4] Оюунцэцэг Л. (2009). “Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол-арга зүйн үндэс (Монгол улсын жишээн дээр)”, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (D.Sc.)-ын дисс. ОХУ, Г. В. Плехановын Эдийн засгийн академи, Монгол улсын ШУА, ШУТИС, КтМС, 2009, -264 х.
- [5] Оюунцэцэг Л. (2018). *Аж үйлдвэрийн IV хувьсгал: онцлог, чиг хандлага, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө*, Шинжлэх ухаан, технологи, сэтгүүл, ШУТИС, №3
- [6] Клаус Шваб (2016). *Четвертая промышленная революция*, ВЭФ, “Эксмо”, - 138 с.
- [7] *Монголын хөгжлийн хувилбарууд* (2014). Дэлхийн орнуудын хөгжлийн зураглал-цуврал. Дэлхийн эдийн засгийн форум. 2014, - 42 х.
- [8] *Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль*, УИХ, 2015. 11.26
- [9] *Инновацийн тухай хууль*, УИХ, 2012.05.44
- [10] *Инновацийн талаар төрөөс баримтлах бодлого*. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоол, 2018.08.01.

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018

МОНГОЛ УЛСЫН ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

Б.Батзаяа¹

<i>JEL ангилал:</i>	<i>Хураангуй:</i>
O13, C61	Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын эдийн засгийн 1991-2017 оны өсөлт, түүнд эрчим хүчний салбарын эзлэх хувь хэмжээг харуулснаас гадна Эрчим хүчний зах зээлийн бүтцийг судлах, өнөө үед гадаад орны цахилгаан эрчим хүчний зах зээлийн үйл ажиллагаа, шинэчлэлийг судалсны үндсэн дээр Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн системийн Нэг худалдан авагчтай загварт тохирох цахилгаан эрчим хүчний бүтээгдэхүүний тогтолцоог санал болгож, энэ тогтолцооны үеийн системийн эдийн засгийн үр ашгийг тодорхойллоо.
<i>Түлхүүр үг:</i>	
Цахилгаан эрчим хүчний зах зээл, оновчлол, бүтээгдэхүүний тогтолцоо, үр ашиг	

1. Оршил

Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар мөн.

Манай орны хувьд өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээ (ЦЭХ)-г дотоодын эх үүсвэрээс хангаж чадахгүй, оргил ачааллын үед ОХУ, БНХАУ-аас импортоор худалдан авч байгаа нь тус салбарын бие даасан байдал, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Импортын цахилгаан эрчим хүчээр дотоод хэрэгцээгээ хангах боломж нь тухайн орны эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдаатайгаар эрчим хүчний системээ үр ашигтай ашиглах үндэсний хүний нөөцийн чадавхи, нийт хүн амын боловсрол, соёлын байдлаас хамаарч тодорхойлогдох учиртай билээ [1].

Өнөөдөр ихэнхи улс орны цахилгаан эрчим хүчний салбар зах зээлийн хэлбэрт шилжин өөрийн онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтцийг ашиглаж байгаа боловч шинэчлэл үргэлжилсээр байна. Эдгээр шинэчлэл нь цахилгаан эрчим хүчний зах зээлийн арга хэрэгслийг сайжруулж, зохицуулалтыг эдийн засгийн хувьд үр ашигтай болгоход чиглэж байна.

Цахилгаан эрчим хүчний зах зээл дээр олон төрлийн бүтээгдэхүүн (*чадал, энерги, хоёр талт гэрээ гэх мэт*) худалдаалж байгаа нь системийн хувьд үр ашиг буурч байдаг. Иймээс бусад орны цахилгаан эрчим хүчний зах зээлийн бүтцэд судалгаа хийж, өөрийн орны онцлогт тохирсон үр ашигтай бүтээгдэхүүний тогтолцоог бий болгох шаардлагатай юм.

¹ ОХУ-ын Эрхүү хотын Байгалын улсын их сургуулийн аспирант, z_zaya12@yahoo.com

Монгол Улсын хувьд “Нэг худалдан авагч”- тай загварыг ашиглан спот, аукцион зах зээл болон хоёр талт гэрээгээр цахилгаан эрчим хүчийг арилжаалдаг ба нэг худалдан авагчийн үүргийг Диспетчерийн үндэсний төв (ДҮТ) гүйцэтгэж байна [2].

Иймээс эрчим хүчний системийн үр ашигтай байдлыг хангахын тулд Нэг худалдан авагчтай загварт тохирсон бүтээгдэхүүний тогтолцоог санал болгож, үр ашгийг тодорхойлох болно.


2. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих их шилжилтийн өмнө буюу 1990 онд Монгол Улсын аж үйлдвэрийн салбар нь ДНБ-ий гуравны нэгийг бүрдүүлээд зогсохгүй ажлын байр бий болгогч томоохон салбар байсан. Харин зах зээлд шилжих шилжилт, үйлдвэржилтийн хямралын он жилүүдэд нийт эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 19.3 хувь (1999 он) болтлоо буураад байсан юм. Үүнд боловсруулах үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нэр төрөл ихээхэн цөөрч, технологийн хувьд нэлээд хоцрогдсон төдийгүй, хими, металл боловсруулалт, эрчим хүчний салбарын үйл ажиллагаа хумигдсан нь голлон нөлөөлжээ. Харин 2004 оноос Монгол Улс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нээлттэй болгосноор уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар эрчимтэй хөгжиж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор манай орны аж үйлдвэрийн салбарын бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан юм. 1990 онд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 71.8 хувийг боловсруулах үйлдвэр, 16.1 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр бүрдүүлж байсан бол 2005 онд эсрэгээрээ 66.3 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр, 21.0 хувийг боловсруулах үйлдвэрийн салбар бүрдүүлэх болсон байна. 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн 66.9 хувийг уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар бүрдүүлснээс үзэхэд, манай орны аж үйлдвэрийн салбар нь уул уурхайн түүхий эдэд тулгуурлах болсон байна. Аж үйлдвэрийн салбарын экспортын хувьд Монгол Улс нь байгалийн нөөцөөр баялаг, хөгжиж буй бусад улс орнуудын адил мөн л цөөн тооны, нэмүү өртөг багатай уул уурхайн түүхий эдэд суурилж байна.

Манай орны хувьд 1991-2017 онд жилийн дундаж өсөлт 4.4 хувь байна. Харин жил бүрийн өсөлтийн арифметик дундаж нь 4.6 хувь, геометр дундаж нь 4.9 хувь, жил бүрийн өсөлтийн стандарт алдаа нь харьцангуй өндөр буюу 6.1 хувь байна (Зураг 1). Эдийн засгийн өсөлт хэт өндөр хэлбэлзэлтэй, гадаад цочролоос хэт их хамааралтай байна. Эдийн засгийн өсөлтийн өндөр хэлбэлзэл нь өрхийн хэрэглээний өсөлт, бууралтыг савлуулж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг тогтвортой бууруулах зэрэг нийгмийн зорилтыг хангах боломжийг хязгаарлаж байна. Эдийн засгийн өсөлтийг тогтвортой, хүртээмжтэй болгох асуудал нь гадаад цочролоос дархлаатай болгох, эдийн засгийн бүтцийг ажлын байр олноор бий болгодог олон тулгууртай болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх явдал юм.

Зураг 1

Монгол Улсын эдийн засгийн өсөлт
(хувиар)



Эх сурвалж: YCX

3. Эрчим хүчний салбар

Цахилгаан эрчим хүчний нийт нөөц өссөөр 2017 онд 7601,7 сая кВт.ц болж өмнөх онтой харьцуулахад 6,9 хувиар, 2010 оноос 66,1 хувиар, 1990 оноос 112,6 хувиар нэмэгдсэн байна. 2017 онд цахилгаан эрчим хүчний нийт нөөцийн 79.3 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 20.7 хувийг БНХАУ, ОХУ-аас импортоор авч хэрэглэсэн бөгөөд дотооддоо үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч 6.4 хувиар, 2010 оноос 39,8 хувиар, 1990 оноос 80,0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2017 оны цахилгаан эрчим хүчний нийт нөөцийн 78,3 хувийг өрх, ААНБ-ууд хэрэглэсэн бол 10,7 хувийг түгээлтийн болон шугамын алдагдал, 10,7 хувийг цахилгаан станцуудын дотоод хэрэглээ, 0,3 хувийг экспорт эзэлж байна. 2017 онд хэрэглэсэн нийт цахилгаан эрчим хүч өмнөх оноос 9,2 хувиар, цахилгаан станцын дотоодын хэрэглээ 9,0 хувиар нэмэгдсэн бол түгээлтийн болон шугамын алдагдал 0.8 хувиар, экспорт 28.8 хувиар буурсан байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтцийг салбараар авч үзвэл, 2017 онд нийт цахилгаан эрчим хүчний 62.1 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 24.0 хувийг өрх, орон сууц, нийтийн аж ахуй, 4.2 хувийг тээвэр, холбооны салбар, 1.1 хувийг хөдөө аж ахуйн салбар, үлдсэн 8.7 хувийг бусад салбар хэрэглэсэн байна. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтцэд сүүлийн 10 жилд бараг өөрчлөлт ороогүй байгааг хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт 1

Цахилгаан эрчим хүчний тэнцэл
(сая кВт.ц, 1995-2017он)

Үзүүлэлт	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017*	Өсөлт, бууралт, %		
									2017/ 1990	2017/ 2010	2017/ 2016
Нөөц-Бүгд	3576,0	3009,0	3127,0	3586,4	4575,7	6930,0	7113,6	7601,7	112,6	66,1	6,9
Үйлдвэрлэсэн	3348,0	2628,0	2946,0	3418,9	4312,8	5513,2	5667,1	6027,3	80,0	39,8	6,4
Импорт	228,0	381,0	181,0	167,5	262,9	1416,8	1446,3	1574,3	590,5	498,8	8,9
Импортын хувь	6,4	12,7	5,8	4,7	5,7	20,4	20,3	20,7	223,4	263,2	2,0
Хуваарилалт-Бүгд	3576,0	3009,0	3127,0	3586,4	4575,7	6895,0	7047,5	5948,7	66,4	30,0	-15,6
Хэрэглэсэн	2719,0	1909,0	1 10,0	2 34,0	3375,9	5283,5	5 445,7	5948,7	118,8	76,2	9,2
Аж үйлдвэр барилга	1803,0	1105,0	1182,0	1569,1	2093,8	3261,4	3356,3	3692,0	104,8	76,3	10,0
Тээвэр, холбоо	175,0	69,0	79,0	105,8	140,4	216,5	222,9	247,5	41,4	76,3	11,0
Хөдөө аж ахуй	116,0	59,0	21,0	27,5	35,6	54,8	56,6	62,8	-45,9	76,4	11,0
Орон сууц нийтийн аж ахуй	349,0	518,0	463,0	609,3	809,7	1277,5	1321,3	1426,6	308,8	76,2	8,0
Бусад	276,0	158,0	165,0	222,3	296,2	473,3	488,6	519,8	88,3	75,5	6,4
Түгээлтийн болон шугамын алдагдал	323	502	576	419,7	505,4	782,6	817,1	810,9	151,1	60,4	-0,8
Түгээлтийн болон шугамын алдагдал, %	9,0	16,7	18,4	11,7	11,0	11,3	11,5	10,7	18,1	-3,4	-7,1
Дотоод хэрэглээ	534,0	598,0	616,0	620,8	672,2	778,2	748,7	816,4	52,9	21,5	9,0
Дотоод хэрэглээ, %	14,9	19,9	19,7	17,3	14,7	11,2	10,5	10,7	-28,1	-26,9	2,0
Экспорт	0,0	0,0	25,0	11,9	22,2	50,8	36,0	25,7	0,0	15,8	-28,6
1 хүн амд ногдох үйлд-вэрлэсэн ЦЭХ,кВт.ц	1 63,8	1298,4	1307,0	1 41,9	1574,8	1860,0	1872,2	1945,8	16,9	23,6	3,9

Эх сурвалж: ҮСХ

Нэг хүнд ногдох нийт цахилгаан эрчим хүчний нөөцийн хувьд 2017 онд 2454,0 киловатт цаг байгаа бол нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэл 2017 онд 1945,8 киловатт цаг болж өмнөх онтой харьцуулахад 73,5 киловатт цаг буюу 3,9 хувиар, 2015 оноос 23,6 хувиар, 2008 оноос 16,9 хувиар нэмэгдсэн байна. Харин нэг хүнд ногдох импортоор авсан цахилгаан эрчим хүч 2017 онд 508.2 киловатт цаг болж, өмнөх оноос 30.4 киловатт цаг буюу 6.4 хувиар өсжээ.

Тус салбарт 2017 онд 1,3 их наяд төгрөгийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 0,1 их наяд төгрөг буюу 7,0 хувиар өсжээ. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд цахилгаан эрчим хүчний эзлэх хувь 2017 онд 6,2 хувь болж, өмнөх оноос 1,4 пунктээр, 2012 оноос 1,0 пунктээр буурч, 2008 оноос 0,5 пунктээр өссөн байна. Харин цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт цахилгаан эрчим хүчний эзлэх хувь 2017 онд 83,4 хувь болж, өмнөх оноос өөрчлөлтгүй, 2012 оноос 2,2 нэгжээр буурч, 2008 оноос 10,7 нэгжээр нэмэгдсэн байна. Цахилгаан эрчим хүчний 1 киловатт цагийн дундаж үнэ 2017 онд 146,3 төгрөг болж, өмнөх оноос 2,4 төгрөг буюу 1,7 хувиар, 2012 оноос 62,3 төгрөг буюу 74,2 хувиар өссөн байна (хүснэгт 2).

Хүснэгт 2

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл
(их наяд төгрөгөөр)

Салбар	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
АҮ-ийн нийт үйлдвэрлэл	3,5	3,6	6,5	8,8	9,8	10,4	14,4	14,8	15,7	20,7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0,3	0,3	0,6	0,7	0,8	0,9	0,8	1,0	1,4	1,5
Цахилгаан эрчим хүч	0,2	0,2	0,5	0,6	0,7	0,8	0,7	0,9	1,2	1,3
Цахилгаан эрчим хүчний 1 киловатт цагийн дундаж үнэ, - төгрөг	-	-	72,0	84,0	84,0	84,0	107,0	132,1	143,9	146,3
Дүнд эзлэх хувь: АҮ-ийн нийт үйлдвэрлэлд	5,7	6,1	7,5	6,5	7,2	7,9	4,7	5,8	7,6	6,2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт	72,7	70,3	76,8	83,6	85,6	91,2	80,0	81,5	83,4	83,4

Эх сурвалж: ҮСХ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харьцуулбал, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн хэмжээ нийт ДНБ-д цахилгаан эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, усан хангамж, урлаг, үзвэр тоглоом наадам зэрэг салбарт 30 хүртэл хувь, тээвэр, уул уурхай, олборлох болон мэргэжлийн, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны салбарт 30-80 хүртэл хувь, бусад салбарт 80-100 хувийг эзэлж байна. Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоо бага байгаа нь хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөл бага, өрсөлдөөнт зах зээлийн тоготлцоонд шилжээгүй зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Хүснэгт 3

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий салбарын бүтэц,
хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь
(эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар)

Салбар	Салбарын бүтэц							
	1991	1995	2000	2005	2010	2015	2016	2017*
ДНБ	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	12,5	32,5	27,4	19,8	11,6	13,3	11,5	10,6
Уул уурхай, олборлолт	12,5	11,3	11,3	21,0	22,4	17,6	20,7	22,6
Боловсруулах үйлдвэр	21,4	19,0	9,1	7,7	8,6	9,1	8,8	10,2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2,2	1,9	2,6	2,7	1,8	1,9	2,3	2,2
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	18,3	12,7	15,6	14,0	18,7	16,4	16,1	16,7
Барилга	5,7	2,0	2,6	3,0	2,9	4,7	4,3	4,0
	Хувийн хэвшил							
		2000	2005	2010	2015	2016	2017*	
ДНБ		72,2	73,7	73,4	80,0	79,1	78,7	
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт		...	100,0	100,0	100,0	100,0	100,0	
Уул уурхай, олборлолт		...	48,0	52,5	76,5	79,4	69,8	
Боловсруулах үйлдвэр		...	89,5	89,0	96,1	98,4	98,7	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		...	13,7	8,9	10,4	13,4	13,5	
Бөөний болон жижиглэнгийн худалдаа		...	99,8	100	99,9	99,9	99,9	
Барилга		...	83,2	92,1	98,3	97,4	97,5	

Эх сурвалж: ҮСХ

Эрчим хүчний үнэ тариф, эрхзүйн орчинг хөрөнгө оруулагчдад таатай байдлаар бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах, ашиглах зэрэг нь эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх угтвар нөхцөл нь болно. Одоогийн байгаа эх үүсвэрүүд, цахилгаан түгээх сүлжээнүүдийг хувьчлах асуудал нь салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх нөхцлийн нэг хэсэг нь болж байгаа юм. Түүнчлэн, хувийн хэвшлийн эх үүсвэрүүд бий болсноор салбар зах зээлийн харилцаанд бодит утгаараа шилжих, өрсөлдөөн үүсэх нөхцөл бас бүрдэх юм.

Монгол улсын эрчим хүчний систем таван бүсээс бүрддэг. Төвийн бүсийн нэгдсэн систем (ТБНС) нь дулааны цахилгаан станц, импортын цахилгаан эрчим хүчнээр нийслэл хот болон төвийн 13 аймгийг цахилгаан эрчим хүчээр хангах бөгөөд Эрчим хүчний салбарын нийт хэрэглээний 90 хувийг эзэлдэг.

ЦЭХ-ний хэрэглээ 2017 онд 5948,7 сая кВт.ц, оргил ачаалал 1016 МВт хүрсэн. 1990 онд ЦЭХ-ний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр 93,6 хувь хангаж байсан бол 2017 онд 79,3 хувь болж буурсан нь тус салбар төдийгүй Монгол улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл

4. Судалгааны үр дүн

ЦЭХ-ний салбарт зах зээлийн өөрчлөлт хийхээс өмнө тус салбарын компаниуд босоо бүтэцтэй байсан. Одоо ч гэсэн энэ бүтцийг амжилттайгаар ашиглан хөгжиж байгаа орнууд байгаа хэдий ч сул талууд ажиглагдсаар байна (Жишээлбэл нь Япон, АНУ-ын зарим бүс нутагт).

Зах зээлийн шинэчлэл нь улс орон бүрт ялгаатай цахилгаан эрчим хүчний зах зээлийн бүтцийг бий болгосон [3]. Жишээлбэл нь Скандинав, Баруун Европ, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнуудад зах зээл нь цахилгаан эрчим хүчний өрсөлдөөнт, олон бүтээгдэхүүний хэлбэрт шилжсэн. Ингэснээр үнийн сигнал нь эрчим хүчний салбарын хөгжлийг бий болгож үр ашгийг нэмэгдүүлнэ гэж үзсэн [4, 5]. Мөн Бразилд цахилгаан эрчим хүчний 1 бүтээгдэхүүнт зах зээл ажилладаг.

Харин ОХУ-ын хувьд инноваци, удирдлагын хөгжлийг хангах зорилгоор Эрхүүд 2015 оны 9-р сарын 3-наас спот зах зээлийн үнийн сигналийг аукционы механизмаар солисон нь эх үүсвэрүүд болон борлуулалтын компаниудын хооронд хоёр талт, урт хугацаа (15-30 жил)-ны гэрээг хийсэн. Ингэснээр эх үүсвэрийн чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг тогтворжуулах юм [6]. Чадлын зах зээл нь эх үүсвэрийн чадлын өсөлтийг хангах механизм болдог [3, 7]. АНУ болон ОХУ-д чадлын эрэлтийг зах зээлийн аргачлалаар зохицуулагч тогтооно. Өмнөд Америк, Испани, Англи зэрэг зарим оронд чадлын төлбөр нь эх үүсвэрийн чадлын хөрөнгө оруулалтын механизмыг тогтворжуулахад ашиглагддаг.

Нэг худалдан авагчтай загвар (НХАЗ)-ыг Монгол, Хятад болон зарим орнууд ашигладаг. БНСУ нь олон төрлийн бүтээгдэхүүн борлуулдаг НХАЗ-ыг ашигладаг.

Зах зээлийн босоо зохион байгуулалтын бүтцийн үйл ажиллагаа нь зах зээлд оролцогчдод хүндрэл учруулж ирсэн учир ОХУ болон зарим оронд тус бүтцийг цомхотгон тохирох хэлбэрээр нь ашиглаж байна [8, 9].

Цахилгаан эрчим хүчний зах зээлийн шилжилтийн үед зах зээлийн бүтэц, үр ашигтай бүтээгдэхүүний тогтолцооны судалгаа хийгдээгүй бөгөөд тус зах зээлийн лидер болох Англи улс ч өнөөг хүртэл тохирсон загварыг олоогүй байна.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээгээр тэргүүлэгч орнуудын нэг ОХУ-ийн Цахилгаан эрчим хүчний зах зээл нь хөгжлийн 4 дэх шатандаа явж байгаа бөгөөд энэ нь чадал энергийн бөөний зах зээл юм. ОХУ-д 2010 оны 12-р сарын 27-ний өдрийн шийдвэрээр чадал энергийн бөөний зах зээлийн дүрмийг баталсан.

Цахилгаан эрчим хүчний бүтээгдэхүүн гэдэг нь үйлдвэрлэлийн үр дүнд чадал, энерги бий болох бөгөөд олон улсад дараах хэлбэрээр хэрэглэдэг. Үүнд: хэмжих нэгж – энерги, чадал; хэрэглэх хэмжээ – хязгаарын нөхцөлтэй ($1-299 \text{ кВт}$, $300-399 \text{ кВт гэх мэт}$); цагийн хязгаар – өдөр, шөнө, оргил ачаалал гэх мэт; хэрэглэгчийн төрөл – айл өрх, аж ахуйн нэгж байгууллага; хүчдэлийн түвшин – өндөр, дунд, нам хүчдэл гэх мэт дээрх олон хэмжээс ашиглагддаг бөгөөд өөр хоорондоо хамааралгүй зах зээлийн сектороор, ялгаатай үнээр арилжаалагдаж байгаа нь цахилгаан эрчим хүчний зах зээлийн удирдлагыг төвөгтэй болгоод зогсохгүй системийн хувьд үр ашиг буурах үндсэн нөхцлийн нэг болж байна. Иймээс S системд цахилгаан эрчим хүчний бүтээгдэхүүний тогтолцоо, S_i өөр хоорондоо хамааралгүй олон тооны бүтээгдэхүүнээс бүрдэнэ [10]. Үүнд:

$$\sum_i^n z_{\text{оновч}}(S_i) > z_{\text{оновч}} \sum_i^n (S_i), \quad (1)$$

энд: $z_{\text{оновч}}(S_i)$ нийлбэр оновчтой зохион байгуулалттай секторуудын бүтээгдэхүүний зардал,

$z_{\text{оновч}} \sum_i^n (S_i)$ оновчтой зохион байгуулалттай бүтээгдэхүүний нийлбэр зардал.

Дээрх шинжүүрээс харахад оновчтой бүтэцтэй бүтээгдэхүүний тогтолцоог ашиглах нь эрчим хүчний системийн хувьд эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх нь харагдаж байна. Иймээс энергийн жилийн нийт хэрэглээг нийгмийн болон цаг агаарын хүчин зүйлээс хамааруулан жилийн дундаж хэрэглээ $P_{\text{дунд}}$ улирлын долоо хоногийн $\Delta P_{\text{дол.хон}}$, өдрийн ачаалалын өөрчлөлт $\Delta P_{\text{хон}}$ гэж хувааж болох юм. Эдгээр бүтээгдэхүүний тогтолцоог Монгол улсын нэг худалдан авагчтай загварт ашиглан, үр ашгийн хэмжээг тодорхойлж тус загварт тохирох дараах математик загварыг санал болгож байна.

5. Математик загварчлал

ТБНС-ийн жилийн хэрэглээ ($P_{\text{дунд}}$, $\Delta P_{\text{ул}}$, $\Delta P_{\text{дол.хон}}$, $\Delta P_{\text{хон}}$)-г хангахын тулд зах зээлийн нөхцөлд эх үүсвэрийн зардал хамгийн бага байх шинжүүрийг тавьж, эх үүсвэрийн ажиллах горимын тооцооны оновчлолын математик загварт шугаман програмчлалыг ашиглан эх үүсвэрүүдийн оновчтой параметрийн хэмжээ ($X_{\text{дунд}}$, $\Delta X_{\text{ул}}$, $\Delta X_{\text{дол.хон}}$, $\Delta X_{\text{хон}}$), тэдгээрийн үнэ ($C_{\text{дунд}}$, $\Delta C_{\text{ул}}$, $\Delta C_{\text{дол.хон}}$, $\Delta C_{\text{хон}}$)-ийг тооцохын тулд дараах зорилгын функцийг ашиглана.

5.1. Зорилгын функц

$$\sum_i X_{\text{дунд}} \cdot C_{\text{дунд}} + \sum_i \Delta X_{\text{ул}} \cdot C_{\text{ул}} + \sum_i \Delta X_{\text{дол.хон}} \cdot C_{\text{дол.хон}} + \sum_i \Delta X_{\text{хон}} \cdot C_{\text{хон}} \rightarrow \min, \quad (3)$$

Энд: $X_{\text{дунд}i}$ - ТБНС-ийн дундаж чадлын хэрэгцээг хаахад оролцож байгаа i -р эх үүсвэр;

$\Delta X_{\text{ул}i}$, $\Delta X_{\text{дол.хон}i}$, $\Delta X_{\text{хон}i}$ - ТБНС-ийн улирлын, долоо хоногийн, хоногийн чадлын хэрэгцээг хаахад оролцож байгаа i -р эх үүсвэр;

$C_{\text{дунд}i}$ - i -р эх үүсвэрийн дундаж чадлын нэгж зардал;

$\Delta C_{\text{ул}i}$, $\Delta C_{\text{дол.хон}i}$, $\Delta C_{\text{хон}i}$ - i -р эх үүсвэрийн улирлын, долоо хоногийн, хоногийн чадлын нэгж зардал.

5.2. Эрэлтийн хязгаарлалт:

$$\sum_i X_{\text{дунд}} \geq P_{\text{дунд}}, \quad (4)$$

$$\sum_i \Delta X_{\text{ул}} \geq P_{\text{ул}}, \quad (5)$$

$$\sum_i \Delta X_{\text{дол.хон}} \geq P_{\text{дол.хон}}, \quad (6)$$

$$\sum_i \Delta X_{\text{хон}} \geq P_{\text{хон}}, \quad (7)$$

$$\sum_i \Delta X_{\text{макс}} \geq P_{\text{макс}}. \quad (8)$$

5.3 Эх үүсвэрийн тоног төхөөрөмжийн хязгаарлалт:

$$X_{\text{дунд}i} - \Delta X_{\text{ул}i} - \Delta X_{\text{дол.хон}i} - \Delta X_{\text{хон}i} \geq N_{\text{зун.мин}i}, \quad (9)$$

$$X_{\text{дунд}i} + \Delta X_{\text{ул}i} + \Delta X_{\text{дол.хон}i} + \Delta X_{\text{хон}i} \leq N_{\text{бол}i}, \quad (10)$$

$$\begin{aligned} \sum_i X_{\text{дунд}} + \sum_i \Delta X_{\text{ул}} + \sum_i \Delta X_{\text{дол.хон}} + \sum_i \Delta X_{\text{хон}} &\geq \\ &\geq P_{\text{дунд}} + \Delta P_{\text{ул}} + \Delta P_{\text{дол.хон}} + \Delta P_{\text{хон}}. \end{aligned} \quad (11)$$

Үүнд: $N_{\text{зун.мини}}$ - i -р эх үүсвэрийн зуны хамгийн бага ачаалал

$N_{\text{бөлі}}$ – i -р эх үүсвэрийн боломжит чадал

Загварын хувьсагчид нь жилийн хэрэглээг хангах эх үүсвэрүүдийн жилийн дундаж чадал, улирлын, долоо хоногийн болон хоногийн өөрчлөлтүүдийн чадлын оролцоонууд ($P_{\text{дунд}}$, $\Delta P_{\text{ул}}$, $\Delta P_{\text{дол.хон}}$, $\Delta P_{\text{хон}}$) байна. Зорилгын функц (2) хүрээнд оновчлол хийснээр эх үүсвэр бүрийн хэмжээ ($X_{\text{дунд}}$, $\Delta X_{\text{ул}}$, $\Delta X_{\text{дол.хон}}$, $\Delta X_{\text{хон}}$) хэмжээсийг тооцон тэдгээрийн ирээдүйд ажиллах горимыг тооцох боломжтой болж байна. Мөн зах зээлийн шалгуур болох хамгийн бага өөрийн өртөгтэй эх үүсвэрийн ажиллах горимыг харуулж, жилийн ачааллын горимд ажиллах эх үүсвэрүүдийн оролцоог тодорхойлсноор эрчим хүчний системийн хувьд эдийн засгийн үзүүлэлт сайтай станцуудыг ажиллуулах боломж гарч байна [11, 12].

6. Үндсэн үр дүн

Хэрэв S систем нь S_i системээс бүрдэх бол нийт оновчтой зардал S_i нь S системийн оновчтой зардлаас их байна (томъёо 1) өөрөөр хэлбэл бүтээгдэхүүний тогтолцооны үр ашиг дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\Delta \phi = \frac{\sum_i^n 3_{\text{оновч}}(S_i) - 3_{\text{оновч}} \sum_i^n (S_i)}{3_{\text{оновч}} \sum_i^n (S_i)}. \quad (12)$$

Үр ашгийн үнэлгээг хийхийн тулд Төвийн бүсийн нэгдсэн систем (ТБНС)-д ажиллаж байгаа эх үүсвэрийн чадлыг тооцооны үндсэн өгөгдөл болгон ашигласан бөгөөд тухайн жилийн цахилгааны үйлдвэрлэл, хувьсах болон тогтмол зардлын хэмжээг (хүснэгт 4) харуулж байна [13].

Хүснэгт 4

ТБНС- ийн техник эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	ДЦС 2	ДЦС 3	ДЦС 4	ДДЦС	ЭДЦС	Импорт	Нийт
Боломжит чадал	МВт	20	116	522	46	28	250	962
Жилийн үйлдвэрлэл	сая кВт.ц	117	691	3524	261	154	315	5062
Тогтмол зардал	сая төг.	7287	40582	75887	14914	12641	187004	338315
Хувьсах зардал	сая төг.	5042	30721	81043	11103	11123	15822	154853
Нийт зардал	сая төг.	12329	71302	156929	26017	23764	202827	493168

Хүснэгт 5


Эх үүсвэрүүдийн бүтээгдэхүүний нэгж зардал,
оновчтой ачааллын хэмжээ

Эх үүсвэр	Нэгж зардал				Станцуудын оновчтой ачаалал				
	$C_{\text{дун}}$	$C_{\text{ул}}$	$C_{\text{дол.хон}}$	$C_{\text{хон}}$	$X_{\text{дун}}$	$\Delta X_{\text{ул}}$	$\Delta X_{\text{дол.хон}}$	$\Delta X_{\text{хон}}$	ΣX
Дулааны цахилгаан станц 2	82	39	39	39	9,5	9,5	0	0	19
Дулааны цахилгаан станц 3	78	34	34	34	58	0	0	58	116
Дулааны цахилгаан станц 4	38	15	15	15	383	132	7	0	522
Дархан дулааны цахилгаан станц	78	35	35	35	22	13	0	10	45
Эрдэнэт дулааны цахилгаан станц	122	50	50	50	14	14	0	0	28
Импорт	136	85	85	85	91	0	0	91	181
Нийт			-		579	169	7	159	911

Хүснэгт 5 - 3-р багананд санал болгож байгаа бүтээгдэхүүний тогтолцоог ашиглан ТБНС-ийн эх үүсвэрийн оновчтой ачааллын хэмжээг тооход бодит зардал 16,9 хувиар буурч байна. Дээрх бүтээгдэхүүний тогтолцоог оновчтой /боломжтой/ гэдгийг харуулахын тулд сектор тус бүрийн бүтээгдэхүүнийг өөр хоорондоо хамааралгүй байдлаар оновчлол хийхэд гарах зардлын өөрчлөлтийн хувийг зураг 2-т үзүүлэв. Зурагаас харахад хэрэглэгчийн хэрэглээг жилийн хугацаанд оновчтой бага зардлаар хангах боломжийг санал болгож буй бүтээгдэхүүний тогтолцоо бүрдүүлж байна.

Зураг 2

Бүтээгдэхүүний тогтолцооны үр ашиг (хувиар)



7. Дүгнэлт

Тус салбарын шинэчлэл нь улс бүрийн онцлогт тохирсон зах зээлийн бүтцийг ашиглаж байгаа боловч үндсэн зорилго нь ЭХ-ний системийг үр ашигтай ажиллуулах зарчим дээр тулгуурлаж байна.

Санал болгож байгаа бүтээгдэхүүний тогтолцоо нь кВт-р хэмжигдэх бөгөөд энэ нь системийн удирлагын үйл ажиллагааг хялбарчлан, арилжааны үе шатыг багасгах юм. Жилийн өмнө хэрэглэгчид нэг худалдан авагчийн загварт өөрийн хэрэгцээт чадлын хэмжээг захиалах ба бодит хэмжээнээс гарах чадлын зөрүүг тэнцвэржүүлэгч зах зээлийг ашиглан арилжаална. Энэ жилийн өмнөх ЦЭХ-ний зах зээл үүссэнээр зах зээлд оролцогчдыг тэнцвэртэй мэдээллээр тэгш хангах боломж бүрдэнэ.

Дээрх тооцооноос харахад санал болгож буй бүтээгдэхүүний тогтолцоог ашигласнаар ЦЭХ үйлдвэрлэх зардал 16,9 хувиар буурч, системийн үр ашиг нэмэгдэх бөгөөд ТБНС-д шат дараалсан өөрчлөлтийг хийсний дараа ашиглах боломжтой юм.

Ном зүй:

- [1] Батхуяг, С., Гантогоо, Ё. (2018). Эрчим хүчний аюулгүй байдлын судалгаа», *Эдийн засаг*, № 1/59, 27–31 хууд,
- [2] Эрчим хүчний зохицуулах хороо <http://erc.gov.mn/index.php?newsid=32J>.
- [3] Electricity market reform. (2006). An international perspective / Ed. by F.P. Sioshansi, W. Pfaffenberger. – Elsevier, 656 p K. Elissa, “Title of paper if known,” unpublished.
- [4] Investment incentives for the SE Europe regional electricity market. – London: NERA, 2005, Vol. 2, 48 p.
- [5] Amelin M., Söder L., Taking Credit // IEEE Power and Energy Magazine. Vol. 8. 2010, # 5, P.47-52.
- [6] Moreno R., Barroso L.A., Rudnick H., Mocarquer S., Bezerra B., (2010). Auction approaches of long-term contracts to ensure generation investment in electricity markets: Lessons from the Brazilian and Chilean experiences // *Energy Policy*. Vol.38., # 10, P. 5758-5769
- [7] Постановление Правительства РФ № 529 от 29 августа 2006 г. „О совершенствовании порядка функционирования оптового рынка электроэнергии (мощности)“
- [8] Newberry D., (2007). What are the issues in mergers and acquisitions arising from electricity market restructuring? EUI WP 2007/1. – Florence: EUI RSCAS, 20 p.
- [9] Подковальников С.В., Хамисов О.В., (2011) Несовершенные электроэнергетические рынки: моделирование и исследование развития генерирующих мощностей // *Известия РАН. Энергетика.*, № 2, С.66-86.
- [10] Tishler A., Newman J., Spekterman I., Woo C.K., (2006). Cost-benefit analysis of reforming Israel’s electricity industry // *Energy policy*. Vol. 34., # 16, P.2442-2454.
- [11] Бат-Очир Батзаяа., (2015). К выбору продукции на рынке // *Производственный менеджмент: теория, методология, практика: сб. материалов 2 междунар. науч.-практ. конф.*, Новосибирск, 15 мая 2015 г. – Новосибирск: Изд-во НГТУ,– С. 218-223. – 0,18 п.л.
- [12] Bat-Ochir Batzaya., (2016). Method of defining the operational regime of power plants under market conditions // *Proceedings of the 11th international forum on strategic technology 2016 (IFOST 2016)*. – Novosibirsk, Russia. – P. 230-234. – 0,23 п.л.
- [13] Батзаяа Б., Ш.Даваахүү Ш. (2017) Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх боломж. ЭХЯ, ШУТИСЭХС “Эрчим хүчний хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, - Улаанбаатар.